

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА

2024 оны 8 дугаар сарын 19-ний өдөр, Даваа гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 11
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	11 - 75
1.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай/</i>	12 - 25
2.	<i>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	25 - 72
3.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай, <b>үргэлжлэл</b>/</i>	72 - 75

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы  
Төсвийн байнгын хорооны 8 дугаар сарын 19-ний өдөр  
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 36 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Ганбаатар, Б.Мөнхсоёл, Г.Тэмүүлэн;  
Тасалсан: Д.Батлут, Х.Болормаа, Х.Булгантуяа, З.Мэндсайхан.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай, үргэлжлэл/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Ж.Баясгалан, Г.Дамдинням, Д.Пүрэвдаваа, Р.Батболд, Б.Энхбаяр, Н.Алтанхуяг нар үг хэлэв.

**Ц.Даваасүрэн:** Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 9  
Бүгд: 16  
43.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 8  
Бүгд: 16  
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Байнгын хорооны хуралдааныг түр завсарлуулав. /11.10/

Байнгын хорооны хуралдаан 11 цаг 40 минутаас үргэлжлэв.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргад нэр дэвшигч Дав.Цогтбаатарыг санал хураалтаар дэмжээгүй тул Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшинг санал болгосныг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ц.Даваасүрэн:** Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшинг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 10  
Бүгд: 17  
41.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн:** Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшинг сонгохыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 9  
Бүгд: 17  
47.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал төхөөрөмжөөр санал хураах боломжгүй байгаа тул саналыг хураалтыг гар өргөж явуулья гэсэн горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	10
Бүгд:	17
41.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй. /11.51/	

*Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга А.Даваажаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын багийн ахлах хянан шалгагч Б.Анар, Т.Нармандах, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын зөвлөх Д.Мөнхбат, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Н.Мандуул, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч Л.Хосбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Нийслэлийн Засаг даргын Улаанбаатар хотын Захирагчийн Төр, хувийн хэвшлийн түншлэл, төсөл хөтөлбөр хариуцсан зөвлөх Н.Баярчимэг, Нийслэлийн Засаг даргын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын зөвлөх Б.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, П.Ганзориг, Г.Дамдинням, Х.Ганхуяг, Б.Энхбаяр, Ж.Батжаргал, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Энхбаяр, Л.Гантөмөр, Г.Уянгахишиг, Б.Түвшин, П.Сайнзориг, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

**Ц.Даваасүрэн:** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдэд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан үндэслэлээр хууль зүйн дүгнэлт гаргуулах Төсвийн байнгын хорооны саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн тавьсан асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	8
Бүгд:	18

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

*Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** 1.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	10
Бүгд:	18

44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн:** Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн:** 2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Чойжилсүрэн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн:** 3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 10  
Бүгд: 18

44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

---

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Чойжилсүрэн, Б.Түвшин нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Чойжилсүрэн, Б.Түвшин нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн: 4.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн: 5.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн: 6.**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.



Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн: 7.**Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн: 8.**Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн: 9.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн: 10.**Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Чойжилсүрэн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн: 11.**Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн: 12.**Засгийн газар дахь Хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн: 13.**Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн: 14.**“Төрийн өмчийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Чойжилсүрэн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн: 15.**“Төрийн захиргааны байгууллын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Дав.Цогтбаатар нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.*

*Байнгын хорооны тогтоолын төсөл /Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай/-ийг үргэлжлүүлэн хэлэлцэв.*

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшинг сонгохыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 47.1 хувийн саналаар дэмжээгүй бөгөөд уг саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар санал хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Даваасүрэн:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн:** Зарлагын хяналтын дэд хорооны даргаар Банзрагчийн Түвшинг сонгох саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 9

Бүгд: 18

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргад нэр дэвшигч Б.Түвшинг санал хураалтаар дэмжээгүй тул Улсын Их Хурал дахь

Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярыг санал болгосныг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ц.Даваасүрэн:** Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаярыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Ц.Даваасүрэн:** “Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.1 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 14 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 3 цаг 39 минут үргэлжилж, 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 45 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 8 дугаар сарын 19-ний өдөр, Даваа гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
10 цаг 36 минут

### ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

#### Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай,  
үргэлжлэл/

**Ц.Даваасүрэн:** Ирц хүрч байна шүү гишүүд ээ.

Зарлагын хяналтын дэд хороонд нэр дэвшсэн хүн нь орж ирсэн байгаа юу? Дав.Цогтбаатар.

Хуралдаан үргэлжилнэ. /алх цохив/

Өнгөрсөн хуралдаанаар бид Зарлагын хяналтын хорооны дэд даргыг сонгох санал хураалт явуулаад зогссон байгаа.

Санал хураалтын тоон дээр маргаан үүссэн байсан. Маргааныг хянасан. Нотлогдож байгаа юм билээ шүү. Нотлогдох нь нотлогдож байгаа юм билээ.

Тэр талаар Тамгын газраас тайлбар өгчих хүмүүс байна уу? Хянасан.

Тэгвэл ингэе. Түрүүний санал хураалтыг хүчингүй болгоё гэдэг горимын санал гарвал гаргаад. Тэгээд дахиад явъя. Гаргачих. Маргаантай байгаа учраас гээд.

Т.Аубакир гишүүн. Т.Аубакир гишүүний микрофоныг өгье.

**Т.Аубакир:** Баярлалаа. Үүний өмнөх долоо хоногийн Төсвийн байнгын хорооны хуралдаан дээр Зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгосон саналыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулж өгөөч гэсэн горимын санал гаргаж байна.

**Ц.Даваасүрэн:** Үүний өмнөх хуралдаанаар Зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгохдоо гар өргөх санал хураалт явуулсан дээр маргаан үүссэн байна.

Тийм учраас Т.Аубакир гишүүн болохоор маргаантай учраас энэ саналыг дахин явуулъя гэж байгаа юм байна.

Тэгвэл энэ горимын саналыг дэмжиж байгаа гишүүд саналаа өгье. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Эхлээд нэг туршилтын санал хураалт явуулчихъя. Туршилтын санал хураалт. /алх цохив/

Энэ туршилтын санал хураалт болж байна.

Тэгэхээр одоо санал хураалтаа явуулъя.

Т.Аубакир гишүүний гаргасан горимын саналын дагуу Зарлагын хяналтын дэд хорооны даргыг гар өргөсөн санал явуулсан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллийг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү. /алх цохив/

Санал дэмжигдсэн тул санал хураалт явуулна.

Нөгөө нэр дэвшсэн хүн маань орж ирсэн үү? Дав.Цогтбаатар биз дээ.

Л.Гантөмөр дарга аа, танай энэ улсууд чинь яагаад орж ирэхгүй байгаад байна.

Өөрсдөө нэрээ ирүүлчхээд. Бүлгийн хурал зарлаагүй юм байна лээ шүү дээ.

Хуулийн заалтыг нь би та нарт дахиад уншиж өгье. Нэр дэвшигч орж иртэл.

27.10.Монгол Улсын Их Хурлын дэгийн тухай хууль дээр дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхын саналаар сонгоно гэж байгаа юм.

Төсвийн зарлагын хяналтын хорооны дэд даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс. Хэрэв цөөнхийн бүлэг байхгүй, гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгоно гэж байгаа юм.

Тэгэхээр одоо та нарын маргалдаад байгаа нь болохоор цөөнхийн бүлгийг Ардчилсан намын бүлэг биш ээ гэж зарим нь үзээд байх шиг байна.

Тэгэхээр үүнийг одоо биш ээ гэж үзсэн юм хуулиар байхгүй байгаа байхгүй юу.

Тийм учраас цөөнхийн бүлэгтэй Ардчилсан намын гишүүдээс Зарлагын хяналтын хорооны дэд даргад Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатарыг томилно уу гэдэг, томилж өгнө үү гэсэн хүсэлтийг бүлгийн дарга О.Цогтгэрэлээс ирүүлсэн байгаа юм.

Заавал цөөнхийн бүлгээс байх ёстой болчихоод байхгүй юу даа.

Т.Аубакир гишүүн.

**Т.Аубакир:** Энэ Зарлагын хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн бүлгээс нэр дэвшүүлж орж ирсэн байна л даа.

Тэгээд яг өнөөдрийн үүсчихсэн нөхцөл байдал Ардчилсан нам парламент доторх цөөнх боловч засагт хамтарчихсан, төсвийг захиран зарцуулах эрхийг зарим сайдууд авчихсан байж байдаг.

Яг Ардчилсан нам дотроосоо Зарлагын хяналтын дэд хорооныхоо даргыг томилоод явах нь өөрөө энэ Үндсэн хуулийн зарчим, энэ хуулийн концепц өөрөө зөрчигдөж байна гэж үзэж байгаа юм.

Олонхдоо хяналт тавих л үндсэн чиг үүрэгтэй л ийм дэд хороо шүү дээ.

Тэгээд өөрсдөө захиран зарцуулаад байдаг. Тэгээд яг тэр захиран

зарцуулж байгаа энэ засгийн. Одоо энэ чинь зөвхөн улсын төсөв биш, аймгийн, орон нутгийн төсөвт хүртэл хяналт тавих ёстой ийм дэд хороо шүү дээ.

Тийм учраас бидний хувьд Ардчилсан намаас хүн санал болгоод тэрийг сонгох нь өөрөө энэ хуулийг агуулгаар нь үндсэндээ бүтэн зөрчиж байгаа юм.

Энэ Байнгын хороонд цөөнхүүд бас байж байгаа. ХҮН намын төлөөлөл байна. Биш ээ. Ногоон нам байна. Тийм ээ.

Цөөнхүүд байгаа учраас тэд нараасаа даргаа сонгоод явбал яасан юм бэ гэсэн.

Хэдүүлээ нэгэнт хамтарчихсан. Зориг гаргаад хамтарч байгаа юм чинь бас энэ дээрээ ч зоригтой л бай байя.

Тэгэхгүй нэг гараараа зарлагдаад, нөгөө гараараа хяналт тавина гээд Л.Гантөмөр дарга аа. Та бүхэн зарчимтай байя аа л гэж энэ засагт орж ирсэн бол энэ дээр хэдүүлээ шударга л байя. Тийм ээ.

Тийм учраас О.Цогтгэрэл даргын оруулж ирсэн энэ хүнийг дэмжих боломжгүй байна.

Одоо тэр бүр нөгөө цөөнхүүдээсээ даргаа тавивал яасан юм бэ гэсэн ийм горимын санал гаргаж байна.

**Ц.Даваасүрэн:** Тэгэхдээ би Та бүхэнд хууль уншиж сонгосон.

Цөөнхийн бүлгийн гишүүдээс Зарлагын хяналтын дэд хорооны даргыг томилно гэж байгаа юм л даа.

Тэгэхээр цөөнхийн бүлэг байгаа юу л гэдэг асуудал. Байгаа байхгүй юу.

Тэгэхээр хуулийг би зөрчиж болохгүй болчихоод байна.

Горимын саналаар үг хэлж байна. Тэгэхдээ дэмий хууль зөрчсөн юугаар яриад яах вэ дээ. Цаг цаг алдахын нэмэр шүү дээ.

Горимын саналтай холбогдуулж үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя.

Т.Аубакир гишүүнээр тасаллаа. Б.Батбаяр гишүүнийг оруулчихъя. Горимын саналтай холбогдуулж үг хэлж байгаа юм. Бүгдээрээ орох юм уу? Б.Энхбаяр гишүүн, Р.Батболд гишүүн. Б.Түвшин гишүүн үг хэлье.

**Б.Түвшин:** Ер нь хууль дээр байж байгаа үг, заалтаас зөрөх юм бол бид хууль зөрчсөн болчих гээд байгаа юм.

Хоёрдугаарт, засагт хамтрах Их Хурлын бүлэг гэдэг хоёр чинь хоёр тусдаа байгууллага.

Хуулийн этгээдийн хувьд ч. Нэг нь хууль тогтоох. Нөгөөдөх нь гүйцэтгэх эрх мэдэл бүхий байгууллагууд учраас энэ харилцаа засаг дээр хамтарсантай хамаагүй.

Ардчилсан намын бүлэг байсаар байгаа учраас хууль дээр заасан үүргээ яг тэр заалтаар биелүүлэхгүй бол бид дараа нь хуулийн зөрчилд орно.

**Ц.Даваасүрэн:** Б.Түвшин гишүүний хэлээд байгаа дээр үндэслэл байгаа. Яагаад гэвэл Их Хурлын тухай хуулийн 27.10 дээр “цөөнхийн бүлгийн гишүүдээс” гэгчихсэн байхгүй юу.

Тийм учраас ингээд л яриад байх хэрэг байгаа юм уу. Уг нь яах вэ яг агуулга талаас нь авч үзэх юм бол бүр та нарын яриад байгаагаар яг одоо бүр агуулга талаасаа хэрвээ сонгодог утгаараа байна гэх юм бол энэ Зарлагын хяналтын хорооны дийлэнх олонх цөөнх байх ёстой шүү. Тэгвэл тэгж өөрчлөлтөө хийсний дараа ярих ёстой байхгүй юу.

Хууль дээрээ өөрчлөөгүй байж агуулга талаас нь яриад байж болохгүй шүү дээ. Яг агуулгаараа харах юм бол олонхын бүлэг нь Зарлагын хяналтын дэд хороонд олонх байж болохгүй шүү дээ. Хэрвээ хяналт тавих гэж байгаа бол. Энэ чинь санал хураалтаар л шийднэ шүү дээ.

Тэгэхээр яг агуулга талаасаа харах юм бол бүр энэ чинь орвонгоороо эргэх тухай асуудал. Тэгвэл хуулийн өөрчлөлт яригдах ёстой.

Ж.Баясгалан гишүүн.

**Ж.Баясгалан:** Бид чинь хууль тогтоож, хуулиа хамгийн дээдээр дээдлэх ёстой хүмүүс юм чинь хуульд заасан заалтаараа л явъя.

Хуульд агуулга гэж байхгүй байгаа шүү дээ. Хууль дээр тэртээ тэргүй цагаан дээр хараар биччихсэн байгаа энэ хуулийн заалтыгаа яг баримтлаад явах нь зөв байх.

Тийм болохоор Ардчилсан намын бүлгээс одоо энэ цөөнхийн бүлэг гэдэг маань өөрөө яг хууль дээрээ байгаа юм чинь үүгээрээ явсан нь дээрээ гэж үзэж байна.

Тэгээд нийлээд ингээд зөрчөөд байж болохгүй шүү дээ гэж түрүүн ярьж байна. Үгүй ээ, тэгвэл нийлээд хуулиа зөрчөөд байж болохгүй. Агуулгаа зөрчиж

болж байгаа шигээ хуулиа бас зөрчиж болохгүй. Хуулиа л бариад явсан нь дээр байх.

**Ц.Даваасүрэн:** Г.Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Төсвийн зарлагын дэд хорооны дарга гэдэг яагаад цөөнхийн бүлгээс, эсвэл цөөнхөөс тавигддаг вэ гэвэл гүйцэтгэх засаглалын зардалд хяналт тавьдаг хамгийн том Их Хурлын бүтцийн байгууллага байгаа юм.

Улсын Их Хурлын дэгийн тухай хууль тэгээд ер нь ингээд Улсын Их Хуралд чинь өөрт нь эрх хэмжээ нь хууль батлах, хуулийн хэрэгжилтийг хянах, ингээд эрх, үүргүүд явж байгаа шүү дээ.

Тэгэхээр өөрөөр хэлбэл бид өнөөдөр энэ шинэ Үндсэн хууль баталснаас, тэгээд түүнээс гарч байгаа үр дүнгээс хамаараад бид бас дахиад эрх зүйн зохицуулалтуудыг тодорхой болгох зайлшгүй шаардлага гарч ирчхээд байгаа юм.

Түүнээс хууль зөрчих гээд байгаа энэ тэр алга байна. Ж.Баясгалан гишүүн ээ.

Гол асуудал нь юу вэ гэхээр улсын төсөв татвар төлөгчдийн мөнгийг зарцуулдаг эрх хэмжээтэй намын бүлгийн төлөөллүүд өөрөө өөрийгөө хянаж болохгүй ээ гэдэг логик байхгүй юу. Логик нь ерөөсөө энэ. Уг нь бол.

Монгол Улсын Үндсэн хуулиар “олонх нь засгаа бариад, цөөнх нь хяналтаа тавина” гэдэг. Яг бид нарын амьд гар дээрээ барих ёстой үндсэн эх бол Үндсэн хууль. Үндсэн хууль дээр яг ингээд заачихсан байгаа.



Энэ хуулийн заалт нь өөрөө ингэж орж ирж байгаа юм.

Тэгэхээр бид нарын яриад байгаа асуудал бол ийм л юм яриад байгаа байхгүй юу. Одоо хэрвээ ХҮН нам бүлэгтэй байсан бол, одоо энэ Ногоон нам бүлэгтэй байсан бол, Эвсэл бүлэгтэй байсан бол ингээд 4 бүлэг цөөнх байгаад байна шүү дээ. 4 бүлэг цөөнх байх юм бол хэнээс нь сонгох юм.

Бид хуулиа тодорхой болгох ёстой. Тийм байгаа биз.

Хоёрдугаарт, одоо засагт хамтраад орчихсон. Мөнгө зарж байгаа. Татварын мөнгө зарах эрхтэй сайд нартай. Засаг дээр.

Дээр нь Их Хурлын бүтэц дээрээ хамтарчихсан. Байнгын хороодоо хуваагаад авцгаачихсан.

Ийм тохироотой байгаа нөхцөлд Төсвийн зарлагын дэд хороо гэдэг маш чухал байгууллага. Төсвийн зарлагын дэд хорооны дарга, бүрэлдэхүүн бол энэ эрх барьж байгаа олонхын энэ олуулаа болж байгаа зуун хэдэн хүний шийдэл. Түүн дээр гарч байгаа зардал дээр хяналт тавьж байх эрх хэмжээтэй байгууллага байхгүй юу.

Төсвийн зарлагын дэд хороо бол улсын төсөв, аймаг, орон нутгийн төсвийг хүртэл хянадаг эрх хэмжээтэй байгууллага шүү дээ.

Тэгэхээр бидний хэсэг гишүүд юу гэж яриад байгаа вэ гэхээр бүр харин ч та нар нэг юмыг ойлгох ёстой. Эрх баригч намын гишүүд зоригтой өөрчлөлтөө хийгээд Үндсэн хуулийнхаа өөрчлөлтийг улам хэрэгжүүлээд, тодорхой болгоод, нэг бол хууль, эрх зүйн орчноо тодорхой

болгоод жинхэнэ одоо бүр яг энэ засагт байхгүй байгаа хэсэг нь энэ төсөвтөө хяналт тавиад яваач ээ гэдэг санаачилга гаргаад байгааг та нар бас харах ёстой шүү дээ.

Үнэхээр л бид шинэ 30 жилдээ ороод, үнэхээр л бас шударга зарчимтай явъя гэж байгаа бол Үндсэн хуулийнхаа энэ зарчим руу явъя.

Олуулаа нийлээд засаг барьж байгаа бол, мөнгөө зарж байгаа бол, татварын мөнгийг үрж байгаа бол, хэрэгжүүлж байгаа бол энэ нь үнэтэй байна уу, бага байна уу, хулгай хийж байна уу, үгүй юу, бүгдийг нь хянадаг энэ эрх хэмжээтэй байгууллагаа бүр яг жинхэнэ энд ороогүй байгаа хэсгээсээ томилъё гэдэг энэ л саналыг бид яриад байгаа шүү дээ.

Тэгэхээр Ардчилсан намын бүлэг буюу манай энэ их том бүдүүн бүлэг зуун хэдийн бүлэг болчхов доо. Энэ чинь.

Одоо манай нам дээр нэмэх нь Ардчилсан нам, ХҮН нам.

Үүнээсээ гадуур хүнийг томилчихъё. Тэгвэл шударга болох гээд байна аа л гээд байгаа байхгүй юу.

Орж ирсэн хүнийг нь бол дэмжих боломжгүй л байгаад байна л даа. Хүндээ биш шүү. Зарчим нь болохгүй байгаад байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Үгүй ээ, үгүй. Зарчим, агуулга гээд ингээд харвал би түрүүн хэлсэн шүү дээ. Яг үнэхээр зарчим, агуулгаараа харах юм бол Зарлагын хяналтын дэд хороо цөөнхөөс олонх нь бүрдэх ёстой. Яг одоо өөрийн чинь яриад байгаагаар бол.

Тэгэхдээ хууль дээр ийм юм алга. Хууль дээр одоо жишээлбэл зохицуулагдаагүй юмнууд байгаад байна.

Яг өнөөдөр хууль дээр бичсэнээрээ бид явахгүй бол агуулга тийм, зарчим тийм гэж явж болохгүй байгаад байна.

Уг нь Үндсэн хуулийн агуулга тийм л дээ. Олонх нь засгаа бариад л, цөөнх нь хянаад явах ёстой. Цөөнх нь орчихсон.

Цөөнхийн бүлэг байна уу. Байна. Гэтэл хууль дээр цөөнхийн бүлгээс зарлагын хяналтын дэд хороог тавь гэсэн.

Өмнө нь хамтарч байсан тохиолдлууд бий. Одоо Н.Алтанхуяг гишүүн ч байж л байна. Н.Алтанхуяг гишүүнийг Ерөнхий сайд байх үед Зарлагын хяналтын дэд хорооны дарга Ж.Эрдэнэбат байсан санагдаж байна.

Ингээд хамтарч байгаа улсуудаасаа тавиад яваад байсан байгаа байхгүй юу.

Тийм учраас хуулийн зохицуулалт хийхгүй бол наадах чинь болохгүй.

Тэгэхдээ чиний хэлээд байгаад яг үнэн байгаа юм. Одоо энэ 4, 5 нам бүгдээрээ бүлэгтэй байсан бол хамгийн бага гишүүдтэйгээс нь гэх үү. Энэ чинь аягүй эвгүй. Ер нь хуулийн зохицуулалт байхгүй юм байна.

Гэхдээ хууль дээр юу гээд хэлчихсэн байна гэвэл цөөнхийн бүлгээс гэхсэн учраас одоо бүлэгтэй байгаагаас л оруулахаас өөр ямар ч арга бол байхгүй.

Д.Пүрэвдаваа гишүүн.

**Д.Пүрэвдаваа:** Өглөөний мэнд.

Г.Дамдинням гишүүнтэй ер нь ярих зүйл давхацлаа.

Тэгээд энэ Үндэсний эвсэл болон Ногоон намаас сонгогдсон төлөөллийг санал хураалтад оролцуулах боломжоор хангаач ээ гэж хуралдаан даргалагчаас одоо хүсэх байна.

Үнэхээр бид энэ зарчим дээрээ байгаад санал хураалтаар асуудлаа шийдэж болдоггүй юм уу? Хяналт тавина гэж байгаа бол одоо бүлгээс нь сайдтай нөхдүүд яаж хяналтаа тавих юм. Тэрийг та бүгд бас бодох хэрэгтэй байх аа л гэж бодож байна. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Цөөнхийн бүлгийн гишүүдээс гэсэн учраас болохгүй байгаад байгаа юм.

Т.Аубакир гишүүн. Р.Батболд гишүүн.

**Р.Батболд:** Тэгэхээр Төсвийн зардлын хяналтын дэд хорооны даргын талаар яригдаад байдаг.

Одоо яг Ардчилсан намыг цөөнхийн бүлэг гэж яг энэ дотор үзэх юм уу, үзэхгүй юм уу гэдэг нэг асуудал гараад байгаа юм.

Та нар чинь 3 нам нийлээд засгаа байгуулчихсан. Нийлээд нэг үйл ажиллагааны хөтөлбөрөө оруулаад ирчихсэн. Ингээд бүгдээрээ эрх баригч нар болчихсон байгаа шүү дээ. Үүнийг яг юу гэж ойлгох юм бэ?

Тэгэхээр цөөнх нь хэн юм гэдэг бас нэг асуудал гараад байна шүү дээ. Гурвуулаа адилхан засаг бариад байдаг,

гурвуулаа адилхан сайдтай, гурвуулаа төсөв захиран зарцуулаад байдаг. Тэгсэн мөртөө үүнийгээ өөрсдөө хянана гэж яриад байх юм. Энэ яг ямар учиртай юм.

Би бол цөөнхөөсөө тавиач ээ гэдэг дээр. Манайх бол Иргэний Зориг ногоон нам бүлэг байгуулах хэмжээнд очоогүй ч гэсэн энэ Их Хурал дотроо цөөнх шүү дээ. Үүнийг яг юу гэж ойлгох юм.

Тэгээд би бол одоо энэ Төсвийн зардлын хяналтын дэд хорооны даргаар нэрээ дэвшүүлье гээд даргад бичиг хүргэсэн. Очсон уу, очоогүй юу мэдэхгүй байна.

Тэгэхээр үүнийг нэг тийш нь болгосон нь дээр байх. Бүр болохгүй бол хууль санаачлаад явах юм уу, яах юм. Тийм.

**Ц.Даваасүрэн:** Тэгэхээр Р.Батболд гишүүн ээ, Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлээр цөөнх, олонхыг бүр тодорхой заагаад өгчихсөн байхгүй юу.

64-өөс дээш суудал авчихсан бол олонх байна аа л гэхихсэн байхгүй юу. Тэгээд олонх нь гараад л ирчихсэн юм чинь.

Тийм учраас цөөнх нь тодорхой. Бас хуулиараа ингээд заагаад өгчихсөн байна. Тэр цөөнхийн бүлэг байгаа тохиолдолд бид агуулга тийм ээ гээд бүлэггүй байгаа намуудын төлөөллөөс зохицуулна гэсэн юм байхгүй байгаа юм.

10.2 дээр юу гэсэн гэхээр аль ч нам, эвсэл олонх болоогүй бол гэж байгаа юм. Аль ч нам, эвсэл олонх болоогүй бол.

Хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж.

Зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу олонхыг бүрдүүлнэ гэж байгаа байхгүй юу.

Өөр зохицуулалт байхгүй. Энэ хуулийн 10.1, 10.2-т зааснаас бусад Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг, гишүүнийг цөөнх гэнэ ээ.

Тэгэхээр цөөнхийн бүлэг байгаа. Цөөнхийн гишүүн байгаа. Цөөнхийн бүлэг, гишүүнийг хүртэл ялгаад өгчихсөн байгаа байхгүй юу. Цөөнхийн гишүүн, цөөнхийн бүлэг гээд.

Тэгэхээр цөөнхийн бүлэг гэдэг нь Ардчилсан намынх гээд яг энэ 10.3-аараа тодорхой.

Тэгэхээр нэгэнт хууль дээр цөөнхийн бүлгийн гишүүдээс гэхихсэн юмыг яагаад ч зөрчих арга байхгүй болчхоод байгаа байхгүй юу.

Б.Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Би Төсвийн байнгын хорооны гишүүн биш.

Энэ дагасан хууль хоёр дахь асуудал дээр асуулт асуух гэж орж ирж байгаад энэ асуудал дээр бас нэг үг хэлчихье ээ гэж бодож байна.

Энэ асуулт асууж, үг хэлж байгаа бүх гишүүдийн зөв байгаад байгаа юм. Буруу юм ерөөсөө яриагүй. Аль ч тал нь.

Яагаад гэхээр цөөнх гэж байгаа Үндсэн хуульд заасан этгээд маань өөрөө Засгийн газрыг бүрдүүлчихсэн. Олонх болчхоод байгаа юм. Олонхын нэг хэсэг болчхоод байгаа юм.

Хэрвээ бид яг цөөнхийн бүлгээс тавихгүй бол хууль зөрчих гээд байна. Дэгийн хууль зөрчих гээд байна гэж ярих юм бол цөөнх нь өөрөө засагт орсон өөрөө Үндсэн хуулийн зарчим руу ороод явчихна.

Анхнаасаа нөгөө зарчим эвдэгдчихээр дараагийн юмнууд чинь бүгд зарчим эвдэгдсэн юмнаас ийм гинжин урвал гараад байгаа байхгүй юу.

Тэгээд би 16 жилийн өмнө манай Б.Чимид багшийн өгсөн ярилцлагыг би хараад байж байна л даа.

Б.Чимид Засгийн газрыг байгуулахдаа Ард түмний хийсэн сонголтыг баримтлах ёстой.

Энд асуултад хариулахдаа ингэж хэлсэн байгаа. Би яг үг, өгүүлбэрийг нь уншихъя.

Ард түмэн аль намд хэдэн хувийн санал өгснөөс хамаарч ямар бүрэлдэхүүнтэй Засгийн газар байгуулахыг Улсын Их Хурал шийдвэрлэх эрх зүйн үндсийг Үндсэн хууль тодорхойлсон. Үүнийг яаж хэрэгжүүлэхийг Улсын Их Хурлын тухай болон дэгийн хуулиар тодруулдаг. Энэ бүхний цаана Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаан гэж хуулийн заалтыг оношилж тайлбарладаг мэдлэгийн тогтолцоо бий.

Ер нь тогтолцоотсон мэдлэгийг шинжлэх ухаан гэдэг. Ард түмэн ямар сонголт хийснийг Засгийн газар байгуулахад баримтална гэсэн ийм ярилцлага байгаа юм.

Тэр утгаараа жишээлбэл Ардчилсан намын бүлгийн төлөөллийг

цөөнх гэж үзээд төсвөө хянах тэр зарлагын хяналтын хороог даргаар тавих гэвэл жишээлбэл энэ өөрөө практик дээр сонирхлын зөрчил үүсгэнэ.

Энэ удаагийн төсөв 120 их наяд буюу 40 тэрбум долларын төсөл, хөтөлбөр бүтээн байгуулалт хэрэгжүүлэх гэж байгаа төсөв байгаа.

Үүнийг Л.Гантөмөр сайд буюу Ардчилсан намын дарга эрхэлж хэрэгжүүлэх гэж байгаа.

Хоёрдугаарт, тэгвэл ХҮН намын төлөөллийг оруулъя. Энэ төсвийг дагасан хуулийн тендерийн хуулийн 49.10-д бүх төрийн өмчийн компаниудын 10 тэрбумаас дээш худалдан авалтыг Т.Доржханд сайд хэрэгжүүлэх гэж байгаа. Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгой гэсэн их наядаар хэрэгжих худалдан авалтуудын тендерийг жишээлбэл ХҮН намын дарга зохион байгуулна.

Ардчилсан намын даргын хэрэгжүүлсэн тэр 40 тэрбум долларын төсвийг Ардчилсан намын гишүүн хянана гэж байхгүй. ХҮН намын даргын хэрэгжүүлж байгаа 15 тэрбум долларын худалдан авалтыг ХҮН намын төлөөлөл хянана гэж бас байж болохгүй. Улс төрийн хувьд ярьж байгаа шүү.

Тийм учраас үүнийг дэгийн хуулиар тодорхой болгож хийхгүйгээр энэ нь өөрөө улс төрийн хувьд асуудал үүсгэнэ.

Тийм учраас цаашдаа анхнаасаа Үндсэн хуулиа нулиад явчихсан учраас ийм асуудал гараад байгаа юм. Цөөнх нь угаасаа нөгөө засагт ордог Үндсэн хуульгүй шүү дээ. Бид нар. Тэр Үндсэн хуулиа давчихаар цөөнхөөс хянах ёстой,

хянах ёсгүй гэдэг энэ асуудал чинь хууль зүйн хувьд гараад байгаа юм.

Тийм учраас бид энэ Үндсэн хуулийнхаа хүрээ рамд нийцүүлж цаашдаа дэгийн хуулийг боловсронгуй болгох ёстой. Жишээлбэл, Үндсэн хуулиа нулиад хамтарчихвал төсвийн хяналтыг нь хэн хийх юм бэ гэдгээ. Жишээлбэл одоо Д.Пүрэвдаваа гишүүн хийх ёстой юм уу гэдгийг бид энэ дэгийн хуульдаа яаралтай бас тодотгохгүй бол энэ өөрөө цаашдаа асуудал гарна.

**Ц.Даваасүрэн:** Хурлын тухай хуультай.

Тэгэхээр одоо бол нэг ийм юм яриад байна шүү дээ. Та нар. Ардчилсан намын бүлэг хамтарсан болчихсон учраас олонход орчихсон гэж.

Тэгэхээр Их Хурлын тухай хуулийн 10.2-оор энэ олонхыг яаж бүрдүүлэх вэ гэдгийг нь тодорхой бас заачихсан байхгүй юу. Аль ч нам, эвсэл олонх болоогүй бол гэж байгаа юм. Олон суудал авсан нам бусад нам эвсэлтэй зөвшилцсөн олонхыг бүрдүүлж болно. Тэгэхээр энэ нь бас байхгүй.

10.1-ээрээ 64-өөс дээш суудал авсан бол олонх гэнэ ээ гэхихсэн юм чинь одоо тэгээд хууль дээр тодорхой л байна шүү дээ. Энэ дээр ямар ч маргаан алга.

Тэгэхээр яах вэ, гишүүдийн яриад байгаа энэ агуулга бол ер нь бас шийдэх ёстой асуудал мөн.

Хэрвээ үнэхээр сонгодог утгаараа цөөнхийн хяналтыг парламентад тавья гэж байгаа бол бүр энэ Улсын Их Хурлын тухай хуульдаа өөрчлөлт оруулаад Зарлагын хяналтын дэд хороог цөөнх бүрдүүлэх хэрэгтэй. Олонхыг.

Энэ чинь санал хураалтаар шийднэ шүү дээ. Яг тэр агуулгаар явах гэж байгаа юм бол.

Тийм учраас нэгэнт хууль дээр байхгүй юмыг бид яриад яах вэ. Яг агуулга талаасаа харах юм бол тийм шүү.

Цөөнх олонх байж Зарлагын хяналтын дэд хороо яг та нарын яриад байгаа шиг тэр цөөнхийн хяналтыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Ганц даргаар үүнийг шийдэхгүй байхгүй юу.

Тийм учраас Б.Энхбаяр гишүүний хэлээд байгаа шиг ер нь Их Хурлын тухай хуульд, түрүүний Г.Дамдинням гишүүний хэлсэн гурав, дөрвөн цөөнх бүлэг гараад ирвэл яаж зохицуулах юм. Аль нь дэвшүүлэх эрхтэй юм гэдэг асуудал хүртэл энэ дээр зохицуулагдаагүй байгаа биз.

Тийм учраас энэ олон зохицуулагдаагүй асуудлууд байгаа учраас үүнийг зүгээр зохицуулах ёстой.

Тийм учраас өнөөдрийн хуулийнхаа хүрээнд бид санал хураалт явуулахаас өөр арга байхгүй.

Манай Их Хурлын гишүүд санаачлаад ялангуяа цөөнхүүд нэлээн ороод ирсэн юм чинь хамтраад ер нь энэ цөөнхийн бүлгийн асуудал, цөөнхийн төсөвт хяналт тавих асуудлыг яг сонгодог утгаар нь хэрэгжүүлбэ гэх юм бол Зарлагын хяналтын дэд хорооны олонхыг цөөнх бүрдүүлэх хэрэгтэй.

Тэгж байж яг сонгодог утгаараа хяналт тавигдана.

Түүнээс биш олонхыг нь авчхаад ганц муу дарга яах юм бэ. Тэр дарга юу

хийдэг вэ гэхээр Б.Пүрэвдорж шиг хурлыг хуралдуулна, хуралдуулахгүй гэдэг шантаажаас өөр юу ч байхгүй шүү дээ.

Тийм учраас яг сонгодог агуулгаар нь явъя гэх юм бол тэр хуулийн өөрчлөлтийг нь хийгээд Зарлагын хяналтын дэд хорооны олонхыг цөөнх бүрдүүлээд явах.

Тэгээд Г.Дамдинням гишүүний хэлээд байгаа хэд хэдэн цөөнхийн бүлэг бий болчихвол хэн нь Зарлагын хяналтын дэд хороонд даргын нэр дэвшүүлэх юм бэ гэдэг асуудлыг хүртэл зохицуулах зохицуулалтуудыг хийж өгөхгүй бол ийм зохицуулалтууд алга байна.

Т.Аубакир гишүүн.

**Т.Аубакир:** Яах вэ, одоо нэгэнт ингээд ийм нөхцөл байдал үүсчихсэн юм чинь Засгийн газрын түвшинд хамтраад явж байгаа.

Яг нарийн ярих юм бол Улсын Их Хурлын түвшинд ч хамтарчихсан л явж байгаа шүү дээ.

Улсын Их Хурлын бүтэц, бүрэлдэхүүнд байдаг зарим Байнгын хороог бас хүлээн зөвшөөрөөд л сөрөг хүчин болсон Ардчилсан намд өгсөн.

Энэ дээр Л.Гантөмөр дарга аа, улс төрийн зориг гаргаад энэ ард иргэд бас харж байгаа.

Л.Гантөмөр дарга одоо жишээлбэл өөрөө захиран зарцуулах гэж байж өөрийнхөө намын юун дээр бас хянуулах гээд байгаа юм уу даа гэдэг бас хар төрнө шүү дээ. Шударга байвал шударга л байя.

Тийм учраас одоо энэ Байнгын хороон дотроо байж байгаа бусад намын төлөөллүүд, Ардчилсан нам, Ардын намаас биш бусад намын төлөөллүүдээс хэдүүлээ эндээ ярьж сууж байгаад даргад нь нэр дэвшүүлээд л тавьчихъя.

Одоо жишээлбэл Д.Пүрэвдаваа гишүүн байж байна шүү дээ.

Өөрөө өөрийгөө л өөрийнхөө намын хүнээр хянуулсан болж л үлдэх гээд байгаа юм шиг нэг ийм байдал үүсчхээд байгаад бид жоохон байр суурь өөр байгаад байгаа юм л даа.

Тийм учраас энэ дээр Та бүхэн маань зориг гаргаад О.Цогтгэрэл дарга бүлгийнхээ бичгийг явуулсан байгаа. Дав.Цогтбаатар гээд залууг.

Хүндээ байгаа юм биш. Дав.Цогтбаатар гэдэг хүнийг би одоо л харж байна. Ардчилсан намын төлөөлөл. Гэтэл сая Б.Энхбаяр гишүүний хэлсэн одоо энэ өчнөөн их наяд төгрөгийн хяналт дээр өөрийнхөө хүнээр хянуулчхаад л тэгээд явж байх юм болж байна уу. Энэ чинь.

Тийм учраас энэ дээр зарчмын хувьд зөрүүтэй. Хууль дээр ийм байгаа юм байж. Үндсэн хуулийнхаа агуулгыг зөрчиж байна. Хяналт тавих гэдэг энэ үндсэн концепцоо бид зөрчих гээд сууж байна л даа. Хууль нь ийм шүү дээ гээд л урдаас нэг хууль харуулаад л.

Энэ дээр чинь олонхдоо цөөнх нь хяналт тавих гэсэн үндсэн зарчим явж байгаа учраас Л.Гантөмөр дарга аа, та энэ дээр шийдвэр гаргах нь зөв байх аа.

Энэ дэвшүүлж байгаа хүнийг дэмжих боломжгүй байна.

**Ц.Даваасүрэн:** Н.Алтанхуяг дарга горимын санал.

**Н.Алтанхуяг:** Би нэг горимын санал хэлбэ дээ.

Одоо байгаа хуулиар чинь ингээд цөөнхийн бүлгээс нэр дэвшүүлж сонгоно.

Т.Аубакир гишүүн Та битгий гуйвуулаад бай л даа. Дургүй бол дургүйгээ л хэлчих гээд нэг онигоо байдаг юм. Түүнийгээ л хэл.

Энэ чинь одоо явж байгаагаараа оруулж ирээд л Ардчилсан намын бүлгээс санал болгосон хүн дээрээ санал хураагаад л тэгээд л гаргана. Гаргах ёстой байхгүй юу. Хууль чинь.

**Ц.Даваасүрэн** даргын хэлж байгаа онолын зөрчил бол байгаа.

Ер нь хэрвээ ганцхан дарга нь хяналт тавихгүй шүү дээ. Өнгөрсөн 4 жилд Б.Пүрэвдорж гэдэг хяналтын юу билээ, Төсвийн хяналтын зарлагын дэд хорооны даргатай байсан. Тэр хүн хяналт тавьж чадах ч үгүй. Ганц хүний ажил биш. Энэ бол бүхэл бүтэн Зарлагын дэд хорооны ажил.

Тэгэхээр **Ц.Даваасүрэн** даргын хэлээд байгаа онолын асуудал үнэн. Хэрвээ та нар ингэж байгаа юм бол тэр намынхаа даргатай очиж ярь.

Тэгээд Төсвийн зарлагын хяналтын дэд хороог цөөнхөөс бүрдүүл. Цөөнхийн бүлгийн цөөнх бүгдээрээ нийлээд олонх болох ёстой.

Хэрвээ тэгж байгаа бол ийм асуудал руу очно.

Зүгээр энэ Ардчилсан намын бүлгээс санал болгочоод байгаа хүнээ оруулж ирээд дэмжээд гаргачихвал тэгээд л явчих.

Тэртээ тэргүй та нар Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дээр олонх байгаа биз дээ. Ардын нам. Одоо ийм л байна. Тэгээд та нар үүнийг.

Хайран цаг шүү дээ. Би түрүүн орж ирэхгүй гэж байсан. Хараад бүр цаг гаруй нэг ийм сэдвээр ярих юм аа.

**Ц.Даваасүрэн:** Одоо болчихсон, болчихсон. Энд чинь хууль нь Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлээр бүгдийг нь зохицуулчихсан байгаа байхгүй юу.

Цөөнх, олонх. Цөөнх дотроо цөөнхийн бүлэг гэж байна. Цөөнхийн гишүүн гэж байна гээд ингээд зохицуулчихсан. 10.3-аар.

Цөөнхийн гишүүн гээд байгаа нь Та нарын хэлээд байгаа эвсэлд орж чадаагүй байгаа, олонхыг бүрдүүлж чадаагүй байгаа намуудын гишүүдийг хэлээд байгаа юм.

Цөөнхийн бүлэг гээд байгаа нь Ардчилсан намын хэлээд. Энэ чинь бүр тодорхой заачихсан учраас энэ дээр уг нь маргалдаад суугаад байх шаардлагагүй л юм байгаа юм л даа.

Хэрвээ одоо ингээд маргалдахаар байгаа бол би хурлыг завсарлуулаад тэгээд тэр намынхаа бүлгүүд дээр ярь.

Тэгээд тэр цөөнхийг сонгодог утгаараа байгуул. Тэгвэл. Сонгодог утгаараа байгуул.

Үгүй ээ, үгүй. Ярих нь зөв. Хэлээд байна шүү дээ. Тэгэхдээ бид хууль дээр байхгүй юмыг Л.Гантөмөр ч чадахгүй байхгүй юу даа. Тийм. Энэ хууль дээр нь ингээд цөөнхийн бүлгээс дэвшүүл гэхихсэн. Цөөнхийн бүлэг гэж байна. Цөөнхийн гишүүн гэж байна гээд ингээд бүр тодорхой заачихсан юмыг чинь одоо яах юм бэ.

Хэрвээ тодорхой заагаагүй байсан бол би одоо хамаагүй. Шууд өрсөлдүүлээд.

Харин ингэж болох юм билээ. Ардчилсан намын бүлэг дотроо. Одоо та нар Дав.Цогтбаатарыг оруулж ирсэн ч гэсэн Н.Алтанхуяг гишүүн ч гэдэг юм уу, Л.Гантөмөр гишүүн ч гэдэг юм уу, хэн нэгэн өрсөлдье гэх юм бол харин тэр бол нээлттэй юм билээ шүү. Цөөнхийн бүлэг дотроо бол. Тийм. Өөр юм байхгүй.

Ардчилсан намын 3 гишүүн Зарлагын хяналтын дэд хороонд байгаа юм байна шүү дээ. Тэр 3 бол хоорондоо өрсөлдөж болох юм байна лээ.

Тэгээд яах вэ бүлэг дээрээ шийдчихсэн учраас би Дав.Цогтбаатар гэдгээр нь оруулья. Тэгээд өөрсдөө шийд.

Тэгээд шийдэж чадахгүй бол тэгээд Н.Алтанхуяг гишүүний хэлдгээр нээрээ тэр сонгодог утгаараа байгуулаад яв. Одоо яршиг.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатарыг сонгохыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү.

Би горимын санал гаргая. Сая би дэмжсэн санал өгсөн боловч. Би одоо хууль зөрчмөөргүй байна. Хууль дээр байгаа юм чинь.

Миний санал эсрэгээрээ гарчихсан учраас энэ саналыг хүчингүй болгоё гэдэг горимын саналаар санал хураалт явуулъя.

Саяын саналыг хүчингүй болгоё гэсэн миний гаргасан горимын саналын дагуу санал хураалт явъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

Энэ яагаад ажиллахгүй байна аа.

Хуралдааныг завсарлуулаад тэгээд бүлгүүд дээрээ ярьцгаа. Зарлагын хяналтын дэд хороо. Тэгэхдээ хууль дээр байгаа юмыг одоо ингээд байх утгагүй л юм байгаа юм.

Үүнийгээ шийдэж орж ирээд тэгээд саналаа хураая.

Хуулийнхаа дагуу л явна шүү.

#### ЗАВСАРЛАГА

Хуралдаанаа үргэлжлүүлье. Хэд болчихсон байна? Сая санал хураалтаар Дав.Цогтбаатарын нэр дэмжигдээгүй учраас Ардчилсан нам цөөнхийн бүлгээс Б.Түвшинийг санал болгож байгаа юм байна. Б.Түвшин байна уу?

Тэгээд Б.Түвшин ороод ирэг. Тэгээд санал хураалтаа явуулъя. Б.Түвшинг нь танилцуулж байя.



Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин 1993 онд Завхан аймгийн Нөмрөг сумын 10 жилийн дунд сургуулийг төгссөн.

1997 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуулийг эдийн засагч, нягтлан бодогч, 2007 онд Итали улсын Триест хотын Олон улсын бизнесийн их сургуулийг Олон улсын бизнесийн удирдлага, 2013 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрх зүйн мэргэжлээр тус тус төгссөн.

2018 онд Санхүү, эдийн засгийн их сургуулийн Бизнесийн удирдлагад магистрын зэрэг хамгаалсан.

2016 оноос Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд докторантаар суралцаж байгаа юм байна.

Ажил байдлын хувьд 1997-1999 онд Худалдаа, хөгжлийн банкинд эдийн засагч, 2000-2002 онд “Эрэл” ХХК-д ахлах нягтлан бодогч, 2003-2018 онд “АПУ” хувьцаат компанид санхүү хариуцсан захирал, 2016-2024 онд “МИГ даатгал” ХХК-д ерөнхий захирал, 2016-2025 онд Монгол Улсын Мэргэжсэн нягтлан бодогчийн институтийн Ерөнхийлөгч бөгөөд Удирдах зөвлөлийн даргаар тус тус ажиллаж байгаа юм байна.

Нэр дэвшигчтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд байна уу? Нэр дэвшигчээс асуух асуулт байна уу? Алга байгаа юм байна. Гишүүдийн ирц хэд хэдэн хувьтай байна. Нягталчих. Одоо ингээд санал хураалт явуулъя.

11 байна. 2 гишүүн ороод ирэхээр санал хураалт явуулъя. Хэдэн гишүүн сая ойрхон гарсан одоо нэг гишүүн байна. Би

орсон юу орсон. Хоёр гишүүн дуудчих. Манайхан.

Дараагийн асуудал хэлэлцэх гэж байгаа учраас сайд нар орж ирэх хэрэгтэй байна. Төсвийн тодотгол дагасан хуулиуд хэлэлцэнэ. Холбогдох сайд нар орж ирээрэй.

Гишүүд ээ, анхааралтай байгаарай. Санал хураалт явуулъя. Нэр дэвшигч өөрөө саналаа өгөөрэй.

Төсвийн зарлагын хяналтын хорооны дэд даргаар Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшинг сонгохыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд.

Энэ болохгүй байгаад байна шүү. Миний санал лав эсрэг явчихлаа. Дахья.

Уншигдахгүй байна уу? Тэгвэл Та санал гаргачих. Санал хураалтыг хүчингүйд тооцъё. Та горимын санал гаргачих. Хүчингүй болгох.

Ж.Батжаргал гишүүний микрофоныг өгье.

**Ж.Батжаргал:** Би сая дэмжиж санал өгсөн юм. Тэгэхээр өгсөн санал уншигдахгүй байгаад байна.

Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгөхийг хүсэж байна.

**Ц.Даваасүрэн:** Миний санал ч гэсэн тэгчихлээ.

Ж.Батжаргал гишүүний гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

10 гишүүн дэмжиж, 58.8 хувийн саналаар дэмжигдсэн тул өмнөх саналыг дахин санал хураалт явуулъя.

Төсвийн зарлагын дэд хорооны даргаар Банзрагчийн Түвшинг сонгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалтыг дахин явуулъя.

Энэ төхөөрөмж ажиллахгүй байгаад байна. Яах вэ. Манай техникийнхэн. Ж.Батжаргал гишүүнийх дахиад эсрэг саналтай гараад байна шүү дээ. Гар өргөх юм уу? Тэгвэл Та тийм горимын санал гаргачих. Яршиг.

**Ж.Батжаргал:** Техникийн бас тодорхой шаардлагын улмаас уншихгүй байна.

Тийм учраас санал хураалтыг гар өргөж явуулж өгнө үү гэж хүсэж байна.

**Ц.Даваасүрэн:** Ж.Батжаргал гишүүний гаргасан горимын саналын дагуу төхөөрөмжөөр санал хураах

боломжгүй байгаа тул гар өргөж санал хураая гэсэн саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

Хэн гишүүн горимын санал гаргая гээд байлаа. Горимын санал дэмжигдсэнгүй. Дараагийнхаа асуудалд орёё. Горимгүйгээр явчхаж болох байх аа. Энэ асуудал ингээд хаагдчихлаа.

Дараагийн хэлэлцэх асуудалд орёё. Тэгэхдээ нэг асуудал үлдэж байгаа шүү. Тодотгол хугацаанд амжихгүй болчхож байгаа шүү.

Яагаад гэвэл Зарлагын хяналтын хорооны дүгнэлт өнөөдөр гарах байсан. Боломжгүй болчхож байгаа юм. Яах вэ дээ. Тэгээд эд нар өөрсдөө учраа олог.

Би нэр сольсон. Одоо яах юм. Өнөөдөр тэгээд Зарлагын хяналтын дэд хорооны дүгнэлт гарах.

Дараагийн асуудлаа хэлэлцээд явъя.

---

**Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд**  
**/Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

---

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,

үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Аж

ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төрийн өмчийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх. Санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулна.

Эдгээр асуудлыг хэлэлцэхээр оруулж байна.

Хэлэлцэх асуудалтай саналтай гишүүн байна уу? Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн алга байгаа учраас хэлэлцэх асуудалдаа оръё.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг би танилцуулаадахъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн.

Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын Шадар сайд.

Т.Доржханд сайд байгаа юм уу? Энэ Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуультай холбогдуулаад нэлээн асуулт асуух юм билээ шүү. Т.Доржханд сайд орж ирье.

Равжихын Эрдэнэбүрэн Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга гэнэ. Болдын Жавхлан Сангийн сайд ирсэн байна.

Борхүүгийн Дэлгэрсайхан ирсэн байна. Зам, тээврийн хөгжлийн сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд ирсэн байна. Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга. Чөлөөтэй. Оронд нь Н.Мандуул дарга ирсэн байгаа юм байна.

Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга. Байна уу? Өөрсдөө оролцоно шүү. Тэр орны хүн явуулах юм байхгүй шүү.

Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ирсэн байна. Сандагдоржийн Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Цэдэнбалын Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга. Ц.Батзул дарга ирсэн үү? Ирчихсэн байна.

Доржсүрэнхорлоогийн Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга. Байна уу? Байна.

Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга ирсэн байна.

Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга. Байна уу? Байна.

Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга ирсэн байна.

Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга. Алга уу?

Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Адьяасүрэнгийн Даваажаргал Соёлын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга, Жигжидсүрэнгийн Отгонбат Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Баярсайханы Анар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хяналт шалгалтын багийн ахлах хянан шалгагч, Төмөрбаатарын Нармандах Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хяналт шалгалтын багийн ахлах хянан шалгагч, Дүүсүрэнгийн Мөнхбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын зөвлөх, Нямдэлэгийн Мандуул Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч, Луулайн Хосбаяр Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч, Дугаржавын Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Нанзадын Баярчимэг Нийслэлийн Засаг даргын Улаанбаатар хотын Захирагчийн Төр, хувийн хэвшлийн түншлэл, төсөл хөтөлбөр хариуцсан зөвлөх, Болдбаатарын Энхжин Нийслэлийн Засаг даргын Санхүү, хөрөнгө оруулалтын

газрын дарга, Мөнхөөгийн Батбаяр Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга, Баасанжавын Батхуяг Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээ Үндэсний хорооны даргын зөвлөх. Эдгээр улсууд оролцож байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн холбогдох хууль, тогтоолын төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулна. Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт 13 хуулийн төсөл, 2 Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийн талаар товч дурдвал Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн анхдугаар чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай хууль, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн холбогдох бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн баталж, Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудалд өөрчлөлт орсон.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд

нэмэлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн нийгмийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Түүнчлэн оновчтой, үр ашигтай засаглалыг бэхжүүлэх Засгийн газрын харьяа байгууллага, албан тушаалтан албаны чиг үүргээ хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж байгаа эсэхэд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага хяналт тавих тогтолцоог оновчтой болгох хүрээнд төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол төслийг боловсрууллаа.

2.Тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хангахад зоригжуулалтыг сайжруулах, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд өөрсдийн салбарын төсвийн төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулдаг байх, төсвийн цаглаврыг төсөв боловсруулах, хянах, дүгнэлт гаргах, хэлэлцүүлэх үйл явцдаа нийцүүлэх, төрийн үйлчилгээний бүтээмж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн механизмыг бүх салбарт хэрэгжүүлэх боломжтой байх зэрэг зохицуулалтыг Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа.

Нийгэмд чиглэсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрүүдийг өөрийн хөрөнгөөр санаачлан хэрэгжүүлсэн албан татвар төлөгчийн элэгдэлд тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт болон харилцан хамааралгүй этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын

зардлыг тухайн жилийн татварт ногдох орлогын нэг хувиас хэтрэхгүй дүнгээр үйл ажиллагааны орлогод төлбөл зохих албан татвараас хасах, хөнгөлөх зохицуулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа.

3.Монгол Улсын хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжих бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг худалдан авах ажиллагааг чадавхад суурилсан хэлэлцээний аргаар зохион байгуулж, тендер шалгаруулалтад туршлага, чадавх, нэр хүнд бүхий аж ахуйн нэгжийг урьж оролцуулах нөхцөлийг бүрдүүлж, бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийг хурдан шуурхай гүйцэтгэх зохицуулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалд авах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг хэвийн, тасралтгүй хангах нэн яаралтай нөхцөл үүссэн тохиолдолд сонгон шалгаруулалт зарлахгүйгээр төслийг хэрэгжүүлэх чадвартай хоёроос доошгүй хувийн хэвшлийн түншлэгчид урилга хүргүүлж, төслийн санал авч хэлэлцээ хийж, хамгийн сайн нөхцөл санал болгосон түншлэгчтэй гэрээ байгуулах зохицуулалтыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа.

Нийслэлийн нийслэл хотын аж ахуй, инженер хангамжийн бараа, ажил үйлчилгээг тухайн салбарын төрийн

болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэх ажлыг түргэн шуурхай эхлүүлэх зохицуулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөлд тусгалаа.

4.Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ус, цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлийг давтамж эрчим нэмэгдсэн өнөөгийн нөхцөлд нийслэл Улаанбаатар хотод үүсэж болзошгүй гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршиг, үр дагавраас урьдчилан сэргийлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг нэн даруй хэрэгжүүлэхтэй холбогдуулан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсрууллаа.

5.Шахмал түлшний хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, түгээлт болон эдгээр үйл явцад тавих хяналт, түүнчлэн санхүүжилтийн механизмыг сайжруулах зорилгоор энэхүү үйл ажиллагааг эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн төрийн хэвшлийн хувийг Нийслэлийн өмчлөлд шилжүүлж, үйл ажиллагаа, үйлдвэрлэлийг нийслэлд хариуцуулахаар “Төрийн өмчийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулан хэлэлцүүлж байна.

Хуулийн төслүүд батлагдсанаар Засгийн газрын үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж, хамтарсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөгжлийг хурдасгах, хөрөнгө оруулалтын

хөтөлбөрүүд цаг алдалгүй шуурхай, үр дүнтэй хэрэгжих боломж бүрдэх болно.

Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Б.Жавхлан сайдад баярлалаа.

Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд нэрээ өгье.

Ж.Батжаргал гишүүнийх орчихлоо. С.Ганбаатар орчихсон уу? Өөр ороогүй гишүүн байна уу? Д.Ганбаатар гишүүнийх. Г.Ганбаатар гишүүнээр таслахаар 7.

Энэ төхөөрөмжид их асуудал байна даа. Манай техникийнхэн анхаарахгүй бол энэ санал хураалт дээр ерөөсөө асуудал үүсээд байна шүү дээ. Үүнийг зохицуулахгүй бол. Санал хураалт явуулах боломжгүй болчихоод байна шүү дээ.

Тийм учраас гишүүд асуулт асууж байх хугацаанд манай техникийнхэн тоног төхөөрөмжийг найдвартай явуулах чиглэл дээр анхаармаар байна.

С.Ганбаатар гишүүн асуултаа асууя.

**С.Ганбаатар:** Би чуулган дээр асууж байсан асуултуудаа л бас тодруулья.

Азаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан дүгнэлтэд бас энэ орчихсон байгаа юм байна. Би өчигдөр авлаа.

Энэ дээр юу гэж заасан бэ гэвэл Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт буюу төсвийн алдагдлыг хязгаарласан тусгай шаардлагыг суурь зарлага хэмээх ойлголтод үндэслэж суурь зарлага тэнцэл хэмээн гэсэн нь нэр томъёоллоор оруулж ирсэн нь өнөөдөр төсвийг эрс нэмэгдүүлэхээр болсон байна гэж заасан байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн энэ дүгнэлтэд Сангийн яамны газар хэлтсийн яг хариуцаж байгаа улсууд нь ямар тайлбар өгч байгаа вэ? Ямар байр суурь илэрхийлж байгаа вэ?

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-д заасан нийт зарлагын өсөлтийг хязгаарласан шаардлагыг нэгдсэн төсвийн урсгал. “Урсгал” гэж байгаа шүү. Зардлыг ингэж 30 хувиас хэтрэхгүй гэж болгосноороо эрсдэлтэй байдал үүсэх нь ээ. Нөлөөлөх хүчин буюу өөрөөр хэлбэл төсвийн эрсдэлд онцгой нөлөөлж байна гэсэн ийм заалт орсон байна.

Миний ойлгож байгаагаар боловсрол, эрүүл мэнд болон урсгал зардал чинь ер нь гол нь боловсрол, эрүүл мэнд, төрийн цалин хөлс байгаа шүү дээ. Үүнийгээ хязгаарлана. Төсвийн хөрөнгө оруулалтуудыг бол зүгээр хамаагүй задгай тавьж өгнө гэсэн ийм ойлголт ороод ирчихсэн байна. Энэ дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс бүр ингээд дүгнэлт гарчихсан байна. Үүнийгээ зас аа. Энэ маш их эрсдэлтэй байдал үүсгэнэ гээд.

Би өнөөдөр энэ хамтарсан Засгийн газрын энэ төсөв бас хамтарч байгаа төсөв. Хэрэгжчихээсэй. Үр дүн гарчхаасай гэдэг үндсээр л үүнийг ярьж байгаа юм шүү дээ.

Тогтвортой байдлын зөвлөл гэж хөндлөнгийн бие даасан шинжээч эрдэмтдийн дүгнэлт гарчхаад байхад үүнийг нь авч хэлэлцэхгүй байвал Их Хурал өнөөдөр ажлаа хийхгүй байна гэсэн үг.

Ийм хоёр зүйл дээр би тодруулах асуултаа асууя.

Гуравдугаар зүйл гэвэл үндсэндээ төсвийн орлогын өсөлттэй холбоотойгоор хувь хүний орлогын албан татварыг 539.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байгаа.

Улсын Их Хурлын чуулган дээр би үүндээ хариулт авч чадаагүй.

Энэ төсвийн зарлага талд цалин хөлсний зардлыг бас хасах 111.2 тэрбум төгрөгөөр бас бууруулсан байгаа. Үүний нарийн учрыг нь надад тайлбарлаад өгөөч. Энэ миний гурав дахь асуулт.

2024 онд Монгол Улс гадаадын зээл, тусламжийн 2.9 их наяд төгрөгийн хөрөнгийг зарцуулахаар байгаа. Энэ хөрөнгийн хэдэн хувь нь нийгмийн салбарт, хэдэн хувь нь бүтээн байгуулалтын салбарт зарцуулахаар байгаа вэ гэдэг ийм дөрвөн асуултад би хариулт авъя.

**Ц.Даваасүрэн:** Б.Жавхлан сайдын микрофоныг өгье. Асуултад хариулъя. С.Ганбаатар гишүүний. Гурван асуулт асуусан.

**Б.Жавхлан:** Баярлалаа.  
С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

С.Ганбаатар гишүүн ээ, уг нь сүүлийн хурал дээр бид тайлбарлах гээд л оролдоод байгаа юм. Юу вэ гэхээр Төсвийн тогтвортой байдлын хуульд өөрчлөлт оруулах хоёр үндсэн шалтгаан байна. Хоёр үндсэн шалтгаан.

Нэгийг нь гишүүд ер нь анзаараагүй байжээ. Засгийн газар ч үндсэндээ бараг үнэнээ хэлье. Бид ч бараг мэдээгүй байсан.

Ингээд сая ээлжит бус хурал зарлахаас өмнөхөн, хэдхэн хоногийн өмнө төрийн төлөөлөл дээр өнгөрсөн 6 сард нэлээн хэдэн өөрчлөлт орсон хуулиуд дөнгөж тавигдсан. Ингээд олон нийт үүнийг харж мэдээлэл авсан. Веб дээр тавигдсан. Бид ч мөн яг тэгтэл харсан.

Юу вэ гэхээр Төсвийн тогтвортой байдлын хуулийн 6.4 дээр хоёр том зарчмын өөрчлөлт орчихсон байгаа.

6.1.2, 6.1.4 гээд хоёр тусгай шаардлагаа хөндчихсэн.

Үүгээр юу болсон бэ гэхээр өнөөдөр Монгол Улс өрийн хязгаар 60 гэдэг хувь маань байхгүй болчихсон. Он дуустал байхгүй болчихсон. 2025 оны 01 сарын 01-нээс эхлээд нөгөө алдагдлын хязгаар чинь хасах 2 хувь буюу түүнээс илүү сайн байх ёстой шүү гэдэг хязгаар 01 сарын 01-нээс эхлээд бид бүр байхгүй болчихсон. Бүр байхгүй болчихсон.

Тэгэхээр таны ярьж байгаа тэр 30 хувийн хязгаар чинь бүр байхгүй болчхож байгаа байхгүй юу. 01 сарын 01-нээс. Бүр байхгүй.

Тийм учраас энэ дээр яаралтай засвар хийх энэ саналыг Засгийн газраас оруулж ирж байгаа юм.

Тэгээд Улсын Их Хурал эрхэм гишүүд Та бүхэн энд тунгааж үзнэ биз ээ.

Хэрвээ өөрчлөлт орохгүй бол яг энэ хуучнаар одоо байгаа статусаа явах юм бол таны яг сая яриад байсан чинь бүр 30 хувь чинь бүр байхгүй болоод өрийн хязгаар ч энэ жилдээ байхгүй, зардлын хязгаар ч, алдагдлын хязгаар ч байхгүй болчхож байгаа юм. Монгол Улс. Нэгдүгээр шаардлага нь энэ байна.

Хоёрдугаар шаардлага нь, юуны тулд хамтарсан Засгийн газар байгуулагдаж байгаа билээ? Энэ 4 жилийн хугацааг бид маш сайн ашиглах, гүйцэтгэл сайтай байх ёстой.

Тийм учраас энд ийм шинэ зохицуулалт орж ирж байгаа юм. Тэр “урсгал зардал” гэдэг чинь яг таны хэлж байгаа тэр нийгмийн суурь зардлууд. Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамж гээд.

Эдгээр зардлууд маань сүүлийн жилүүдэд ер нь 30 орчим хувь дээрээ л байгаа. Зарим жил нь 31, зарим жил нь 29, 28 гээд байгаа.

Тийм учраас нөгөө дотоодын нийт бүтээгдэхүүнээ өсөж байгаа өсөлтийг нь дагаад энэ суурь төсөв маань өөрөө байнга өсөж байдаг учраас тэгсэн хэдий ч 30 хувь дээрээ хэдүүлээ барья. Харин энэ 4 жилийг ашиглаад хөрөнгө оруулалтуудаа, бүтээн байгуулалтуудаа, ялангуяа дэд бүтцийн. Улсын Их Хурал дээрээс баталсан жагсаалт, Засгийн газрын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулаад энэ дэд бүтцүүдээ хийж авъя.



Хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч нарыг цаашид ажлаа өргөжүүлэх, тэр дэд бүтцийн суурин дээр бүтээн байгуулалтуудаа хийх, баялаг бүтээх тэр боломжийг нь бүрдүүлье. Зөвхөн дэд бүтцүүд дээрээ.

Тэгээд ингэж зарим гишүүд маань бас болгоомжлоод байх шиг байгаа юм. Би ч бас болгоомжилж байгаа.

Юу вэ гэхээр нөгөө гадаад зээл, тусламж ингээд үлэмж нэмэгдчихнэ ээ, өр нэмэгдчихнэ ээ гээд. Үгүй юм аа. Өрийг хэд хэдэн хэдэн заалтаар энэ дээр түгжиж байгаа. Хэвээрээ байгаа.

Одоо байхгүй болчихсон байгаа тэр 60 хувийг буцааж оруулж ирж байгаа. Дээрээс нь. Дээд хязгаар нь.

Доороос нь яаж сойж өгч байна вэ гэхээр одоо өнөөгийн үнэ цэнээр бүртгэдэг энэ горимоо өөрчлөөд нэрлэсэн үнээр болчихож байгаа юм. Өөрөөр хэлбэл өнөөдөр 40 хувь байсан зээл маань нэрлэсэн үнээр бодохоор шууд 45 болоод явчхаж байгаа юм.

Ингээд доороосоо 45, дээрээсээ 60. Энэ хоёр хязгаар дотроо гаднаас шинээр авах өр маань хязгаарлагдана.

Тэр хөрөнгө оруулалт гээд тэр нөгөө бүртгэлийн. Бүртгэл биш ээ. Суурь зардлаасаа тусад нь тооцоод явахаар нэгэнт авчихсан байгаа зээлийг зарлагыг нь төсөв дээр заавал бичиж байж.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Б.Жавхлан сайд 1 минут.

**Б.Жавхлан:** Би танд хоёрхон жишээ хэлье.

Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламж. Бид 250.0 сая долларын зээл Хятадаас авсан.

Үүнийг байгуулаад сүүлийнхээ шатдаа орж байна. Барилга нь. Гэтэл сүүлийн санхүүжилтүүдээ бид хийж чадахгүй хязгаартаа тулчхад байгаа.

Жишээ нь, нефть боловсруулах үйлдвэр байна. Мөн л тэрбум 600 сая доллар, 800 орчим дээр гарчихсан. Одоо цаашаагаа бид зээлээ авчихсан, үзэглэчихсэн, Улсын Их Хурал зөвшөөрчихсөн мөртөө ашиглаж чадахгүй байх жишээтэй.

Тэгэхээр энэ дээр зөвхөн ашиглалтууд нэмэгдэнэ. Зээлийн ашиглалтууд. Түүнээс биш шинэ зээл авахад Их Хурал та шийднэ энд. Их Хурлын гишүүд энд шийднэ.

Харин ашиглалтаа Засгийн газар дангаараа өөрсдөө шийдээд явдаг байгаа юм.

Гэхдээ энэ нь хязгаарт орж ирчхээд байгаа учраас энэ 4 жил бүгдээрээ юм хийе ээ л гэж байгаа ийм зохицуулалт юм байгаа юм шүү. Нэгдүгээр асуулт нь тэр.

Аж ахуйн нэгжийн орлогын татвартай хариултыг манай Б.Тэлмүүн хариулчихна.

Гадаад зээлийн 2.9-ийг Ж.Дэлгэржаргал дарга хариулаад яваарай.

**Ц.Даваасүрэн:** Энэ дээр нэмэлтээр та хэд нэг тодруулга өгөөдхөөч.

Төсвийн тэнцлийн 6.1.2-ыг байхгүй болчихсон гэдэг ийм ойлголт яваад байна шүү дээ.

Тэгэхээр 19.9 дээр. Яах вэ 2024 оны 2.8 хувиас хэтрүүлэхгүй гэдгийг зохицуулахын тулд саяын Б.Жавхлан сайдын яриад байгаа заалтыг оруулаад 2025 оны төсвийн жилээс эхлэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна гээд 19.9 дээрээ байгаад байгаа юм. Тэрийг та хэд нэмж тайлбарлаадхаач.

Б.Жавхлан сайдын микрофон. Яагаад гэвэл буруу ойлголт явах гээд байна.

**Б.Жавхлан:** Ийм юм байгаа юм. Тэр 19 чинь болохоор 6.1.2 байгаа тохиолдолд ажиллана. Байхгүй болчихоор одоо тэр чинь ерөөсөө ажиллахгүй болчхож байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 2.8 гэдэг хязгаар байгаа боловч өнгөрсөн чуулганаар 2023 оны намар 2024 оны төсвийг батлахдаа ч тэр, Засгийн газар оруулахдаа ч тэр 2 хувь дээрээ оруулсан. 2 хувь байна гэж. 2.8 биш 2 хувь гэж.

Одоо тодотгол хийх гэж байгаа суурь төсөв маань ч 2 хувиараа байж байгаа. Тодотгол хийгээд оруулж ирэхдээ ч 2 хувиа хөдөлгөөгүй. 2 хувиараа байж байгаа. Маш тодорхой.

Тийм учраас 6.1.2 маань ерөөсөө бүтэн байхгүй болчихоод байна. Байхгүй болчихоор тэр 6.1.19 чинь өөрөө ажиллахгүй.

**Ц.Даваасүрэн:** Үгүй ээ. Тийм биш байна.

2024 онд 2.8 хувиас хэтрүүлэхгүй гэхээр 2 хувьтай байж болно. 2.8 хувиас хэтрүүлэхгүй л гэж хязгаар тавьж өгсөн байхгүй юу. Энэ чинь хязгаар.

Тэгээд дараачийнхаараа болохоор 2025 оноос эхлэн гэж байгаа юм. 2025 оноос эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна гээд ийм заалт бас байж байгаа байхгүй юу.

5 дугаар микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Байнгын хорооны даргын асуултад хариулья.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл маань өөрөө тусгай шаардлага гэдэг зүйл байгаа. Өөрөөр хэлбэл энэ хуулийн яг амин сүнс нь.

19 дүгээр зүйл бол дагаж мөрдөх журам. Өөрөөр хэлбэл 6 дугаар зүйлд заачихсан байгаа тусгай шаардлагуудаа дагаж мөрдөж байна гэсэн үг.

19.9 гээд таны уншиж байгаа энэ заалт өөрөө их эхлэхдээ 6.1.2-т заасан тэнцвэржүүлсэн тэнцэл гэж эхэлж байгаа байхгүй юу.

Тэгэхээр өөрөөр хэлбэл тусгай шаардлага нь байхгүй болчихсон тохиолдолд дагаж мөрдөх нь өөрөө бас хүчингүй болоод дагаад үүнийгээ мөрдөх боломжгүй болчихоод байгаа ийм заалт байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 19.1 дээрээ бас эсрэгээрээ зөрчилдсөн заалт орчхоод байгаа.

Тэгэхээр тусгай шаардлага дээрх заалт нь л байна байж дагаж мөрдөх нь орж ирнэ ээ л гэдэг ийм байдлаар манай хуулийнхан үүнийг тайлбарлаж байгаа. Мөн Хэрэг эрхлэх дээр энэ талаар яг ингэж ярьсан байгаа.

Тэгэхээр 6 дугаар зүйлийг нь дагаж мөрдөх журам, тусгай шаардлага нь байна байж тусгай шаардлагаа яаж дагаж мөрдөх нь 19.9 дээр орно.

Түрүүн С.Ганбаатар гишүүний асуусан асуултад гүйцээгээд хариулья.

Хувь хүний орлогын албан татварын өсөлтийг асуусан. Эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор, мөн Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн иргэдэд хуваарилсан ногдол ашгийн нөлөөгөөр, мөн төрийн албан хаагчдын цалин хөлсийг бид дөрөвдүгээр улирлаас нэмэгдүүлсэн байгаа.

Энэ нэмэгдүүлсэн хэмжээн дээр орон нутаг бидний 20, 40 хувиар орон нутгийн нэмэгдэл олгосон дээр бас нэмэх эрх нь байгаа.

Эдгээртэй холбоотойгоор хувь хүний орлогын албан татвар хагас жилийн гүйцэтгэлээр 55.0 хувьд хүрээд давчихсан явж байгаа.

Тэгэхээр 550.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж байгаа нь эдийн засгийн идэвхжилттэй холбоотойгоор нэмэгдэж байгаа ийм зүйл байгаа.

Хоёр нь, цалингийн зардал 111.0 тэрбум төгрөгөөр яагаад буурсан бэ гэж асуусан.

Засгийн газраас 2024 оны 01 дүгээр сарын 23-нд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хувьсах зардлыг шинэчлэн батлуулсан байгаа.

Үүн дээр дотуур байрны зардлыг бас нарийвчилж тогтоосон. Энэ дээрээ зардлын нийт бүтцийг тогтоосон байгаа. Өөрөөр хэлбэл цалингийн зардал тэдэн хувийг эзэлнэ, хичээлийн хэрэглэлийн зардал тэдэн хувийг эзэлнэ. Бусад зардлууд тэдэн хувь гээд зардлууд нэг бүрээрээ тогтоосон байгаа. Илүү нарийвчилж тогтоосон гэсэн үг.

Тэр дагуу бид зохицуулалтыг нь хийсэн.

Түүнээс биш хүний цалин тэнд буурсан зүйл байхгүй. Илүү нарийвчилж орсон зүйл орсон байгаа.

Өмнө нь яасан гэхээр нийтдээ сургууль, цэцэрлэгийн нийт зардал маань 2024 онд 2.8 их наяд төгрөг батлагдсан байгаа. Эндээс 2.2 их наяд төгрөг нь зөвхөн цалин гээд тавьчихаад байгаа юм.

Тэгэхээр цалин дээрээ хэмнэлт гаргаад зарим сургууль, цэцэрлэг, бусад багшийн хөгжлийн төв ч байдаг юм уу, өрөө тасалгаагаа сайжруулах, мөн материалын зардлаа нэмэгдүүлэх ийм боломжийг нь гаргаж өгөхийн тулд хувьчилж нөгөө пропорцыг тогтоосон. Түүнийх нь дагуу зохицуулалт орсон байгаа.

**Ц.Даваасүрэн:** Энэ дээр нэг ийм асуудал үүсчхээд байгаа юм.

6.1.2-ыг аваачаад тэр хуулийнхаа 6-гийн хэд дээр байлаа. 6.4 дээрээ аваачаад 2025 он хүртэл юм шиг ойлголт өгчихсөн.

19.9-өөр болохоор 2025 оноос эхлээд 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна гээд заачихсан.

Тэгэхээр энэ дээр ямар нэг эрх зүйн дүгнэлт гаргаж энэ хуулийн зөрчлийг арилгахгүй бол байхгүй ч биш, байгаа ч биш, тэгэхдээ үгүйсгэчихсэн ийм заалт оруулчихсан байгаа байхгүй юу. Тэрийгээ хийхдээ 2024 оны 2.8-ыг зохицуулчихсан гэж тайлбарлаад байгаа юм билээ.

Тийм учраас манай Тамгын газрын хууль эрх зүйнхэнд дүгнэлт гаргаад, шаардлагатай энэ удаагийн хэлэлцүүлгийн явцад бид энэ хуулийн зөрчлийг арилгаад явах арга хэмжээ авах нь зүйтэй шүү.

С.Ганбаатар гишүүн тодруулах юм уу? Тодруулъя.

Энэ төсвийн тодотгол чинь өөрөө тогтвортой байдлын хүрээнд батлагдах ёстой учраас гишүүд асуугаад байх шиг байна л даа.

Уг нь Тогтвортой байдлын хууль бол төсвийн хүрээний мэдэгдлээ дагаж өргөн баригдсан.

С.Ганбаатар гишүүн.

**С.Ганбаатар:** Миний хугацаа ч бүр алга болж өглөө л дөө.

Хамгийн гол нь цалингийн 111.0 тэрбум ингээд төсвийн зарлагын талд цалин хөлсний зардлыг бууруулчихлаа. Мөн энэ дээр 539.0 тэрбум төгрөг хувь

хүний орлогын албан татвар дээр нэмэгдчихлээ.

Энэ дээр холбогдох, ялангуяа багш нар, эмч нар, тэд нартайгаа зөвлөлдөж, ярьж, тэр салбарын хэлэлцээртээ орсон уу гэдэг нэгдүгээр асуулт. Тодруулж асууж байна.

Хоёрдугаарт, өчигдөр асуусан. Нэгдсэн төсвийн нийт орлогыг батлагдсан дүнгээс 2.9 их наядар нэмэгдүүлсэн байгаагаас 58.6 хувь нь шүү дээ. 1.7 их наядыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр нэмэгдээд ороод ирсэн байгаа.

Яг энэ аж ахуйн нэгжийн орлогын татвар дээр ямар салбар дээр нь ямар үйлдвэрлэлийн өсөлт, бүтээгдэхүүн, инновац, бүтээмж дээр бий болсон юм бэ гэдэг энэ асуултыг би тодруулж асуусан. Би хариултаа аваагүй байгаа. Ийм хоёр асуулт.

**Ц.Даваасүрэн:** С.Ганбаатар гишүүний тодруулсан хоёр асуултад хариулт өгье. Б.Жавхлан сайд. Дараа нь 5 номерын микрофон. Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** С.Ганбаатар гишүүн ээ, энэ чинь ер нь тэгээд эдийн засгийн л идэвхжил шүү дээ.

Мэдээж манай эдийн засгийн бүтэц дотор уурхай л зонхилж байна. Уул уурхайг дагасан тээвэр ложистик гээд энэ салбаруудаас. Өөрөөр хэлбэл манай суурь идэвхжээд суурь тэлж байгаа учраас аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төвлөрүүлэлт нэмэгдэж байгаа л зүйл.

Түүнээс биш тэнд татварын ямар нэг хувь хэмжээнд өөрчлөлт орсон зүйл ерөөсөө огт байхгүй байгаа.

Ер нь 2019 оноос хойш бид татвараа ер нь хөндөөгүй байгаа шүү дээ.

Тэр нөгөө цалин гэж байна. Цалин дээр салбарын хувьд цалингийн дундаж хэмжээ, үндсэн цалин, суурьд өөрчлөлт ороогүй.

Тэгэхээр хэмнэлт гарсан суурин дээрээсээ нэмэгдэж байгаа төдийд салбартай ярилцах ямар ч шаардлага байхгүй. Нэг ч багшийн, нэг ч эмчийн цалин нь одоо энэ төсвөөс болж дутахгүй, цалин тавигдахгүй байна гэсэн асуудал гарахгүй.

Тийм учраас энэ бол цэвэр төсвийн бодлогоор зохицуулагдаад явдаг асуудал байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** 5 номерын микрофоныг өгье. Больчихсон юм уу?

Тэгвэл дараагийн гишүүн. П.Ганзориг гишүүн асуултаа асууя.

**П.Ганзориг:** Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлттэй холбоотой нэг асуулт байна.

Үүний 3.31.5 дээр тендер сонгон шалгаруулалтыг тухайн аргаар хоёроос доошгүй удаа зарлаад нэг ч компани орж ирээгүй бол төрийн эсвэл орон нутгийн өмчит компанитай шууд гэрээ байгуулж болохоор ийм зохицуулалт орж байна.

Бид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, ер нь бодлого дээрээ эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоогоо нэмэгдүүлнэ гээд яриад байгаа.

Гэтэл энэ зохицуулалтаар үүнийхээ эсрэг байхаар ийм логиктой юм яваад байна.

Ер нь яг ямар шалтгаанаар ингэж оруулж ирж байгаа вэ? Одоо энэ төрийн өмчийн компани, орон нутгийн өмчлөлийн компани гүйцэтгэхээрээ алдагдалгүй болдог ч юм уу, богино хугацаанд гүйцэтгэдэг, ашигтай гүйцчихдэг гэсэн тийм тайлбарууд бас өгөөд байна лээ.

Төрийн өмчийн компани алдагдал хүлээх юм бол тэр алдагдлыг дахиад л төсвийн мөнгөөр нөхнө. Ялгаа байхгүй.

Тэгэхээр хувийн хэвшлүүдээ дэмжье гэж байгаа бол ийм зохицуулалт оруулах нь буруу юм болов уу гэж бодоод байна.

Ер нь гол асуудал нь энэ үнэ тариф, нормоо шинэчилдэггүй. Манай бүтээн байгуулалтын ажлууд ялангуяа ихэнх нь импортоор явж байгаа шүү дээ. 90 хувь нь. Дэд бүтцийн барилга.

Тэгээд хэдэн жил ингээд шинэчлэхгүй болохоор үнийн өсөлтдөө нөгөө бүтээн байгуулалтын ажлууд нь идэгдээд, тэгээд хувийн хэвшлүүд ороход үр ашиггүй болчихоор орохгүй байна гээд байдаг.

Тэгэхээр гол асуудал чинь энэ үнэ тарифтай байгаа юм биш үү. Ажлын хөлсний, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний.

Ингээд төрийн өмчит компаниуд, орон нутгийн өмчит компаниуд руу шилжүүлээд эхлэхээр тэд нарын хөрөнгө оруулалтууд, урсгал зардлууд нэмэгдэнэ. Дахиад л төр данхайна. Энэ дээр тодорхой хариулт өгөөч ээ.

Хоёрт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуультай холбоотой асуудал хөндсөн болохоор бас дахиад тодруулаад асуучихмаар байна.

Одоо байгаа хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн 6.4 дээр 6.1.2 2025 оны 01 сарын 01-нээс хүчингүй болно гээд заачихсан байгаад байгаа шүү дээ.

Тэгэхээр мянга 6.1.2-т өөрчлөлт оруулаад энэ чинь ач холбогдолгүй зохицуулалт болчхож байгаа юм биш үү гэдэг ийм хоёр асуулт байна. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** П.Ганзориг гишүүний асуултад хариулъя. Б.Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** П.Ганзориг гишүүний асуултад хариулъя.

Тэр Төрийн худалдан авах ажиллагааны тухай хуульд орж байгаа өөрчлөлт ер нь хувийн хэвшил, баялаг бүтээгч нартай нэг их халгаа байхгүй дээ. Харин ч ер нь төсөв талаасаа эрсдэлээ багасгаад, төсөв өөрөө тогтвортой байна гэдэг чинь макро суурь хамгийн чухал үзүүлэлт.

Тийм ч учраас үүгээрээ ингээд хувийн хэвшилдээ ч гэсэндээ ер нь төлөвлөлт дунд урт хугацааных нь тогтвортой байдал дээр нь ч бас нөлөө үзүүлдэг байхгүй юу. Маш ихээр.

Сүүлийн өнгөрсөн 4 жил бид ковид гээд, мөн сүүлийн 2 жил энэ геополитикийн энэ асуудлаас болоод ер нь энэ хөрөнгө оруулалтууд маань маш их эрсдэлтэй байсан. Маш их үнийн өсөлттэй явж ирсэн учраас үнийн өсөлтийг нь нэг талаар төсөв дийлэхгүй.

Нөгөө талаар аж ахуйн нэгжүүд тендерт орохгүй. Авсан аж ахуйн нэгжүүд нь гүйцэтгэл муутай. Үнэхээр одоо бодит байдал ийм л болсон. Зарим нь дундуур нь туулайнууд ч явсан.

Тийм учраас цаашдаа аль аль талаа бодоод. Ер нь ингээд эдийн засгаа тогтворжуулах энэ бүхий л тал дээр бид чармайж гаргаж байна.

Тийм учраас энэ хөрөнгө оруулалтуудын гүйцэтгэлийг их сайтар байлгахын тулд зарим нэг эрсдэлүүдээ хааж байгаа юм.

Зарлаад хоёр удаа огт оролцоогүй. Өөрөөр хэлбэл хувийн хэвшил маань энд их эрсдэлтэй байна. Ийм өртгөөр бид хийж дийлэхгүй алдагдалд орох юм байна гэж байгаа ийм төслүүд дээр төрийн болон орон нутгийн өмчит компаниуд ороод энэ дээр “тэг ашигтай” гэж бид ярьдаг. Тийм ээ. Эдийн засгийн “тэг ашигтай”. Өөрөөр хэлбэл зардлаа нөхөөд, цалингаа тавиад ингээд явчих юм бол болох юм байна гэж үзвэл гэрээлээд явж болно гэдэг ийм зохицуулалт юм.

Х.Нямбаатар дарга энэ дээр маш дэлгэрэнгүй олон жишээ гаргаад ярьдаг л даа.

Түүнээс гадна би саяхан болсон жишээ хэлье. Дархан хотод 2010 онд эхэлсэн төсөл байдаг юм. “Спорт комплекс”. 14 жил болоод сая 6 сард ашиглалтад орсон.

2023 оны жилийн эцэст үндсэн гэрээлэгч нь хугацаа нь дуусаад зогссон. Үйл ажиллагаа нь. 10 хүрэхгүй хувийн ажил үлдсэн байсан. Тендерүүд зарлагдсан. Сүүлд нь Батлан хамгаалах яамны барилгын цэргийн анги орж ирсэн.

Тэгээд барилгын анги ороод хоёрхон сарын дотор ажил дуусгасан. Хоёрхон сарын дотор шүү. Тэр барилга дотор нь цэргүүд бүр казармлаж ажиллаж байгаад хоёрхон сарын дотор дуусгасан.

Тэгэхээр ер нь төр талдаа ч гэсэн хувийн хэвшлийнхний дийлэхгүй байгаа ийм зүйлүүдийг төр оролцоод гараад явчих боломжууд байгаа юм байна гэдэг нь ингэж харагдаж байгаа юм.

Одоо тэнд барилгын цэргийн анги орсноор тэр барилгын цэргүүд цалинтай байгаа юм. Ямар ч байсан цэргээс халагдахдаа хөөрхөн цалинтай бүгдээрээ л ингээд буучхаж байгаа байхгүй юу. Өөр нэг ашиг хайгаагүй байх. Батлан хамгаалах яам.

Гэх мэтчилэн ийм боломжууд байгаа. Өөрөөр хэлбэл хувийн хэвшилтэй огт өрсөлдөөгүй. Дийлэхгүй байгаа ийм зүйлүүдийг бид хийхээс өөр аргагүй ээ. Ийм боломжуудыг төр өөрөө хаяж болохгүй байгаа юм. Ийм байдлаар орсон байгаа.

П.Ганзориг гишүүний хувьд хоёр дахь асуудал дээр бүр яв цав 100 хувь санал нийлж байна.

6.4-ийг хөндөхгүйгээр 6.1.2, 6.1.4-ийг буцааж сэргээх гээд ч бараг шаардлагагүй ийм болж байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо ингээд хэрвээ өөрчлөлт хийхгүй ингээд орхичих юм бол маш өндөр эрсдэлтэй. Байгаа байдал. Одоо бидний хүсэж байгаагаас бүр долоон доор л юм болчхоод байгаа юм. Цаад суурин дээрээ.

Тэгээд үүнийг ямар ч байсан хуулийн зөрчил гэж үзнэ үү, юу гэж үзнэ

үү. Ямар нэг байдлаар үүнийгээ эргэж харгахгүй л болохоо байчхаад байна л гэж. Тийм. Логик бол тантай санал нийлж байна. 6.4-ийг өөрчлөхгүйгээр өөр юу ч өөрчлөөд үр дүн гарахгүй.

**Ц.Даваасүрэн:** Г.Дамдинням гишүүн асуултаа асууя.

**Г.Дамдинням:** Төсөв дагасан хуулиуд орж ирж байна.

Яах вэ, сүүлийн хэдэн жил бид энэ цар тахлын дараах эдийн засгийн нөхцөл байдлаас хамаараад, бас түүхий эдийн үнэ өссөнөөс болоод манай эдийн засаг тэлээд, тэгээд бас нэг жоохон зайтай болоод хөрөнгө оруулалтуудаа зоригтой хийгээд яваад байгаа.

Тэгээд энэ эрдсийн үнэ унаад ирэх дээр зэрэг бид нарт том асуудал үүсэж байгаа нь ойлгомжтой. Энэ зээл хуультай холбоотой л асуудал яригдахаас өөр аргагүй болчхоод байгаа байхгүй юу. Үндсэн одоо үүнийг яриад байгаа гол шалтгаан цаанаа тэр шүү дээ.

Тэгэхээр би зүгээр Сангийн яамныхнаасаа дахиад л асууя даа. Би эртээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гээд 2010 онд энэ чинь бараг С.Баярцогт сайдын үед хийсэн хууль байх шүү. Гаднаас олон улсын санхүүгийн байгууллагаас дэмжлэг аваад, хөтөлбөр хэрэгжүүлээд хийсэн хууль шүү дээ. Уг нь бол. Төсвөө тогтвортой байлгая. Бид санхүүгийн сахилга батаа алдаад байна.

Тийм учраас Монголд төсвийн тогтвортой байдлын хууль хэрэгтэй юм гэж хийж өгсөн хууль байхгүй юу.

Харамсалтай нь бид 17 удаа өөрчилж байна л даа. Жил хүрэхгүй

хугацаанд л хуулийн өөрчлөлт хийгээд тодотгол хийгээд яваад байна гэсэн үг.

Тэгэхээр би Үндэсний аудитын газрын төсвийн тодотголд өгсөн дүгнэлтийн 02 дугаар дүгнэлтийг уншъя.

Цаашид дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахгүй байх, төсвийн тусгай шаардлагыг дунд, урт хугацаанд тогтвортой байдлыг хадгалж, дагаж мөрдөх нь төсвийн тогтвортой байдлыг бэхжүүлэх суурь нөхцөл болно гээд.

Өөрөөр хэлбэл бид төсвийн хүрээндээ хүрээд байгааг Үндэсний аудитын газар ч, энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ч өгөөд байгаа байхгүй юу.

Юу хэлээд байна вэ гэхээр бид 2024 оноо 100 төгрөгөөр давж болно гэж байсан бол үүнийгээ 120 болгочихъё, 130 болгочихъё л гээд байгаа л санаа шүү дээ. Маш энгийн товчоор яриад байгаа нь.

Тэгэхээр энэ савандаа багтаж, байгаа боломждоо зохицуулалт хийх маягаар энэ хөрөнгө оруулалтаа өөрчлөөд хийчих ийм төсвийн тодотгол оруулаад ирэх боломж байгаагүй юм уу? Энэ одоо яг төсвийг хянадаг Улсын Их Хурлаас томилогддог хоёр мэргэжлийн байгууллагынх нь дүгнэлт яг ижилхэн юм хэлээд байхад Их Хурал чинь бас сонсох ёстой л болчхоод байна л даа.

Тэгэхээр энэ дээр өөр гаргалгаа байхгүй юу л гэдэг асуулт байна.

**Ц.Даваасүрэн:** Б.Жавхлан сайдын микрофоныг өгье. Асуултад хариулъя. Г.Дамдинням гишүүний.

**Б.Жавхлан:** Г.Дамдинжавын асуултад хариулъя.

Бид өнгөрсөн 4 жилийг ямар нөхцөл байдалтай өнгөрүүлж байсныг ерөөсөө хэдүүлээ огт магтаж болохгүй шүү.

Үндсэндээ сүүлийн 4 жил үргэлжлээд энэ чинь одоо бараг 12 дахь төсөв байгаа юм. Төсвийн тодотгол, үндсэн төсөв нийлээд. Өөрөөр хэлбэл энэ ковидын хүнд үе, эдийн засгийн хүнд нөхцөл байдал, геополитикийн асуудал гээд энэ бүх юмыг даван туулах бидэнд ийм маневр хэрэгтэй байсан.

Дээрээс нь ковидын үеийн хууль ч гэж бид их тийм онцгой түүхэн үүргээ гүйцэтгэсэн ийм хуультай явж ирсний үр дүнд өнөөдөр эдийн засаг маань нэг ийм тогтвортой байдал. Нөгөө хонгилын үзүүрт гэрэл харагдаж эхэлж байгаа юм шүү.

Яах вэ, Засгийн газар луу хэрвээ ингэж ярьж байгаа бол 2017 оноос хойш Төсвийн тогтвортой байдлын хуульд өөрчлөлт оруулах санал Засгийн газраас ер нь хоёр удаа л гарч ирсэн юм.

2021 онд ковидын үед нэг удаа гарч ирсэн. Баялгийн сантай холбоотойгоор Засгийн газар нэг удаа өөрчилсөн. Хоёр удаа ийм санал гарч ирсэн.

Их Хурал дээр бол гурван удаа санал гараад ингээд өөрчлөгдсөн байдаг юм.

Тэгээд 2012-2016 онд 7 удаа өөрчлөгдөж байсан юм билээ. Энэ бол түүх.



Энэ удаа бид сүүлийн 5 жилийн хугацаанд тэнцвэржүүлсэн орлогоо нэг ч алдаа хийгээгүй. Засгийн газраас өргөн барьсан орлого дандаа биелж байсан. Сүүлийн хоёр жил давж биелж байгаа. Энэ удаагийн давсан орлогоо ч гэсэн бид алдаагүй гэдэгтээ итгэлтэй байгаа.

Үүнийг яах вэ, алдагдал руугаа шингээгээд явчхаж болно. Гэхдээ өнөөдөр бидний тулгамдсан асуудал бол хамтарсан Засгийн газрын үедээ номер нэг бүтээн байгуулалтын ажил байгаа.

Тийм учраас энэ жил нэмж олж болох орлогынхоо хэмжээнд бүтээн байгуулалтынхаа ажлыг төлөвлөж оруулж ирж байна гэсэн үг байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Нэмэлт тодруулга байна уу? Г.Дамдинням гишүүн нэмж тодруулъя.

**Г.Дамдинням:** Үгүй ээ, яах вэ одоо Их Хурал, Засгийн газар хоёрын хоорондын жил болгоны л дуэль энэ дээр л явна л даа. Өөр арга байхгүй. Бид нарын ажил.

Тэгэхээр яах вэ, зүгээр алдагдал руугаа шингээгээд энэ том төслүүдээ оруулж ирмээр байгаа юм.

Тэгэхээр энэ хүрээндээ хүрэлгүйгээр хийчихвэл нэгдүгээрт зүгээр байгаад байгаа юм.

Хоёрдугаарт, шууд доллар олдог, орлого олдогт нэмэр болдог энэ хөрөнгө оруулалтуудаа бас дэмжмээр байгаа байхгүй юу.

Том хэмжээний хөрөнгө оруулалтууд хийх гээд харагдаж байна лээ. Ядаж энэ говийн зам руугаа хандсан юмнуудаа ингээд оруулаад ирэхгүй бол

ингээд хамтарч байгаа учраас гээд. Би бол одоо жишээ нь гэхэд Ардын намын бүлгийн гишүүн гэхэд энэ хамтарч байгаа гэрээг нэг ч удаа олж хараагүй. Яг ямар гэрээ хийчхээд ингээд энэ том юм шахаад байгааг бол ойлгохгүй байгаа. Ийм л байгаа. Тийм. Асуулт биш шүү. Тэр үг.

**Ц.Даваасүрэн:** Үг хэлсэн байна. Х.Ганхуяг гишүүн асуултаа асууя.

**Х.Ганхуяг:** Энэ өдрийн мэндийг хүргэе.

Хэд хэдэн асуулт байна. Нэгдүгээр асуудал нь, Ирээдүйн өв санд 750 гаруй тэрбум төгрөг хуримтлагдана гэж ойлгогдож байна. Тэгээд бид Баялгийн сангийн хуулийг хийхдээ Монголбанкаар менежмент хийлгэж болно гээд заасан байгаа.

Тэгээд энэ хуримтлалыг бид валютаар хуримтлуулах гэж байна уу? Ямар нэгэн үр өгөөжтэй байдлаар хуримтлуулах гэж байна уу, үгүй юу гэдэг нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, энэ төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг уншсан ч, одоо энэ Төрийн болон орон нутгийн өмчийн худалдан авалтын тухай хуулийг уншсан ч ер нь хувийн хэвшилд маш тийм хаалттай ийм орчин бүрдүүлэх гээд байна шүү. Т.Доржханд сайд аа.

Яагаад гэдгийг нь хэлье.

31.5 дээр. Сая П.Ганзориг гишүүн хэлж байна. Тендерийн шалгаруулалт. Ингээд хоёр удаа зарлаад санал ирээгүй бол шууд төрийн болон орон нутгийн өмчит компаниар ажлаа гүйцэтгүүлнэ гэхчээ байгаа юм.

Энэ бол яах вэ одоо төрийн худалдан авах дээр харьцангуй шилэн, ил тод явдаг. Орон нутагт бол аймаг гээд явах юм бол энэ бол зүгээр л баахан орон нутгийн шинэ компаниуд байгуулагддаг үндэслэлийг тавина шүү.

Төсөв нь хэд дахин томорчихсон. Тэгсэн мөртөө хувийн хэвшлийн хийдэг ажлыг нь төрийн болон орон нутгийн өмчит компаниуд өгөх л ийм л гаргалгаа харагдаж байна.

Тэгээд энэ компаниуд чинь хувийн хэвшлийн компаниуд ер нь яг цаашдаа яаж явах юм?

Тендер шалгаруулалтад хоёр удаа санал өгөөд ирээгүй бол гэдэг гэсэн тийм л гаргалгаа гаргаад байна л даа.

Тэгээд энэ чинь уг нь тэр тендерт орох, сонгон шалгаруулалтад орох компаниудыг нь болохгүй бол харин тэр тавьдаг нөхцөлүүдэд жоохон зөөлрүүлэх, хялбаршуулах ийм аргачлалыг цөмөөрөө сонгохгүй бол ингээд л төр бол төрийн өмчит компани, эсвэл орон нутгийн өмчит компани гэдэг ийм юм руугаа л явчхаад байна шүү дээ. Т.Доржханд гишүүн ээ.

Та өмнөх 4 жил ярьдаг юмнаасаа шал ондоо л юм ярьдаг болчихсон байна шүү.

Хоёрдугаар асуулт. 37.9. Ингээд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар болохоор хоёр хуулийн этгээдэд урилга хүргүүлнэ гэж байгаа юм. Ямар тохиолдолд аль төсөл дээр урилга хүргүүлдэг болох вэ гээд. Энэ чинь ерөөсөө тодорхойгүй байна шүү дээ. Яг энэ хууль дээр. Одоо яах юм. Бүх энэ төслүүд дээрээ зүгээр ингээд хоёр өөр

компани тухайн төсөв захирагч нь урилга хүргүүлээд л.

Тэр дотроос нь сонгохдоо ингэж байгаа юм. 37.11.5 дээр чинь байж байгаа юм.

Хамгийн сайн нөхцөл санал болгосон компанийг сонгоно гэж байгаа юм. Хамгийн сайн гэдэг энэ хуулийн хэллэгийг би ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Би одоо тэр П.Сайнзориг гишүүн байгаа, Б.Энхбаяр гишүүн байна.

Энэ чинь зүгээр үзэмжийн асуудал шүү дээ. Үнэлгээ хийх зарчим нь алга байна.

Тэгээд одоо хамгийн сайн гээд тэнд аль нэгийг нь зүгээр дураараа ингээд сонгоно гэсэн үг. Хоёрхон компанид урилга өгөөд тэр хоёроосоо энэ нь хамгийн сайн байсан болохоор гэдэг ийм хууль гэж.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Б.Жавхлан сайд хариулъя. Т.Доржханд дараа нь. Ингээд дараалаад явчихъя.

**Б.Жавхлан:** Х.Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Тэр Ирээдүй өв сан гэж байгаа. Одоо ер нь цаашдаа хэдүүлээ их том том сантай боллоо. Ирээдүй өв сангийн үлдэгдэл энэ жилийн эцэст гэхэд 3.4 их наяд болно. Тэрбум доллар болно. Тэрийг нь бид Төрийн сан гээд том данснаасаа бүр бэлэн мөнгөөр нь тусгаарлаад Төв банканд дээрээ байршуулдаг. Ингэж болж байгаа.

Тийм учраас үүнийг олон улсын байгууллагаар, тэгээд Төв банкаар удирдуулъя л гэдэг ийм өөрчлөлт орж байгаа юм шүү. Тийм.

Тэгэхээр улам л найдвартай хадгалагдана л гэсэн санаа байгаа юм.

Ер нь бид Эрүүл мэндийн даатгалын сангаасаа эхлээд л өөрсдөө удирдана гээд л өнөөдрийг хүртэл дандаа л дотоодын хэдэн банкнууд дээр аваачаад л алдсан ийм их гашуун түүхтэй байгаа юм.

Тийм учраас энэ алдааг цаашаагаа хэдүүлээ давтахгүй. Тэгэхдээ энэ нь их ил тод, алдагдалгүй, эрсдэлгүй, хөрвөх чадвартай байгаасай л гэж байгаа юм. Тийм. Ийм өөрчлөлт орж байгаа юм шүү.

Яах вэ, тэр орон нутгийнх дээр би ийм санаа хэлье. Т.Доржханд сайд хариулна биз.

Ер нь хэдүүлээ ёстой 100 хувь бүгдийг нь хувийн хэвшлээр болдог бол хийлгэчихмээр л байгаа юм.

Энэ уриан доор хэдүүлээ хэт их тийшээгээ туйлшрахаар энэ төлөвлөчихсөн байсан хайран хөрөнгө оруулалт маань эрсдэлд ороод байгаа байхгүй юу. 10-аас 20 хувийн жилийн жилд нэг хэмнэлттэй гардаг юм.

Ямар юмных нь хэмнэлт байх вэ дээ. Хувийн хэвшлийнхэн орж дийлэхгүй болохоор л хэмнэлт гарч ирж байгаа байхгүй юу. Тийм юман дээр нь орон нутгаас, төрийн өмчөөс одоо байж болох тусгай лицензтэй. Тэнд чинь бас л баялаг бүтээж байгаа хүмүүс шүү дээ. Цалин авч байгаа, өрхийн тэжээгч ийм хүмүүс байгаа.

Тэгээд тэд нар луу өгөөд 10, 20 хувийн эрсдэлээ бас тэд нар нь даагаад бүтээн байгуулалтаа хийгээд явах юм бол төсөв талдаа энэ чинь бас алдагдалгүй,

хэмнэлттэй, зөв төлөвлөлт болчхож байгаа юм.

Тэгэхээр ийм л санаагаар орж ирж байгаа юм шүү зүгээр. Нэмж санаа хэлэхэд.

**Ц.Даваасүрэн:** Т.Доржханд гишүүн хариулъя.

**Т.Доржханд:** Баярлалаа. Х.Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр нэгдүгээрт нэг ийм ойлголтын зөрүүгээ гаргачихмаар байна. Юу вэ гэхээр өнөөдөр Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд прокурементийн агентлаг<sup>[худалдан авах ажиллагааны]</sup> байгаа шүү. Нэг.

Хоёрдугаарт, хувийн хэвшлийн эсрэг ямар нэгэн чиглэсэн бодлого огт байхгүй ээ. Тэрийг гаргахгүй ээ.

Тэгээд та мэдэж байгаа байх. Энэ өнгөрсөн хаврын чуулганаар бид Дав.Цогтбаатар гишүүн тэргүүтэй. Та ч бас орсон байх. Улсын Их Хурлын тогтоол гаргуулсан шүү дээ. Тэгээд дахиж нэмж шинээр төрийн өмчийн компани, аж ахуйн нэгж байгуулахгүй байя гэдэг дээр хязгаарлалт байгаа. Төрийн хэмнэлтийн хууль дээр хязгаарлалт байгаа.

Тэгэхээр энэ хязгаарлалтын хүрээнд Засгийн газрын түвшинд төрийн өмчийн компанийг шинээр байгуулаад байхгүй ээ. Үүнийгээ Засгийн газар дээр бид хатуу ярьж тохироод байгаа юм.

Тэгэхээр цаашаагаа энэ маань ингээд ямар тохиолдолд хоёр удаа тендер зарлаад орж ирэхгүй. Үнийнх нь санал бага. Энэ тохиолдолд дараагийн боломжийг нь төрийн өмчийн

компаниудад, ялангуяа орон нутгийн өмчтэй компаниудад боломжийг нь олгоё гэдэг. Энэ бол орон нутгийн зүгээс орж ирсэн юм. Ялангуяа Х.Нямбаатар дарга байх юм бол бас хариулаарай.

Тэгээд энэ хэмжээний эх үүсвэр нь тийм төрийн өмчийн компаниудыг дэмжсэн, тэтгэсэн асар их хэмжээний хөрөнгө оруулалтын эх үүсвэр бас байхгүй шүү. Бодит байдал дээр. Тэгээд бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө тойрог дээрээ мөнгөө тавьдаг. Тэгээд он дуусаад ирэхээр нөгөөдөх нь шалгардаггүй, явдаггүй. Яагаад вэ гэхээр төслүүд нь он дамжиж явсаар байгаад. Түрүүн Б.Жавхлан сайд хэлж байна. 12 жил хүртэл дуусгаагүй ийм объектууд байгаа байхгүй юу.

Тэгвэл үр дүн нь юу вэ гэхлэр эсрэгээрээ төсөв дээр чинь дарамт үүсгээд байна. Жил ирэх тусам инфляцтайгаа уялдуулаад, бараа материалын үнэтэйгээ уялдуулаад нөгөө төсөвт өртөг нь өсөөд байдаг.

Тэгвэл үүнийгээ цэглээд цэглээд явдаг байя гээд. Ийм агуулгаар өнөөдөр энэ хуулийн төсөл орж ирж байгаа шүү.

Тэгэхдээ би зарчмын хувьд Х.Ганхуяг гишүүнтэй санал нэг байгаа.

Ерөөсөө бид бизнесийнхээ салбаруудыг дэмжих ёстой. Худалдан авах ажиллагааны үндсэн бодлого нь концепцын хувьд бизнес лүүгээ дэмжиж байгаа шүү.

Одоо энэ томоохон төслүүд чинь концепцоор хийнэ гэдэг нь дандаа бизнесээ дэмжиж байгаа.

Тэгээд худалдан авах ажиллагааныхаа боломж, чанарынх нь түвшинг нь өсгөж байгаад бүгдэд нь ижилхэн ил тод боломжийг олгоё гэсэн байдлаар илүү шилэн байдлаар орж ирж байгаа.

Та бүгд бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Өмнө нь ямар их шууд бус худалдан авалтууд хийж байлаа. Ногоон автобус. Бүгдээрээ мэдэж байгаа. Эрдэс Тавантолгойн төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн худалдан авалт юу болж дуусаж байлаа. Ямар их дүнтэй байлаа.

Тэгвэл энэ бүх процессуудыг чинь бүгдийг нь ил тод болгоё. Тэгээд илүү бизнесүүдэд ижилхэн боломж олгоё гэсэн байдлаар энэ хуулийн төслүүд орж ирж байгаа.

Манайхнаас нэмж хариулах уу. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Болчихсон уу. Х.Ганхуяг гишүүн нэмж тодруулъя.

**Х.Ганхуяг:** Нэгдүгээрт, төрийн болон орон нутгийн өмчит компани нэмж байгуулахгүй байх тогтоолын төсөл өргөн барьсан.

Тэгэхдээ тэр батлагдаагүй шүү. Т.Доржханд гишүүн ээ.

Хоёрдугаарт, дөнгөж саяхан бид Зарлагын хяналтын дэд хорооны даргын асуудал ярьсан.

120 их наяд төгрөгийн. Хагас нь төрийн худалдан авалтаар хийгдэнэ. Нэг ёсондоо одоо тэр бол ингээд тендер шалгаруулахгүйгээр аль нэг төрийн өмчит компаниар хийлгэх юм байна.

Нөгөө талдаа төр, хувийн хэвшлийн түншлэлээр цөөн хэдэн компанид урилга хүргүүлээд цөөн хэдэн компанид өгөх юм байна.

Тэгээд энэ нь гол хяналт тавьж явдаг Хяналтын дэд хорооны дарга та нар өөрсдөө тавих гээд одоо ингээд сууж байна. Энэ одоо ингээд байж болдог логик уу? Та нар зарчим яриад байсан. Хэдүүлээ засах гэж явсан. Одоо ингээд орж ирэнгүүтээ энэ зарчмыг бүгдийг нь нураах гээд энд сууж байна.

**Ц.Даваасүрэн:** Санал хэлчихлээ. Тийм ээ. Санал юм даа. Б.Энхбаяр гишүүн асуултаа асууя.

**Б.Энхбаяр:** Би Х.Ганхуяг гишүүний асуултыг үргэлжлүүлж асууна.

40 тэрбум орчим долларын төсөл, бүтээн байгуулалтын ажлыг ямар хуулийн прокурементийн хууль хэрэглэж, эсвэл ямар төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль хэрэглэж хэрэгжүүлэх гэж байгаа вэ гэдэг хууль нь энэ төсөв дагасан хуулиуд байгаа.

Тийм учраас ямар хэмжээний мөнгөн дүнг одоо энэ хуулийг хэрэглэж зарцуулах гэж байна вэ гэдэг асуудлыг ярихын тулд энэ хуулийг аягүй сайн ярих ёстой.

Яг энэ үзэл санаа өнгөрсөн 4 жил дөрөв дэхээ орж ирж байгаа. Ковидын хуулиас эхлээд тендергүй бүх юмыг хийчихье гэдэг хууль орж ирж байсан. 2022 онд орж ирж байсан. 2023 онд орж ирж байсан.

Хамгийн том хулгайг дандаа төсөв дагасан хуулиар хийдэг. Энэ удаа бас орж ирж байна.

Хэдэн заалт байна. Нэгдүгээрт, хүчингүй болчихсон Концессын хуулийг хэрэглэе гэдгийг яагаад оруулж ирсэн юм бэ гэдгийг Л.Гантөмөр сайдаас асууж байна.

Хоёрдугаарт, Тендерийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 2 дугаар зүйлд, Тендерийн хуульд 3 дугаар зүйлийн 3.3.7-д Засгийн газраас хөгжлийн бодлого, шинэчлэлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх асуудлаар нэр хүнд бүхий тусгай мэдлэг, ур чадвартай зөвлөх хүн, хуулийн этгээдийг сонгох шаардлагатай гэж шийдвэрлэсэн бол тендерийн хуулийг дагаж мөрдөхгүй гэдэг заалт оруулж ирж байгаа.

Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлаас тендерийн хуулийг яах гэж гаргасан юм. Засгийн газар тендерийн хуулийг хэрэглэхгүй ээ гэдгийг Засгийн газар шийдье гэдэг ийм хуулийн өөрчлөлт оруулж ирж байгаа. Гэхдээ өөрийнхөө үзэмжээр.

Ямар төсөл дээр энэ тендерийн хуулийг хэрэглэхгүй вэ гэдгийг Засгийн газар бие дааж мэдэх өөрчлөлт оруулж ирсэн байгаа.

Энэ бол Улсын Их Хурлын буюу ард түмний төлөөллийн байгууллагын бүрэн эрхэд халдаж байгаа асуудал. Нэг.

Хоёрдугаарт, Засгийн газар тухайлан хуульчилсан хуулийг үйлчлэх, үйлчлүүлэхгүй эсэхийг Засгийн газар бие дааж мэддэг байх Үндсэн хуулийн зарчим байхгүй.

Тийм учраас үүнийг тодруулж асууж байгаа юм.

Гуравдугаарт, 10 тэрбум төгрөгөөс дээш төрийн өмчийн компанийн

худалдан авалтыг, тэр дотроо нийгмийн чанартай бүтээн байгуулалтын худалдан авалтыг Т.Доржханд сайдын харьяа худалдан авах агентлаг хийдэг байя гэдэг өөрчлөлт орж ирж байгаа.

Т.Доржханд сайд бид хоёр нүүрсний хулгай гээд нэлээн ярьсан. Тийм ээ. Тэр дээр ямар хэмжээний нийгмийн бүтээн байгуулалтыг Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэт үйлдвэрээр хийж байгааг бид ярьж байсан.

Хамгийн сүүлд Эрдэнэт үйлдвэр 100 тэрбум төгрөгөөр жорлон барьсан. Улсын Их Хурлаар ороогүй.

Одоо үүнийг Худалдан авах ажиллагааны агентлаг хийдэг болъё гэдэг өөрчлөлт ямар учир шалтгаантайгаар оруулж ирж байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Дараа нь тодруулах юм уу? Эхлээд хариулчихъя. Л.Гантөмөр сайд. Тэгээд Т.Доржханд сайд хариулах юм байна шүү. Л.Гантөмөр сайдаас эхэлчихье.

**Л.Гантөмөр:** Бид Засгийн газар дээр яригдаж, шийдэгдсэн асуудлаа л Та бүхэн тайлбарлаад сууж байгаа шүү дээ.

Энэ Засгийн газар өөрөө шинэ Засгийн газар байгуулагдаад шинэ бодлого гаргаж байгаа хэрэг биш шүү дээ.

Өнгөрсөн 4 жилийнхээ тэр Засгийн газрын амьдралд үнэлэлт дүгнэлт өгөөд юу болоод өнгөрөв, юун дээрээ алдав, яагаад бид ажлаа хийж чадахгүй байна гэдэг энэ үндэслэлийг холбогдох хамаарах яамд нь ярьсаар байгаад л орж ирж байгаа төсөл гэж Та бүхэн хүлээж аваарай.

Жишээлбэл, “Шинэ сэргэлт”-ийн бодлого зарлаад баахан ажлыг концессын хуулиар явуулсан. Тэгээд баахан компани шалгаруулчихсан юм байна. Зам, тээврийн яам. Тийм.

Гэтэл тэр ажлуудаа ажилд нь оруулдаггүй. Нөгөө коридор, нөгөө нисэх буудал, нөгөө боомт гээд баахан юм явчихсан.

Тэгээд энэ хугацаанд явж чадсан ажил нь юу вэ гэхээр “оффтэйк”. Нөгөө нууцад авч байж явуулдаг.

Тэгээд хотын дарга юу яриад байгаа вэ, Замын сайд юу яриад байгаа вэ, энэ яг ажил хариуцсан хүмүүс нь юу яриад байгаа вэ гэхээр ерөөсөө энэ чинь болохгүй байна. Бид одоо хийж чаддаг ганц ажил бол ерөөсөө нууцад авч байгаа л нэг эзэнтэй болгож ажлынхаа ард гардаг.

Тэгэхгүй бол өнөөдөр Тавантолгойн цахилгаан станц гээд 10 жил ярьж байгаа. Одоо хүртэл байхгүй. Одоо бараг тэр байхгүй юм шиг байна лээ шүү. Б.Энхбаяр сайд аа.

Хийдэггүй. Маргалдаад суугаад байдаг. Тэгээд хамгийн сүүлд нь томчуул нь тунаж байгаад нэгнийхээ шилийг үзнэ гээд ингээд шүүхдээд суучихдаг. Тийм юм билээ.

Тэгэхээр харин ингэж байна лээ л дээ. Тийм. Таны ярьж байгаа хуулийн нюанстай асуултуудад Засгийн газрын хуулийн хүмүүс хариулах хэрэгтэй. Бодитойгоор. Та өөрөө хуулийн сайд байсан хүн учраас. Харин тийм.

Та тэгэхээр системтэйгээр хувааж байгаад хариуцсан хүмүүс нь толгой даагаад үүндээ хариул гээд байна л даа.

Би бол Засгийн газрыг төлөөлж ярих учраас Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хуулийн хүмүүс энэ тайлбарыг өгөх хэрэгтэй.

Гол асуудал нь. Би бол асуудлаа хэлэх гээд байгаа юм. Одоо жишээлбэл Т.Доржханд бид хоёр баахан мөнгө зарцуулах гээд байгаа хэрэг энд байхгүй. Над дээр нэг ч тендер явахгүй. Т.Доржханд дээр нэг ч тендер явахгүй.

Худалдан авах ажиллагаан дээр хулгайгүйгээр, тэгсэн мөртөө ажил хэрэг болдог тэр худалдан авалтын хуулийг удахгүй том утгаар нь хийж өргөн барих ажил руу алхана. Тэр бодлогыг Засгийн газар хийнэ ээ.

Төр, хувийн хэвшлийн түншлэл дээр хуучин концесс дээрээ баахан гэрээ хийчихсэн. Одоо тэрийг ямар хуулиар дүгнэх вэ гээд хүлээгээд сууж байгаа байхгүй юу. Б.Энхбаяр гишүүн ээ.

Концессын гэрээ хийчихсэн. Одоо тэр гэрээний дагуу хүмүүс зам бариад байдаг, ажил хийгээд байдаг. Одоо тэгээд тэр улсуудтай ямар гэрээгээр бид асуудлаа шийдэх вэ.

7, 8 гомдол байна. Харин явчихсан юм байгаа гэж ойлгоод ийм асуудлаа яриад байгаа юм.

Б.Дэлгэрсайхан сайд жишээлбэл өөр дээр чинь юу байгаа тухай ярих хэрэгтэй. Хотын дарга юу байгаа тухайгаа ярих хэрэгтэй.

Одоо жишээлбэл ийм байхгүй юу. Шинэ хотыг байгуулъя гэж байгаа юм. Хөшигийн хөндий. Шинэ хот байгуулахад тэрийг хэрэгжүүлэх компанийг олж хурдан ажилд нь

оруулахын тулд л ийм гарц байна гээд энэ холбогдох ажил хийдэг хүмүүс нь яриад байгаа байхгүй юу даа. Үгүй ээ, та нар бол тэгэхгүй ээ. Хуучин шигээ ингээд ярьж суугаад байвал дахиад хоёр, гурван жил алдах юм билээ л дээ. Хотын менежмент хийдэг компаниа шалгаруулж амжихгүй гэж байгаа юм. Зүгээр тайлбарууд нь. Энэ бол хаана ч нууц биш шүү дээ. Засаг дээр яригдаад хаанаас ийм асуудал үүсэв ээ гэдгийг л бид.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Б.Дэлгэрсайхан сайд нэмж тодруулга өгье.

Ер нь Л.Гантөмөр сайдын хэлдэг үнэн байхгүй юу. Бид хуулиар бүх юмаа хаачхаад, тэгээд ямар ч хөдлөх боломж байхгүй гараа хүлүүлчхээд сууж байгаа.

Жишээлбэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль гээд концессын гэрээний ар дээр шинэ хууль гаргаж ирээд.

Зөвхөн энэ хуулиар үйл ажиллагаа явуулна гэвэл бичиг цаас бүрдүүлж, тендер шалгаруулах хугацаа нь 1.8 жил зарцуулахаар байгаа юм. Энэ хуулийг ингээд судлаад үзэхээр.

Тэгээд ийм байдлаар явна гэвэл энэ бол одоо үнэхээр Монгол Улсын бүх бүтээн байгуулалтуудыг, ялангуяа хамтарсан Засгийн газар өмнөх том бүтээн байгуулалтуудаа үргэлжлүүлбэ гэж байгаа дээр бид ингээд бүх юмаа хаачхаж байгаа юм.

Б.Энхбаяр сайдын.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Б.Дэлгэрсайхан сайдад 1 минут өгчихье.

**Б.Дэлгэрсайхан:** Жишээлбэл, Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтад өмнөх хууль, эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн зарим хэсэг хүчин төгөлдөр үйлчлэх тодорхой нөхцөл тохиолдолд, мөн хуулийн 27.6 дахь заалтад хууль буцаж үйлчлэх онцгой тохиолдлыг хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт тусгахаар зохицуулсны дагуу Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд. Энэ хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалт зарласан тохиолдолд шалгарсан этгээдтэй Концессын тухай хуулийн дагуу концессын гэрээ, дагалдах гэрээг байгуулна гэх агуулгыг тусгаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Иймд дээрх хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн хуульд нийцэж байгаа юм. Б.Энхбаяр гишүүн ээ.

**Ц.Даваасүрэн:** Тодруулах юм уу? Б.Энхбаяр гишүүн тодруулъя. Т.Доржханд гишүүн.

**Б.Энхбаяр:** Ингээд байгаа юм. Хүчингүй болчихсон хуулийг хэрэглэнэ гэдэг хууль байхгүй.

Үүнтэй маргаад байх. Энэ дээр ажил нь ингэж байсан юм гэж тэр ямар ч үндэслэл байхгүй.

Монгол Улсад хүчингүй болчихсон хуулийг хэрэглэнэ гэдэг хуулийн төсөл орж ирж таарахгүй. Үүнийгээ татаж авах ёстой.

Хоёрдугаарт, ер нь төсөл, хөтөлбөрүүдийг илүү нээлттэй, илүү шударга, илүү олон оролцогчтой, илүү

хөнгөн шуурхай, илүү авлигагүй шийддэг байх. Энэ бол хамтарсан Засгийн газрын нийтлэг зарчим.

Тэгвэл тендерийн хуулийг хэрэглэхгүйгээр энэ бүх төслүүдээ хэрэгжүүлбэ гэдэг зарчим орж ирж байгаа юм. Нэг.

Хоёрдугаарт, үүнийгээ Улсын Их Хурлын буюу ард түмний төлөөллийн дээд байгууллагаас хаалттайгаар оруулахгүйгээр шийдэх гэж байгаа.

Нэгд. Цахилгаан станцын төсөл ч орж ирэхгүй. Улсын Их Хурал дээр. Бүгдийг нь Засгийн газар шийдэх гэж байгаа юм.

Ингэхдээ тэр.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Т.Доржханд гишүүн.

**Т.Доржханд:** Би Б.Энхбаяр гишүүний асуултад яг тодорхой хариулчихмаар байгаа юм. 1 минут юм уу? Тийм ээ.

Одоо тухайлбал яагаад энэ төрийн өмчийн компаниудын. Тухайлбал, 10 тэрбумаас дээш нийгмийн болон хөрөнгө оруулалтын төслүүдийг авах гээд байгаа юм бэ гэдэг асуулт байна. Яг зөв асуулт байхгүй.

Яагаад вэ гэхээр та бид хоёр аягүй сайн мэдэж байгаа. Яг түрүүчийн хэлдэг жишээ байхгүй юу. Эрдэнэс Тавантолгой дээр бид ямар их хэмжээний хөрөнгө оруулалт түүгээрээ явчихлаа.

Улсын төсөв дээр бид 3 их наядын асуудал ярьдаг байхад тэнд чинь 18 их наядын асуудал дээр нэг захирал гарын үсэг зурдаг байсан юм шүү дээ.



Тэгээд л түүгээрээ шууд гэрээ байгуулаад л явдаг. Та ч мэдэхгүй, хэн ч мэдэхгүй. Бүгд ийм байсан.

Тэгвэл үүнийг чинь хийдэг байгууллага нь юу юм бэ гэхээр олон улсад энэ нэгдсэн прокурементийн тийм байгууллага нь байдаг. Ил тодоор явуулдаг.

Яг энэ гараа руугаа бид орчихсон байхад энэ байгууллагаараа хийлгэдэггүй. Тэнд баахан прокуремент хийгээд байгаа юм нь авлигыг бий болгоод байгаа юм.

Нэг бол энэ байгууллагыг татан буулгаад өөрсдөө дураараа яв л даа. Үгүй бол энэ мэргэжлийн байгууллагаар нь хийлгэ гэдэг ийм л асуудал байгаа юм.

Тэгээд түүрүүчийн хэлдэг энэ.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Гол асуудал ингээд байна шүү дээ. Та нар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийнхаа 7 штрих дээр өмнө нь үйлчилж байсан концессын хуулийн дагуу гэрээ байгуулна гэхихсэн байхгүй юу.

Гэтэл концессын хууль чинь хүчингүй болчихсон гээд. Тэгээд та нар болохоор Хууль тогтоомжийн хуулийн дагуу онцгой тохиолдолд хуулийг буцаан хэрэглэх гэсэн заалтыг л ашиглаад байна уу л гэдэг асуудал шүү дээ.

Б.Дэлгэрсайхан гишүүн. Тийм ээ тийм. Дутуу байх юм бол. Б.Дэлгэрсайхан гишүүн.

**Б.Дэлгэрсайхан:** Үгүй ээ. Б.Энхбаяр гишүүн ээ. Хардаж болно оо.

Тэгэхдээ бас учир байна шүү дээ. Энэ чинь. Хуучин хуулийг байхад хэрэглээд, тэр хуулийн дагуу шалгаруулчхаад байгаа юмыг л явуулъя гэж байгаа болохоос биш таны унтчихсан үйлчлэхгүй хуулийг сэргээе гэж яриагүй шүү дээ.

Ингээд мушгиж юмыг гацаах юм яриад байх юм. Та бас ялгаж салгаж ойлго л доо.

Түүнээс биш хуучин хуулийн үед хуучин хууль чинь байх үед ямар нэгэн процесс явна биз дээ. Шалгаруулах ч юм уу, ингээд сонгон шалгаруулалт хийсэн байгаа байхгүй юу. Тэр процессоо л үргэлжлүүлье гэж байгаа байхгүй юу.

Хэрэв энэ процесс үргэлжлэхгүй бол энэ шалгарчихсан компаниуд төрөөс нөхөн төлбөр нэхнэ шүү. Үүнийг би хэлчихье.

**Ц.Даваасүрэн:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хуулийнхан байна уу? Концессын өмнөх хүчингүй болчихсон байгаа хуулийн дагуу гэрээ байгуулна гэхихсэн байхгүй юу.

Хууль нь хүчингүй болчихсон уу. Болчихсон. Тэгэхдээ Хууль тогтоомжийн тухай хуулиар онцгой тохиолдолд хүчингүй болсон хуулийг буцааж хэрэглэх нэг заалт бий. Түүгээр оруулж ирээд байгаа юм уу, яагаад байгаа юм гэж.

Түүнээс биш энэ хүчингүй болчихсон хуулийн дагуу гэрээ байгуулна гэхээр чинь асуудал үүсчээд байна шүү дээ. Байна уу? Хуулийнхнаас. Аан..?

Д.Саруул хариулъя. Хэрэг эрхлэх газрын 3 номерын микрофон дээр очоод ярьчих.

**Д.Саруул:** Гишүүний асуултад хариулъя.

Хууль тогтоомжийн тухай хууль дээр бол тухайн хууль буцаан хэрэглэх буюу хүчингүй болсон хуулийн зарим заалтыг онцгой нөхцөлд хэрэглэхийг дагаж мөрдөх журмын тухай хуульд тусгаж болохоор оруулсан.

Энэ тохиолдолд шинээр оруулж ирж байгаа хууль биш. Өөрөөр хэлэх юм бол Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад энэ зохицуулалтуудыг тодорхой зааж өгч байгаагаар.

Хэрвээ үүнийг бүр нарийвчлах шаардлагатай гэж үзэж байгаа бол нөхцөлүүдийг бид бас энэ дотроо тусгах боломжтой юм байна.

Тэгэхээр магадгүй хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг ажиллавал энэ дээрээ бас тодруулах боломжтой гэж харж байна.

**Ц.Даваасүрэн:** Миний хэлж байгаагаар нөгөө Хууль тогтоомжийн тухай хуулийн 27.1.6-г яриад байна уу? Тийм ээ.

Тэгэхээр тэр “онцгой тохиолдол” гэдгийг нь юу гэж тайлбарлаж байгаа юм?

3 номерын микрофон.

**Д.Саруул:** Өмнө нь яг Концессын тухай хуулиар гэрээ байгуулчихсан

байсан тохиолдлуудыг бол энэ дотор хамруулж..

**Ц.Даваасүрэн:** “Гэрээ байгуулна” гэж байгаа байхгүй юу.

Биш ээ биш. Энэ хууль дээр чинь байна шүү дээ. Концессын хуулийн дагуу концессын гэрээ, дагалдах гэрээг “байгуулна” гэхихсэн байгаа байхгүй юу.

Би энэ оруулж ирсэн хуулийг чинь яриад байна шүү дээ. Байгуулчихсан байгаа бол өөр хэрэг. “Байгуулна” гэхихсэн байхгүй юу.

Болчихсон уу? Тэгвэл ажлын хэсэг дээр үүнийг дахиж.

Б.Энхбаяр гишүүн хариулт дутуу учраас дахин тодруулъя гэж байна.

**Б.Энхбаяр:** Энд би маллагдахгүй ээ. Намайг Хууль зүйн сайдаар ажиллаж байхад 2 удаа энэ төслийн үзэл баримтлалыг нь батлуулах гэж оролдсон юм.

Би үхсэн хүнийг амилуулдаггүй юм. Хууль зүйн техникт хүчингүй болчихсон хуулийг хэрэглэдэг зүйл байхгүй ээ гээд батлаагүй юм.

Үүнийг би мэдэхгүйдээ асуугаад байгаа зүйл биш. Л.Гантөмөр сайд аа.

Энэ тендерийн хуулийн өөрчлөлтийг сая хэлээд байгаа. Одоо ер нь нэг цогцоор нь авч үзье гэж байгаа бол төсөв дагуулж биш бүтнээр нь оруулж ирж байж ярих ёстой. Төсөв дагуулж хулгай хийх хэрэггүй.

Одоо энд зааснаар тэр шууд “хэлцлийг тооцох журмыг нь тухайн сайд нь батална” гээд ороод ирчихсэн байгаа.

Энэ том төслүүдийг тендер шалгаруулалтыг нь хийх гэж байгаа сайд өөрөө ямар шалгуураар шалгаруулах вэ гэдэг журмыг баталдаг байж таарахгүй. Энэ бол авлига болно. Авлига болно шүү.

Сая хэлээд байгаа биз дээ. Ерөнхий сайд, Их Хурлын дарга. Журмаар.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Ж.Батжаргал гишүүн асуултаа.

Тэгэхдээ саяын тэр хуулийн нюансуудыг байдаг ажлын хэсэг дээр хэдүүлээ сайн яриад зохицуулалтуудыг нь хийж өгье.

Ж.Батжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Дагасан хуулиуд дээр хоёр, гуравхан зүйл байгаа юм.

**Нэгдүгээрт,** Төсвийн тухай хуулиа төсөл боловсруулах, өргөн барих цаг албартаа өөрчлөлт оруулах гээд ороод ирчихсэн юм билээ.

Ер нь Их Хурлын гишүүдийн гэдэг юм уу, ер нь Их Хурлын өөрийнх нь мэдэх эрхийг жоохон нэмэгдүүлээд, төсөв батлах үйл явцаа нэлээн чадваржуулах үүднээс 10 сарын 01-ийг 9 сарын 01 болгож нааш нь татсан юм.

Тэгээд түүнийг буцааж 10 сарын 01 болгох санал орж ирээд байгаа юм билээ. Учир шалтгаан нь юунд байгаад байгаа юм.

Их Хурлын өөрийнх нь бас Үндсэн бүтцийн байгууллагууд өргөн баригдсаных нь дараа тодорхой дүн шинжилгээнүүд хийж, дүгнэлтээ гаргах. 10 сарын 01-нээс Их Хурал яг төсвөө хэлэлцэж эхлэхээр ийм л цаглавар л хийсэн л дээ.

Тэгээд энэ дээр ийм асуудал орчхоод байгаа юм билээ. Үүний учир шалтгаан нь юунд байгаа юм гэж? Нэг ийм зүйл.

**Хоёр дахь зүйл.** Тэр баялгийн сангийн 2024 оны төсвийн төлөвлөгөө орж ирээд байгаа юм. Түүн дотор **“Ирээдүйн өв сан”** бол **“Тогтворжуулалтын сан”** руугаа таталт хийчхээд өнөө АМНАТ-аасаа буцаагаад 65.0 хувь нь “Ирээдүйн өв сан” руугаа явдаг шиг би санаад байгаа юм.

Гэтэл энэ төсвийн юу руу 20.0 хувь гэсэн юу орж ирчхээд байгаа байхгүй юу? Тэр 700 хэдэн тэрбум төгрөг чинь.

Тэр цаад зөрүү 45 пункт хаана ямар байдлаар байрших гээд байна вэ? Би тэгж ойлгоод байх юм. Буруу ойлгоод байна уу? Энэ дээр нэг тодорхой хариу авчихмаар байна гэж.

**Гурав дахь зүйл.** Энэ худалдан авах ажиллагаатай холбоотой нэлээн юм яригдаад байгаа юм. Ер нь байнгын л нэг ийм юм яригдаад байдаг. Хаа хаанаа. Нэг хэсэг нь учиргүй хамгаалаад ч байгаа юм шиг, нэг хэсэг нь хулгай хийх гээд ч байгаа юм шиг. Ингэж нийгэмд хэдүүлээ янз бүрийн ойлголт өгөөд хэрэггүй.

Үүнийг ажлын хэсэг дээрээ нэлээн нухацтай судалж судалж үзэж энэ үндэсний эрх ашиг юманд чинь нийцтэй байх, эргээд энэ том бүтээн

байгуулалтуудын чинь ажилд цаг алдахгүй явах, тэр дотор нь бас янз бүрийн гар хуруу орчихгүй байх, тэр ил тод байдал энэ тэрийг нь хангаж болох ямар хувилбар байгаад байгаа юм.

Яг нарийндаа одоо энэ хуулийг унших юм бол нэг хэсгийг нь хэдүүлээ бага үнийн дүнтэй төсөв тавьж байгаад тендер зарлаад хоёр удаа хүн орж ирсэнгүй гээд төрийн өмчийн компаниудад өгчих нэг ийм бололцоо бүрдүүлээд өгчхөж байгаа юм.

Нөгөө талд нь жоохон том дүнтэй юмнуудаа болохоор зэрэг гаднын хүлээн зөвшөөрөгдсөн дэлхийд танигдсан компаниудыг урилгаар оруулж ирнэ гэж хэлээд юм хийх бололцоо хийх гээд байгаа байхгүй юу.

Одоо тэр 10 аймгийн дулааны станцыг хар. Солонгосын компани орж ирээд юу хийв ээ.

**Ц.Даваасүрэн:** Хэн хариулах вэ?  
Б.Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Тийм. Ж.Батжаргал гишүүний асуултад хариулья.

Тэр цаглаварын хувьд хэдүүлээ ийм байна аа. Бид бас өмнө нь ярилцаж байгаад л нэг туршаад үзье гээд л хийцгээсэн л дээ.

Тэгээд амьдрал дээр үнэхээр бас болохгүй байна. Хэдүүлээ үүнийг бас нэг наана цаанатай хараад өгөөч ээ гээд би хичээнгүйлэн хүсээд байгаа юм.

Одоо би нэг л жишээ хэлье. 7 сарын 25-н гэхэд бүх сайд нар, төсвийн ерөнхийлөн захирагч нар дараа жилийнхээ бүх тоо, төслүүдээ Сангийн яаманд хүргүүлсэн байх ёстой. Зэрэгцээд

Их Хурал руу, Байнгын хороо руу хүргүүлсэн байх ёстой ийм цаглавартай болчихсон. 7 сарын 25-нд шүү.

Гэтэл хагас жилийн макро тоонууд маань, 6 сарын тоонууд маань 7 сараас хойш ер нь гарч амжаагүй байдаг.

8 сар гарч байж тоонууд маань гардаг. Төлбөрийн тэнцлээс эхлээд л статистикууд бүгд ингэж 8 сар гарч гардаг байхгүй юу.

Гэтэл хагас жилийнхээ гүйцэтгэлийг хараагүй сайд нар маань, төсвийн ерөнхийлөн захирагч нар маань дараа жилийнхээ бүтэн төлөвлөлтийг хийнэ гэдэг бол бараг боломжгүй асуудал юм байна.

Өнөөдөр 8 сарын 15-н гэхэд Сангийн яамнаас Засгийн газар луугаа ирэх оныхоо төсвийг өргөн барьчихсан байх ёстой байгаа юм.

Яах вэ, бид эхнийхээ төсөл дээр ярилцаж байна л даа.

Энэ жилийн хувьд тодотгол, ирэх жилийн төсөв, бүх юм давхцаад нэлээн юутай л байна. Жоохон сандруудуу л байна.

Тэгээд 10 сарын 01-ийг 9 сарын 01-н болгодог өөр нэг шаардлага нь нөгөө хэлэлцүүлэг. Олон нийтийн хэлэлцүүлэг гээд байгаа юм. Байж болно л доо.

Ер нь хяналт гэдэг бол өөрөө ил тод байх тусмаа л хэрэгждэг ийм зүйл.

Гэхдээ үүнийг Их Хурал дээр ч гэсэн бас хэлэлцүүлж болох юм байгаа юм. Өөрөөр хэлбэл яг төлөвлөх шатдаа хоорондоо холилдчихоод байгаа юм.

Төсөв маань өөрөө ер нь 3 шаттай байдаг. Засгийн газар төлөвлөх үүрэгтэй. Их Хурал үүнийг батлах бүрэн эрх нь тэнд байдаг. Дараа нь Засгийн газар үүнийг гүйцэтгэлээр хангах бүрэн эрхтэй.

Одоо жишээ нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс одоо бид 2025 оныхоо тоог гаргаж амжаагүй байхад тийшээгээ тоо хүргүүлээд, төсвийн хүрээний мэдэгдэл, энэ бүх юмнууд дээр тэндээс санал аваад. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын бүтцийн байгууллага Засгийн газрыг төсвөө төлөвлөх шатад нь бас ингэж наана цаана оролцдог болчихсон ийм зүйлүүд ч байгаад байгаа юм.

Тэр хэсгийг нь бид хөндөөгүй ээ. Улсын Их Хурлын бүрэн эрх гэж.

Харин тэр цаглаварын хувьд бол үнэхээр яг төлөвлөх шатдаа давчуу болчихоор түүхий, бүрэн боловсруулагдаагүй, эрсдэлүүд бас дагуулж болзошгүй ийм л төсөв явах гээд байгаа юм.

Тийм учраас Их Хурал дээр бага хэл амтай давъя гэвэл төлөвлөх шат дээрээ алдаагүй чамбай боочихсон төсвөө л явуулчихдаг. Тэр нь тэгээд Их Хурлын гишүүддээ, Их Хурал дээр түвэг удчихгүйхэн шиг цаашаа явчих энэ байдлуудыг харгалзаад л энэ хугацаагаа хуучнаар нь тавьж өгөөч ээ л гэдэг ийм хүсэлт байгаа юм. Өөр энд янз бүрийн шалтгаан юу байх вэ. Тийм.

Тэгээд ч ер нь бас амралтын сезон давхацчихаад. Одоо Сангийн яамнаас өөр ажиллаж байгаа, бүтэн ажиллаж байгаа яамд яг 7, 8 сард байдаггүй байхгүй юу. Тэгээд тэндээ хүчин чадал, хүн нөөц багатай, ихэнх нь амарчихсан ийм үед

тэгээд их л түүхий, яаруу сандруу л нэг ийм л юм болчих гээд байна.

Тийм учраас үүнийг нэг эргэж харж өгөөч ээ л гээд байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Худалдан авахтай холбогдолтой нь. Худалдан авахтай холбогдолтой юман дээр үү? Т.Доржханд хариулсан нь дээр байх.

**Т.Доржханд:** Тэгэхээр Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Зөв зөв. Нийгэмд бид буруу ойлголт өгч болохгүй. Үнэн. Нэг нь хуулиар шууд худалдан авалт хийх гээд байгаа юм шиг. Нөгөө хэсэг нь үгүй гэсэн байдалтай биш.

Ямар нэгэн ялгамжтай зүйл огт байхгүй. Тэгээд энэ зохицуулалтууд нь мэдээж энэ дээрээ Их Хурлын түвшиндээ яригдаад явна. Засгийн газрын түвшинд.

Тухайлбал, Б.Энхбаяр гишүүний асуултад нэмж хариулахад. Бид Оюу Толгойн гэрээ байгуулаад явлаа гэхэд үнэхээр тусгай ур чадвар хэрэгтэй байгаа байхгүй юу.

Гэтэл тэр хүнийг тендерийн хуулиар явна гэхээр цаг хугацаа алдчихдаг. Түүнээс болоод их хэмжээний алдагдал үүрчхээд байдаг. Жишээ шүү. Нэг жишээ.

Тэгвэл үүнийгээ бид Засгийн газар дээрээ ярьж байгаад, жагсаалтыг нь гаргаж байгаад энэ хүмүүсийг ийм байдлаар явъя гэсэн байдлаар оруулж ирж байгаа.

Энэ бол одоо том хэмжээний бүтээн байгуулалт.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Б.Дэлгэрсайхан гишүүн тодруулах юм уу? Баялгийн санг дараа нь. Б.Дэлгэрсайхан гишүүн нэг тодруулах юм байвал тодруулчих.

Тэгээд дараа нь Б.Жавхлан гишүүн Баялгийн сангийн асуултыг. Б.Дэлгэрсайхан гишүүнийн микрофоныг.

**Б.Дэлгэрсайхан:** Ер нь Т.Доржханд гишүүний ярьж байгаа. Сая дутуу хэлээд микрофон нь хаагдчихлаа л даа. Зөв байна.

Тэгээд мөн ялгаагүй би энэ Ж.Батжаргал гишүүний ярьж байгаатай бас санал нэг.

Тэгэхдээ би ганцхан жишээ ярья. Энэ уржигдар шөнө 2 цагт энэ ярьсан болохоор ихэнх гишүүд сонсоогүй өнгөрчихсөн байх.

Одоо бид Гашуунсухайт-Ганц модны боомттой холбож чадахгүй бүтэн 1.6 жил болж байна.

Хятад талтай очоод ярьчихсан. Ярьдаг. Үгүй ээ, та нар одоо энэ компанитай гэрээ хийгээд ингээд наадхаа холбоо гэдэг.

Гэтэл манайх энэ урд хөршөөс нэг гаргасан төсөл. Манайх юу гэж ярьж байна вэ гэхээр 700-аас 800 сая ам.доллороор үүнийг хийнэ гэж байгаа юм.

Монгол тал бол оролцогч нь Тавантолгой төмөр зам, Хятад тал нь “Чайна Энержи” компани байх жишээтэй.

Тэгэхээр Хятад тал ямар болзол тавьдаг вэ гэхээр зэрэг бид энэ

холболтын зөрүү, янз бүрийн ажлыг хийж гүйцэтгэе. Гэхдээ танайхаас нэгдүгээрт нүүрсний ам авъя. Хоёрдугаарт, нүүрсээ өөрөө олборлоно. /минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Болно оо, болно. Б.Жавхлан сайд.

Баялгийн сангийн тоог тэндээс хариулъя. 5 номерын микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг Улсын Их Хурлаас 2024 оны 4 сарын 19-нд баталсан.

Баялгийн сангийн хууль дээр таны хэлсэн 65.0 хувь, АМНАТ-ын 65.0 хувийг хуваарилна гэсэн заалт байгаа.

Мөн Баялгийн сангийн хуулийг баталсан энэ өдрөө Баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хамтад нь баталсан.

Энэ хуулиар 2024 онд 20.0 хувь байна гэсэн заалтыг бас давхар баталсан.

Тэгэхээр яг энэ зохицуулалтынх нь дагуу бид 2024 оны төсвийн тодотгол дээр тусгаж орж ирсэн.

Мөн Баялгийн сангийн тухай хуулийг батлахдаа дагаад Улсын Их Хурлын тогтоолоор төсвийн тодотголын саналыг бас оруулж ирэх заалт байгаа.

Түүгээрээ Баялгийн сангийн хуулийг оруулж ир гэж заасан байгаа.

Тэр дагуу бид Баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийг оруулж ирсэн.

**Ц.Даваасүрэн:** Г.Ганбаатар гишүүн. Тодруулах юм уу? Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

**Ж.Батжаргал:** Үгүй ээ. Наад юу чинь харин би ойлгоод л байна л даа.

65-тай гээд тов тодорхой бид төсвийн төлөвлөлтдөө тооцоо хийчихсэн улс байхгүй юу.

Гэтэл одоо мөнгөжүүлэх юман дээрээ болохоор зэрэг 20 пунктээр хийчхээд 45 чинь хаана очиж орох гээд байгаа юм бэ л гэдэг асуудал байгаа юм.

Тэр орон нутаг руу хуваарилагдах, тэр “Тогтворжуулалтын сан” руу орох чинь угаасаа 65-аас өмнөх үйл явц байхгүй юу. Тэгээд түүний үлдсэнээс 65-ыг нь “Ирээдүйн өв сан” руу татаж авах тухай л ойлголт байгаа юм.

Б.Дэлгэрсайхан гишүүний тэр яриад байгаа саяын кэйс дээр Их Хурал шийдвэрээ гаргаад өгчихсөн шүү дээ.

20 сая тонн нүүрсний чинь асуудлыг тов тодорхой шийдээд өгчихсөн.

Яах аргагүй Засгийн газрын өмнө гэдэг юм уу, тусгайлсан эрх зүйн орчных нь хүрээнд, хамтын ажиллагааны хүрээнд хүндрэл үүсвэл асуудлыг нь цаг алдалгүй шийдье гээд шийдээд өгчихсөн.

Цаашид дандаа ийм байдлаар явах гээд байгаа юм уу, яах гээд байгаа юм?

**Ц.Даваасүрэн:** Санал хэлчхэв үү? Та. Аан..? Санал хэлчихсэн үү? 5 номерын микрофон. Дахиад хариулъя.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Одоо мөрдөгдөж байгаа хуулийн дагуу АМНАТ-ын орлого орж ирэхээр эхлээд тэнцвэржүүлсэн үнээс дээш хэсэг нь Тогтворжуулалтын сандаа ороод, дараагийн хэсгээс нь 10 хувь нь Орон нутгийн хөгжлийн сандаа ороод, үлдэх хэсгээс нь 20 хувийг нь бид Ирээдүйн өв санд хуваарилж байгаа.

Үлдсэн хэсэг нь улсын төсөвтөө орж явж байгаа. Ийм хуваарилалтаар орж байгаа.

Яг энэ дагуу 2024 оны Баялгийн сангийн хуулийг бичиж орж ирсэн байгаа.

Өмнөх үлдэгдлийн хувьд. Ж.Батжаргал гишүүн ээ, өмнөх үлдэгдэл нь байж байгаа. Энэ нь өөрөө Монголбанканд байршина гээд заачихсан байгаа. Монголбанканд бид байршуулаад явж байгаа.

**Ц.Даваасүрэн:** Г.Ганбаатар гишүүн асуултаа асууя.

**Г.Ганбаатар:** Өдрийн мэнд. Сүүлд учраас асуултауд ихэнх нь асуучихлаа.

Тэгэхдээ энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал дээр чинь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт, тэр аудитын дүгнэлт гарчхаад байхад ингээд л хэлэлцэх гээд л оруулж ирээд байх юм.

Хэлэлцэх асуудал дээр нь уг нь би бас түүрүүчийн Байнгын хороон дээр арай өөр л байр суурьтай л байсан.

Тэгээд энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл чинь одоо уг нь төсвийн сахилга бат, төсвийн тогтвортой байдалд хор уршиг учруулж байна уу гэдэг дээр дүгнэлт гаргуулдаг хараат бус Их Хурлаас байгуулдаг байгууллага биш билүү.

Тэгээд макро эдийн засгийн болон төсвийн тогтвортой байдалд ноцтой үр дагавар учруулахаар байна гэсэн дүгнэлтийнх нь гол заалт ирчхээд байхад л бид хэлэлцээд байх нь хэр зөв бэ гэдэг. Хоёр дахь асуудал нь.

Хоёр дахь нь санал юм даа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төр ер нь яг юугаа хийх юм. Хувийн хэвшилд юугаа хийх юм. Үүнийгээ тодорхой болгохгүй болохоор чинь өнөөдрийн маргааны, бидний Байнгын хурал дээр мэтгэлцээний чинь гол сэдэв болоод байгаа юм биш үү?

Ер нь хувийн хэвшил орж чадах салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төр оролцох ер нь хэр зохистой байдаг юм? Иймэрхүү.

Ер нь цаашдаа аудитын байгууллага, Төсвийн тогтвортой байдлынхаа зөвлөлийн дүгнэлтүүдийг авч хэлэлцэхгүй юм уу гэдэг ийм асуулт байна. Хэрэгтэй юм уу? Улсын Их Хурлаас ийм байгууллага тэгвэл байх.

**Ц.Даваасүрэн:** Б.Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Надаас асуусан юм уу? Гишүүний асуултад хариулъя.

Үгүй ээ. Байх ёстой шүү дээ. Байх ёстой гээд л хуульчилчихсан. Тэр дагуу дүгнэлтээ хийгээд. Бид сонсоод л явж байгаа юм. Тийм. Тэр дагуу ажлаа хийгээд л явах хэрэгтэй.

Зүгээр энэ дээр нэг ийм л нэг логик гарч ирчхээд байгаа юм.

Тогтвортой байдлын зөвлөл уг нь улс төржихгүй хүн шиг зөвлөмжөө өгөөд явмаар байгаа юм. Юу вэ гэхээр одоо үүсчихсэн байгаа нөхцөл байдал дээрээ эхлээд нэг дүгнэлтээ өгмөөр байгаа байхгүй юу.

Одоо тэр 6.4-өөр 6.1.2, 6.1.4 гээд энэ заалтууд чинь байхгүй болчихсон. Ард талынхаа заалтуудтайгаа бас хууль зүйн зөрчил гэж үзэх юм уу, эсвэл санаатай юм уу, санаагүй юм уу. Бүү мэд. Нэг ийм маш ойлгомжгүй байдал үүсчхээд байгаа юм.

Эрсдэл тэнд байгаад байгаа юм. Түүн дээрээ дүгнэлт хийгээд энэ чинь ёстой сайхан өөрчлөлт болсон байна. Яг болж байна гэвэл бид дахиж нэмж энэ өргөн барьсан юмнуудаа бүгдийг нь татаад авчихъя. Одоо яг байгаагаар нь ингээд явуулчихъя. Болохгүй юм байхгүй.

Эхлээд тэндээсээ дүгнэлт хиймээр байна.

Тэгэхгүй тэрийгээ давж ирээд өргөн барьсантайгаа ноцолдоод нөгөө сууриа харахгүй ингээд явчихаар ер нь тэрийг яг мэргэжлийн дүгнэлт гэж харах уу, юу гэж харах вэ гээд. Ингээд л нэг итгэл буурчхаад байна л даа. Тийм. Тэр талаас нь бас харна биз ээ.

Түрүүн гишүүд бас хэлж байсан. Тэр төрийн худалдан авах ажиллагааны



тухай хууль дээр одоо энэ томоохон бүтээн байгуулалт. Одоо бүр бид чинь хэдэн их наядын томоохон төслүүд явах гэж байна шүү дээ. Монгол Улс анх удаа.

Үүнийг даадаг манай дотоодын аж ахуйн нэгжүүд үнэндээ байхгүй. Төрийн компаниуд ч байхгүй.

Тэрийг чадавх бүхий олон улсад хүлээн зөвшөөрөгдөх компаниудад урилга өгөөд бүтээн байгуулах. Тэнд чинь нэг ийм “short-list” үүсгэх нь байна шүү дээ.

Тэрийг Засгийн газар дээрээ энэ жагсаалтаа ил тод яриад зарлаад явна гэж байгаа юм.

Гишүүд санал гаргаж байна лээ. Үүнийг тэгвэл Улсын Их Хурлаар батлуулаач ээ гээд. Түүнтэй 100 хувь санал нийлж байна. Одоо харин үүнийгээ тэр ажлын хэсэг дээрээ яриад зарчмын зөрүүтэй санал гаргаад Улсын Их Хурлаар үүнийгээ батлуулчихдаг болчихвол бүр амар. Тийм ээ. Бүр амар. Хардалт сэвдэлт байхгүй. Тэгээд явчихдаг бол үгүй ээ мөн амар. Түүнийгээ тэгээд хэдүүлээ нэлээн ажил хэрэгч байдлаар ажлын хэсэг дээрээ ярилцаад л явъя.

Тэгэхгүй энд бүр нэг болохгүй юм ороод ирчихсэн байгаа юм шиг янз янзаар ингэж яриад олон нийгэд буруу ойлголт өгөөд. Эндээсээ болоод бүр том ажлууд маань ч гацаад. Хамтарсан Засгийн газар маань ч гэсэн ид шидээ гаргаж чадахгүй ийм юм руу яваад орчих вий л гэж санаа зовж байна шүү. Тэгээд Улсын Их Хурлын гишүүд маань тунгаана биз ээ.

**Ц.Даваасүрэн:** Гишүүд асуулт асууж дууслаа.

Хууль хуулийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байвал нэрээ өгье. П.Сайнзориг гишүүний нэрийг оруулчихъя. Б.Түвшин гишүүний нэрийг оруулъя. Б.Түвшин гишүүний.

П.Сайнзориг, Б.Түвшин гишүүн. Ингээд энэ хоёр гишүүнээр тасаллаа.

Ж.Батжаргал гишүүн үг хэлье.

**Ж.Батжаргал:** Надад хоёрхон зүйл байна.

Нэгдүгээрт, дагасан хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг нь дэмжихье.

Ажлын хэсэг дээр тал бүрээс нь нэлээн нухацтай ярьж зөв болгож гаргах тухай асуудал байгаа юм. Би энэ талаас нь хандмаар байна.

Хоёр дахь зүйл. Энэ тогтворжуулалтын хуулиар сүүлийн хоёр, гурван өдөр янз бүрийн юм яриад болж өгөхгүй байна.

Энэ хууль өөрөө 6 дугаар зүйлээрээ тусгай шаардлагаа тавиад, тусгай шаардлагыг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдгээ 19 дүгээр зүйлээрээ хуульчилж өгсөн эд шүү.

Тэгээд 6.4 дээр асуудал авч үзэхдээ яах аргагүй хууль зүйн техник талаасаа үгийн алдаа гарсан юм билээ. Тэрийг бол энэ удаагийн Засгийн газрын өргөн барьчихсантай уялдуулж засах ёстой.

Гэхдээ үүгээр Монгол Улс өрийн хязгаар, алдагдлын хязгааргүй болчихсон тухай яриад байдаг нь худлаа шүү.

Наадах чинь нэгдүгээрт, Өрийн удирдлагын тухай хуулиараа зохицуулагддаг.

Хоёрдугаарт, Төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөллөөрөө зохицуулагддаг.

Улсын Их Хурал 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг батлаад өгчихсөн.

Түүн дотор төсвийн алдагдлыг 2 хувиар нь хийгээд өгчихсөн. Өрийн таазыг нь 60 хувиар нь хийгээд өгчихсөн.

Тэгээд үүнээс болоод улс балрах гэж байгаа юм шиг ийм мэдээлэл нийгэмд өгөөд байдгаа боль оо. Та минь ээ.

Энэ чинь хоорондоо хэдүүлээ хууль хоорондын агуулга, нийцэл энэ юмнуудаа бүгдийг нь хардаг.

Гэхдээ яах аргагүй 6.4 дээр хууль зүйн техник талаасаа үгийн алдаа гарсан байна лээ.

Харин Улсын Их Хурлын гишүүд энэ хуулийг илүү чамбай хэрэгжүүлэх үүднээс 6.1.5 гэдэг заалтыг оруулж ирсэн шүү. 6.1.2-ыг хөдөлгөж таарахгүй. 6.1-ийн хэд билээ. Нөгөө өртэй чинь. Тэрийг хөдөлгөж болохгүй. Нааш цааш нь 19-өөр хэрэгжих хугацааг нь зохицуулаад байгаа юмаа хийж болохгүй гэдэг асуудлыг 6.1.5-аар тов тодорхой хариуцлагын том заалт оруулж ирсэн.

Тийм учраас энд яах аргагүй тийм бодмоор юмнууд байна лээ.

Энэ заалтуудыг ер нь энэ удаагийн тэр Засгийн газраас өргөн барьчихсан Төсвийн тогтвортой байдлын хуульд

өөрчлөлт оруулах тухай хуулийг дагуулж ямарваа нэгэн эрх зүйн зөрчилгүй, хууль зүйн техник алдаагүй болгож гаргах ёстой. Энэ дээр санал нэг байгаа гэдгийг зориуд хэлмээр байна.

**Ц.Даваасүрэн:** Б.Энхбаяр гишүүн үг хэлье.

**Б.Энхбаяр:** Нэг онигоо байдаг юм л даа.

Нэг авлигачаас асуусан. Сайхан амьдрахад юу саад болж байна вэ гэж. Эрүүгийн хуульд саад болж байна гэж хариулсан байдаг юм. Хулгай хийх гээд байна шүү дээ.

Түүнтэй адилхан тендерийн хуульгүйгээр энэ бүтээн байгуулалтын гэрээ хэлцлүүдийг хийчихье гэдэг санаархал сүүлийн 4 жилд 4 дэх удаагаа орж ирж байгаа. 4 дэх удаагаа шүү. Ковидын хуулийг дагалдуулахаас эхэлсэн юм.

Тендерийн шинэ хууль 2023 оны 6 сард батлагдсан. Шинэчилсэн хэлбэрээр. Нэг жил болж байгаа. Дөнгөж.

Энэ хууль дээр ч энэ өөрчлөлтийг оруулах санаархал явагдсан. Улсын Их Хурлын 30 гаруй гишүүн нийлээд Улсын Их Хурлаас баталсан хуулийн хүрээнд Улсын Их Хурлын хяналтад явагдах ёстой гэдэг тэр үзэл баримтлалдаа үнэнч байж баталсан.

Миний мэдэж байгаагаар Ардчилсан нам, ХҮН намынхан тендергүйгээр ногоон автобуснаас эхлээд, ковидын төсөвтэй холбоотой асуудлаар хяналт тавих ёстой. Хяналтгүй явж байна гэдэг асуудлыг тавьж байсан.

Тэгвэл өөрсдөө эрх барьчаад 40 тэрбум долларын өртөг бүхий төсөл, хөтөлбөрүүдийг тендерийн хууль үйлчлүүлэхгүйгээр, Улсын Их Хурлын хараа хяналтаас гадуур, тендерийн хуулийг хэрэглэх үү, хэрэглэхгүй юу гэдгийг Засгийн газар өөрөө тэндээ бие дааж шийдэж мэдэх ийм хуулийн техниктэй хуулийн өөрчлөлтийг өргөн барьсныг миний бие дэмжихгүй.

Сая хэлж байна. Тендерийн хуулийг шинэчилсэн найруулга хэлбэрээр дараа нь оруулж ирнэ ээ гэж. Үгүй ээ.

Энэ өөрчлөлт батлагдах юм бол тэр өөрчлөлт, тэр санаачилга ямар ч шаардлагагүй.

Яагаад гэвэл үүгээр чинь угаасаа энэ асуудлуудыг бүгдийг нь нээлттэй тендергүйгээр хийе ээ гэдэг хуулиа бид одоо хэлчихсэн явж байгаа.

Дахиж хуулийн өөрчлөлт оруулж ирэхгүй. Яагаад гэвэл Засгийн газар амтшина. Л.Гантөмөр сайд та бол бал бурам шиг энд амтшина.

Яагаад гэхээр танаар орох бүх төсөл, худалдан авах ажиллагаанууд, төр, хувийн хэвшлийн түншлэлийн концессуудыг зөвхөн та өөрөө баталсан журмаар шийдэх гэж байна.

Засгийн газраар баталсан журмаар биш шүү. Нэг сайдын баталсан журмаар шийдэх гэж байна.

Нэг сайд тухайн санхүүгийн тэр чадавхыг яаж үнэлэх вэ гэдэг журмыг сайд өөрөө батална гэж байгаа байхгүй юу. Энэ өөрчлөлтөөр.

Засгийн газраараа ч оруулахгүй. Энэ бол Улсын Их Хурлын хяналтаас бүрэн гарах гэж байна.

Тийм учраас хамтарсан Засгийн газарт би юу хэлэх гэж байна вэ гэхээр энэ том төслүүдийг амжилттай, үр дүнтэй, хуулийн дагуу, авлигагүй хэрэгжүүлэх үндэс нь өөрөө нээлттэй, хяналттай, ойлгомжтой байдал байхгүй юу.

Улсын Их Хурлаасаа хааж нууж хийчхээд яаж нээлттэй, авлигагүй, тендер, яаж авлигагүй, араасаа нэхэл хатуугүй бүтээн байгуулалт хийх гэж байгаа юм.

Ганцхан Эрдэнэтийн 49 хувийн асуудал Улсын Их Хурлаас ороогүйн үр дагавар өнөөдөр тухайн шийдвэрийг гаргасан Ерөнхий сайд нь эх орондоо ирж чадахгүй урвагч болоод байж байгаа шүү дээ.

Тэгэхэд түүнээс дахиад 40 дахин том төслүүдийг одоо парламентаар оруулахгүй шийддэг хуулийн өөрчлөлтийн тухай яриад сууж байна шүү дээ.

Энэ өөрөө хүлээн зөвшөөрөгдөж чадах уу. Араасаа нэхэл хатуу. Цэвэр байж чадах уу. Үүний араас 40 түр хороо гарна шүү. Парламент. Хяналтын.

Энд шийдвэр гаргасан бүх сайд нар түр хороогоор орно.

Тэгээд аягүй бол энэ төслүүд нь.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Л.Гантөмөр гишүүн үг хэлье.

**Л.Гантөмөр:** Тийм. Ер нь Б.Энхбаяр гишүүний ярьж байгаа болгоомжлолууд бол зөв л дөө.

Б.Энхбаяр аа, чи сууж байгаад бас сонсчих.

Одоо бид ингээд нэгэндээ зориулж нэг нь үг хэлчхээд тэгээд орхиод гараад явдаг ийм зүйл байж боломгүй байгаа юм.

Яг үнэндээ хэн нэгэн хүн хулгай хийх гээд, тэгээд хэн нэгэн хүн их ажил бүтээх гээд зүтгээд байгаа зүйл ерөөсөө байхгүй шүү.

Монголд байгаа асуудлуудыг шийдье ээ л гэж байгаа юм. Энэ бол Засгийн газрын түвшинд ажлаа хийж байгаа хүмүүс нь ингээд ингээд шийдэгдэхгүй байна гээд зовлон жаргалаа яриад оруулж ирж байгаа төслүүд байгаа гэдгийг бүгдээрээ ойлгож хүлээж авах хэрэгтэй.

Л.Гантөмөр гэдэг хүн дээр ямар нэгэн тендер зарлагдахгүй ээ.

Энэ дээр Монгол Ардын намынхан маань тайван амгалан байж болно. Монгол Улсад явах том төсөл, хөтөлбөрүүд бүгдээрээ энэ үйл ажиллагааны хөтөлбөртэй жагсаалтаар орж ирээд танилцуулагдаад явж байгаа.

Энэ дотор хэн нэгэн хүн зохиогоод шинээр бодоод олчихсон зүйл энэ дотор ерөөсөө байхгүй.

Үнэхээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн дагуу явах юм бол жилийн дараа барилга байшин эхлэх гээд байна.

Тийм учраас барилга барьдаг, зам тавьдаг хүмүүс нь л яараад байхгүй юу. Бид цаг хугацаатайгаа уралдъя л гээд байна л даа. Энэ агуулгаараа энэ хуулийн төслүүд орж ирж байгаа юм шүү. Түүнээс биш.

Түрүүн Б.Энхбаяр гишүүн их тодорхой хэлж байна шүү дээ.

Ер нь энэ концессын хуулийг хүчингүй болгохдоо энэ хуулийн дагуу явж байсан ажлууд яах вэ гэдгийг хэн ч бодоогүй л байгаа байхгүй юу. Тийм сэтгэл дутсан.

Энэ явж байсан төрийн үйл хэрэг тасралтгүй явахын тулд энэ дагаж мөрдөх журмын хууль нь юу байх вэ гэдгийг хийгээгүй л байхгүй юу. Орхичихсон. Энэ тасалдлуудыг буцааж нөхөх болохоор нөхөлт хийж байгаа хүмүүсийгээ хардаж сэвтгээд байх шаардлагагүй. Үүнийгээ яг хуулийн дагуу ямар боломж байна. Боломж байхгүй бол зогсоож бас болно. Энд бол ямар ч асуудал байхгүй.

Тийм учраас энд хэн нэгнийг хулгай хийх гэж байна гэж хардахаас илүү би зүгээр сэрэмжлүүлэх хэлбэртэй саналууд гарч байна гэж ойлгож хүлээж авч байна.

Тэгэхээр үүнийгээ манай Төсвийн байнгын хороо Байнгын хороон дээрээ ажлын хэсэг гаргаад аль нь зөв байна, аль нь буруу байна. Яг тэр зам тавьж байгаа Замын сайд, тэр хотод юм хийх гээд байгаа тэр хотын дарга, Барилгын сайд, 20 минутын хотын сайд, Эрчим хүчний сайд гээд энэ гардаж ажил хийж байгаа хүмүүсээ Төсвийн байнгын хороо нэг дуудаж байгаад бүх төсөл болгон дээр сонсчихмоор юм байна. Ц.Даваасүрэн дарга аа. Ер нь сонсчихмоор юм байна.

Та ч өөрөө саяхан барилгын салбар дээр ажил хийж байсан хүн учраас. Тэнд ямар жаргал байна, ямар зовлон байна, ямар ажил нь болж байна, яагаад юм болохгүй байна.

Ер нь том бүтээн байгуулалт хийдэг тэр зүйлийн ард гарах уу, гарахгүй юу л гэдэг асуудал байгаа юм. Тэр утгаараа ер нь Төсвийн байнгын хороо энэ хуралдааны өдрүүдэд яг манай тодорхой салбар хариуцаж байгаа сайд нарыг дуудаж байгаад ер нь энэ төсөл, хөтөлбөрүүд дээрээ нэг тайлбар мэдээлэл авах нь их зөв байна шүү. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Байнгын хорооны гишүүд хуралдаа орж ирлээ.

Одоо ингээд хоёр гишүүн үг хэлсний дараа санал хураалт явна.

Г.Уянгахишиг гишүүн үгээ хэлье.

**Г.Уянгахишиг:** Би Төсвийн байнгын хорооны гишүүн биш. Тэгэхдээ санал, үг хэлэх хэрэгтэй гэж бодлоо.

Нэгдүгээрт, тав дахь өдрийн чуулганы хуралдааны төгсгөлд хэлсэн. Ер нь өнөөдрийн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа буюу нэмэлт, өөрчлөлтийн төсөл хэлэлцэгдээгүй, тэр батлагдаагүй байх үеийн зохицуулалтад өнөөдөр төсвийн хууль нийцэж байгаа эсэх талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Үндэсний аудитын газрын дүгнэлтэд тусгагдаагүй байна.

Өөрөөр хэлэх юм бол өнөөдөр хэлэлцэгдэх Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд заагдах тэр шалгуур үзүүлэлтэд нийцсэн байна гэдэг дүгнэлт байгаа юм.

Тэгэхээр мэдээж тэр дүгнэлт байх ёстой боловчиг чиг үүрэг нь өнөөдрийн хэлэлцэж байгаа үед, өнөөдрийн цаг хугацаанд хүчин төгөлдөр байгаа тэр хуульд энэ төсвийн тодотгол маань өөрөө нийцэж байна уу, үгүй юу гэдэг дээр дүгнэлт заавал өгөх ёстой.

Тэгэхээр тэр дүгнэлтийг агуулаагүй байгаа учраас тэрийг бас анхааруулж хэлмээр байна.

Уг нь тэрийг авмаар байна, нийцсэн эсэхийг нь мэдмээр байна.

Хоёрдугаарт, Концессын тухай хуулийн зүйл, заалт сая хөндөгдөж яригдаж байна л даа.

Тэгэхээр энэ дээр илүү нарийвчилсан байдлаар буюу концессын гэрээ байгуулагдчихсан бол тэртээ тэргүй гэрээ хэлцлийнхээ журмаар тухайн гэрээг байгуулах үеийнхээ хууль тогтоомжоор цаашаа үргэлжлээд явна.

Энэ дээр үүсэж байгаа асуудал нь Концессынхоо хуулиар тендер шалгаруулалт зарлаад, тэнд шалгарчихсан тохиолдолд аль журмаа барих ёстой юм бэ гэдэг юм өөрөө явах ёстой.

Тэгэхээр энэ нь өөрөө заавал хууль батлагдаж явах уу, эсвэл тухайн харилцаагаа зохицуулсан харилцаагаараа буюу хуулийн бусад хуулиуд үйлчилж явна шүү дээ. Энэ чинь өөрөө гэрээ хэлцэл рүүгээ орчхож байгаа учраас.

Тэгэхээр тэр тал руугаа орох ёстой юу гэдэг дээр хууль талаасаа бас нэлээн ярилцах ёстой болов уу. Тусдаа хууль байх уу. Өмнөх хуулиудынхаа

зохицуулалтаар үргэлжлээд явах боломж нь байгаа юу гэдэг дээр.

Гуравдугаарт, энэ 6.4 дээр байгаа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн.

Тэгэхээр 6.4, 19.9 хоёрын зөрчилдөөд байгаа шалтгаан нь 19.9 бол өөрчлөгдөөгүй буюу өмнөх хуулиараа, өмнөх контекстээрээ явж байгаа. Тэгэнгүүт 6.4-ийг ганцааранг нь 2024 оны 6 сарын 05-нд өөрчилчихсөн байж байдаг.

Уг нь энэ анхнаасаа “үе шаттайгаар хэрэгжүүлнэ” гэж байсан үгийг “үе шаттай” гэдэг нь байхгүй болчихсоноос болоод одоо өнөөдөр бид энэ 6.1-ийн хоёроо ашиглаж чадахгүй байдалд орчхоод байна шүү дээ.

Тэгэхээр энэ 6.4-ийг одоо жишээлбэл 19.9-тэй нийцэж 6.4-ийг өөрчилнө гэдэг асуудал бол байхгүй. Яагаад гэхээр 19.9 чинь бол дагаж мөрдөх журам учраас үндсэн нийтлэг заалт.

Тийм учраас 6.4-ийг бид заавал өөрчлөх ёстой буюу нэмэлтээр хуулийн нэмэлт, өөрчлөлтөө өргөн барьж байж 6.4-өө засаж байж өнөөдрийн бидний энэ яриад байгаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт чинь үр ашгаа үзүүлнэ.

Тэгэхээр үүнийгээ бид бас анхаарч ажиллах ёстой. Нэн яаралтай шийдэх ёстой асуудал гэж харж байна.

**Ц.Даваасүрэн:** Б.Түвшин гишүүн үг хэлье.

**Б.Түвшин:** Баярлалаа.

Тэгээд ер нь саяын хоёр, гурван саналууд давхцаж байна. 6.4-ийг нэмэлт, өөрчлөлтөөр өргөн барьж байж өөрчлөгдөнө гэж байгаа ойлгоц нь өөрөө зөв өө. Энэ бол нэмэлт төсвийн дагавар хуулиудаар өөрчлөгдөхгүй гэдэг ийм санааг агуулж байгааг бас ойлгох ёстой байх.

Хоёрдугаарт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бол Б.Жавхлан сайдын ирээдүйн ажлыг л их хамгаалж байгаа юм л даа. Б.Жавхлан сайд аа.

Ер нь энэ Төсвийн тогтвортой байдлын хууль бол таныг л хамгаалж байгаа хууль шүү дээ.

Өөрөөр хэлбэл энд өрийн таазыг хэд байлгах вэ, өрийг яаж тооцох вэ, төсвийн зардлыг хэтэрхий их огцом нэмэгдүүлэхгүй байх. Тэгээд ялангуяа энэ хуулийг анх эхлээд санал болгохдоо тэр **IFRS**<sup>[International Financial Reporting Standards]</sup> зарчим, нөгөө гаднын валютын сангаас эхэлж санал болгосон юм билээ шүү дээ.

Тэгээд манайхан л өөрсдөө 17, 18 удаа өөрчилчихсэн. Цаашдаа аль болох өөрчлөхгүй гэхээр.

Тэгэхээр ерөнхийдөө хоёр, гурван зүйлийг ойлгож байгаа шүү дээ. Одоо шинэ хот байгуулья гэдэг их хэмжээний зардал, хөрөнгө оруулалтын асуудлууд бас гарч ирэх гэж байна.

Энэ хэсэг дээр нь таны яриад байгаа нөгөө тусгайлсан байдлаар яг энэ хоттой холбоотой зардлыг арай өөр байдлаар шийдье гэж оруулаад, энэ удаагийн төсвийн тодотголоо одоо мөрдөж байгаа хуулийн хүрээнд нь оруулаад ирвэл танд ч бас хэрэгтэй, Монгол Улсын энэ төсвийн тогтвортой байдалд ч бас хэрэгтэй, одоо явж байгаа

энэ хөрөнгө оруулалт, төсвийн зардалд ч гэсэн шинэ тооцоолол орж ирэхгүй. Ер нь үйл ажиллагаа гацахгүй явах юм.

Хоёрт, тэр тендерийн хуулиудын тухай л яриад байна.

Ер нь өнөөдөр тулгарч байгаа асуудлыг хуулиар шийдээд ирээдүйдээ энэ чигээр нь үргэлжлүүлчхээр зөрчил үүсээд байгаа юм.

Өнөөдөр ерөөсөө тулгараад байгаа асуудлыг нэг удаагийн хуулиар бас шийдэж болно шүү дээ. Цаашдаа байнга тийм явна гэдэг дээр л зөрчил үүсээд байгаа юм.

Яг ийм ийм асуудлууд тулгараад байна. Үүнийг давж гарахын тулд нэг удаагийн шийдлээр явъя. Цаашдаа энэ асуудлыг шийдэх, тогтвортой мөрдөх хуулиудыг гаргая гэдэг асуудлыг л хоёр хуваачих юм бол өнөөдөр бидний яригдаад байгаа асуудал цаашаа шийдэгдчихээд байгаа юм.

Тийм учраас Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг хөндөхгүйгээр төсвийнхөө тодотголыг оруулж ирээч.

Энэ өнөөдрийн тулгамдаж байгаа асуудлыг цаашдаа хийх байнгын шийдэл биш. Нэг удаагийн шийдлээр оруулж ирээд төсвийн тодотголоо хэлэлцэх юм бол бидэнд илүү хэн хэнд нь илүү амар. Цаашдаа ч гэсэн Улсын Их Хурал бол өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд төсвөө тогтвортой байлгах энэ бодлогоо аваад үлдчих боломжтой байгаа юм.

Өнөөдөр бид гадаад орчны эдийн засгийн байдал тогтворгүй байна л гэж байна. Нүүрсний үнэ өнөөдөр гадаадад буугаад л эхэлж байна.

Ганц хоёрхон процентоор буусны дараа л манай Монгол Улсын төсвийн орлого хүндрээд ирнэ. Нөгөө өрийн харьцаа чинь хүндрээд ирнэ.

Ингээд л бид буцаагаад л ерөөсөө маш эрсдэлтэй орны тоонд ороод л, буцаад аягүй нөгөө “Standby” хөтөлбөртөө ч орж байх ийм эрсдэлтэй учраас энэ тавиад байгаа шалгууруудыг нь битгий хөндөөч ээ.

Тэр өнөөгийн үнэ цэнээр, нэрлэсэн үнэ цэнээр ч гэсэн бас бодлогын уралдаан явуулаач.

**Discount Rate** буюу тэр хасагдуулж байгаа хүү нь өнөөдрийн бид нарын зээлийн хүүгээс өндөр, бага байгаагаас хамаараад зээлийн хүүгээ оруулж тооцдог байх уу, зөвхөн үндсэн зээлээр нь байдаг байх уу гэдэг хоёр тооцооллын арга байгаа.

Энэ дээр бас ирээдүйн эдийн засгийн төлөв байдлыг харуулж байгаад энэ аргаар өөрчилчих юм бол манай Сангийн яамны орж ирж байгаа саналыг мэргэжлийн хороогоор хэлэлцээд цаашаа явуулчих бас бүрэн боломжтой байгаад байгаа юм.

Тэгэхээр асуудал юундаа байна вэ гэхээр өнөөдрийн тулгамдаж байгаа асуудлыг ирээдүй рүү байнгын энэ байдлаар шийд мэдэх гэж биш, үлдээхийг нь үлдээгээд, харьцаа барихыг нь бариад, хотын асуудлыг тусад нь оруулж ирэхэд ямар ч Их Хурлын гишүүн энэ хэмжээний хөрөнгө оруулалт, төслийг ойлгоно шүү дээ гэдэг ийм горимын саналтай байна.

**Ц.Даваасүрэн:** П.Сайнзориг гишүүн үг хэлье.

**П.Сайнзориг:** Баярлалаа. Бүгдэд нь бас өдрийн мэнд хүргэе.

Төслүүдийг хэлэлцэхийг бол дэмжиж байна. Мэдээж гишүүдийн зарим ярьж байгаа зүйлүүдийг бид анхаарч болно.

Тэгэхдээ нэг зүйлийг хэлмээр байгаа юм. Энэ хуулиудыг дагаж байгаа тэр худалдан авах ажиллагааны хуулиудын проблемыг яг л энэ гүйцэтгэх засаглал гэдэг юм уу, энэ яамдад ажиллаж байсан хүмүүс хэлэх байх.

Жишээ нь, тодорхой Арбитрт дуудагдаад зөвлөх үйлчилгээний тендер авах гэхээр ашиг сонирхлын зөрчил гэдэг дэлхийн томоохон хөрөнгө оруулагчидтай энэ санхүү, хуулийн компаниуд бараг бүгд холбогдчихсон байдаг.

Үүнээс тойрч гарах гэдэг юм уу, нээлттэй сонгон шалгаруулалтаар явах юм бол ямар ч зөвлөх үйлчилгээг бид авч чадахгүй.

Өөрсдөө энэ асуудлаа нарийн ширийн ярина гэхээр бас хэцүү.

Магадгүй бидний цаашдаа хөрөнгө оруулалтын гэрээ хэлцлүүд, эргээд энэ томоохон бүтээн байгуулалтын **PMС**<sub>[project management consultancies]</sub> шалгаруулах энэ зүйлүүд дээр зөвлөх үйлчилгээний асуудлыг бид бас тодорхой хэмжээнд, түрүүн Б.Жавхлан сайдын хэлдэг шиг **shortlist** үүсгэх байдлаар шийдэхгүй бол энэ одоо гадаад худалдааны бодлоготой ч холбоотой зүйлүүд үүснэ.

Бид хэд зөвлөх үйлчилгээ болон барьж байгуулах бүх үйл ажиллагаагаа нэг улсын харьяалалтай компанид

өгчихвөл яах вэ гэдэг асуудал хүртэл цаана нь байдаг.

Тэгэхээр энэ худалдан авах ажиллагааны ганцхан хэлбэр дээр бид муйхарлаад байж ерөөсөө болохгүй. Бүх юм нь зөвхөн бага үнийн дүн өгснөөр шалгардаг гэдэг энэ зүйлээсээ бид бас татгалзах ёстой юм.

Маш олон худалдан авах ажиллагааны хэлбэрүүдийг бид хэд орхигдуулж ирсэн. Энэ орхигдуулсан учраас энэ **“ноу хау”** хөрөнгө оруулалтууд Монгол Улсыг тойроод байна.

Энэ нээлттэй тендерийн чинь цаана үндсэндээ шалгарах эсэх нь хамаагүй, шалгарахгүй компаниуд гомдол гаргаж нөгөө шалгарч байгаа компаниудад шантаажилдаг энэ үйл ажиллагаа практик дээр зүгээр битүү шүү дээ.

Үүнээс илүү хулгай явж байгаа. Үүнийг чинь зогсооно. Үүнийг хаахын тулд бас шинэ худалдан авах ажиллагааны хуулиар 10 хувийн хураамж төлөөд яв гэсэн. Энэ бол тэр том төслийг зогсоож байгаа компанид бол зүгээр жижигхэн дусал юм билээ. Энэ цаана нь магадгүй зарим хөрш орнуудын зарим салбар, эдийн засгийг дэмжих бодлоготой ч орж ирдэг.

Тэгээд энэ зүйлүүдээсээ хэн яг эцсийн дүнд хохирдог вэ гэхээр ард түмэн л хохирч байгаа.

Тэгэхээр бид хэд энэ дээрээ одоо жоохон бодолцохгүй бол бас янз янзын үгээр хэлэхээр одоо бүх л зүйлийг хулгай хийх гэж байгаа ийм зүйл бол байж болохгүй ээ.



Тэгэхээр үүнийгээ гишүүд маань бас бодолцоосой гэж хүсэж байгаа.

Хоёрдугаарт, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг батлахдаа энэ концессын хуулиар үргэлжилж явж байсан харилцааг яах вэ гэдгээ орхигдуулсан нь үнэн байна.

Улсын Их Хурал алдаа гаргасан.

Бид хөрөнгө оруулагчдын итгэлийг цаашаа түлхэж болохгүй. Нэг явж байснаа одоо ингээд.

Тэгэхээр үүнийгээ бас баттай шийдээрэй.

Би бас яах вэ сайн жишээг бас хайх гээд үзлээ. 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдөр Цагдаагийн албаны хуулийг баталж байсан юм. Энэ хуулийг батлахдаа дагаж мөрдөх журмын хуулийн бас батлахгүйгээр яваад 1993 оны Цагдаагийн албаны хуулиар явж байсан харилцааг нь дараа жил нь буюу 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр нөхөж дагаж мөрдөх журмын хуулийг нь гаргаж байсан тохиолдол ч бий.

Тэгэхээр Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөхүүд маань энэ гишүүдийг ингэж хэрэлдүүлэхгүйгээр бас энэ ажлаа бас хийгээч ээ.

Засгийн газрын хуулийнхан бас ажлаа хийгээч ээ.

Энд нэг ийм хууль зүйн техник мэддэг мэддэггүй тухай биш. Энэ хууль хүчингүй болчихсон хуулиудыг буцааж хэрэглэдэг зөндөө кэйс бий. Оюу Толгойн гэрээгээ хар. Ашигт малтмалын хүчингүй болчихсон хуулийг бид энэ гэрээн дээр угаасаа явдаг.

Энэ хуулиудыг хүчингүй болсон эсэхээс хамаарч хувийн эрх зүйн гэрээнүүд хүртэл явж байдаг байхгүй юу.

Тэгэхээр бид хэд энэ дээр бас иргэддээ зөв мэдээлэл өгмөөр байна. Тэгээд ийм хууль зүйн техник байдаггүй энэ тэр гээд одоо ингээд ойлголтууд явчихаар энэ Монгол Улсад чинь хууль ёсонд хэн итгэх юм бэ. Төртэй байгуулж ирсэн гэрээнүүдийг хууль өөрчлөлтөөр бүгдийг нь цуцлах ёстой байдаг юм бол, бүгдийг нь эсвэл зогсоох ёстой байдаг юм бол ер нь хэн манайд хөрөнгө оруулалт хийх юм.

Тэгэхээр Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөхүүд бас ажлаа хийнэ ээ. Би яах вэ ганцхан жишээг л хэллээ. Үүнээс олон жишээнүүд байхыг бас үгүйсгэхгүй байгаа.

Тэгэхээр энэ дээрээ бас анхаараач ээ.

Хоёрдугаарт, тэр хоёр удаа зарлаад орж ирээгүй бол дараагийн компани гэдэг бол нийслэл дээр зовлон байдаг юм. Нэг жижиг шугам солих гэхээр орж ирдэггүй юм. Зарлаад л байна. Тэгтэл тэр нь өвөл яг задрахыг бас үгүйсгэхгүй.

Ингээд нөхцөл байдлууд зүгээр хэцүү байдаг. Энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар нэг ч гэрээ байгуулаагүй байгаа.

Бүх тоглоомын талбай барья гээд жижигхэн төр, хувийн хэвшлийн түншлэлийг шийдье гэсэн ч заавал Улсын Их Хурлаар.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Гишүүд үг хэлж дууслаа.

Би хуулийн төсөлтэй холбогдуулаад бас нэг тодорхой санал хэлье гэж бодож байна.

Энэ гишүүдийн яриад байгаа асуудлууд дээр анхаарахгүй бол бас болохгүй зүйлүүд нэлээн байна.

Худалдан авалт дээр ч гэсэн амьдралд нийцэхгүй зүйлүүд байдаг. Тухайлах юм бол одоо энэ “Сэлбэ сэргэлт” гээд. Улаанбаатар чинь босоо тэнхлэг ерөөсөө Чингэлтэй рүү явдаг нэг л замтай шүү дээ.

Гэтэл Сэлбийг дагуулаад хоёр дахь босоо тэнхлэгийн замыг хийгээд ингээд зураг төсөв бүх юм хийгдсэн. Юун дээр ирээд гацсан. Тендер.

Тендерийн гацалт нь явсаар байгаад төсвийн гацалт болоод, ингээд энэ том төсөл зогссон. Сэлбэ нь эргээд халиад үерт автаад л ингээд байдаг. Гэтэл энэ төсөл хэрэгжээгүй.

Тэгээд би бас энэ Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийг явахад бас нэг хэлж байсан зүйл байгаа юм. Ажлын хэсэг дээр сайн ярина.

Хэт өндөр үнэтэй. Одоо жишээлбэл ТЭЦ-п хэрэглэгдэж байгаа, эсвэл 110, 220 киловольтын дэд станцууд хэрэглэж байгаа трансформаторууд, мөн Эрдэнэт, МИАТ гэдэг ч юм уу одоо ингээд маш үнэтэй юм хэрэглэж байгаа газрууд дээр тендер зарлаад, тэгээд нэг цүнхний компани орж ирээд авчихдаг тохиолдлууд байдаг юм.

Хэзээ ч одоо жишээлбэл тэр тоног төхөөрөмж нь одоо ажиллах чадваргүй болдог юм уу, аль эсвэл доголдол гараад, гэмтэл гараад гэдэг юм уу тэгэхэд буцааж

төлөх чадваргүй компаниуд ороод авчихсан байдаг.

Эрдэнэтийн 220-ийн дэд станц дээр ийм л юм болсон. Нэг компани ороод авсан. Шалгарсан. Трансформатор нь явцдаа ашиглалтгүй болсон. Тэр компани төлж чадахгүй. Жил хүлээсэн. Тэгээд одоо яаж ч чадахгүй болохоор нь Эрдэнэттэй ярьж байгаад төр л тэрийг худалдаж авч байгаа.

Станцын турбин генераторууд гэдэг юм уу, аль эсвэл станцын нэг үнэтэй тоног төхөөрөмж солих боллоо гэхэд компани оруулж өрсөлдөж байгаа шүү дээ. Тэгэхдээ тэр компани хэзээ ч тэрийг гэмтэл гарсны дараа буцааж төлж чадахгүй.

Тэгэхээр гэх мэтийн. Одоо ТЭЦ-IV дээр “гардер” байж байгаа. Одоо болтол ашиглалтад ороогүй. Нөгөө компани буцааж хэзээ ч тэрийг төлж чадахгүй.

Тэгээд ингээд яваад байх юм уу гэх мэтийн асуудлууд байгаа.

Нэг талаасаа ингээд хулгай хийх гэж байна гэдэг ч юм уу, ийм хардалт бас төрөх юмнууд бий. Гэхдээ ажил явахгүй юм уу, аль эсвэл санхүүгийн хувьд боломжгүй компаниуд орж ирээд ингээд ажил аваад сүйрүүлээд, завхруулаад ингээд байгаа юмнууд энэ тэрийг хэдүүлээ тендерийн хуулиар зохицуулах шаардлага бол байна уу гэвэл байна.

Хууль эрх зүйн талаасаа маргаантай зүйлүүд нэлээд байгаад байгаа юм. Жишээлбэл, Төсвийн тухай хуулийн цаглаврын асуудал.

Дэгийн тухай хуулиараа бид 10 сарын 01-нээс хэлэлцэж эхлэх ёстой.

Гэтэл амжихгүй болчих гээд байгаа байхгүй юу. Одоогийн энэ өргөн барьсан Засгийн газраас оруулж ирсэн хуулиар.

Тэгээд үүнийг хэдүүлээ бас ярина.

Тэр Концессын хууль хүчингүй болчихсон байхад тэрний дагуу гэрээ байгуулна гэдэг чинь зөрчилтэй. Мөн саяын Тогтвортой байдлын хуультай холбогдолтой асуудлууд. Тэр 6.4 гэдэг ч юм уу. Тийм ээ. 19.9-өөрөө байж байна.

Энэ бүгд дээр дүгнэлт гаргахгүй бол болохгүй байх гэж ингэж бодож байгаа юм.

Тийм учраас төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн тодотголыг дагаж өргөн барьсан бүх хуулиуд дээр хуулийн дүгнэлт, эрх зүйн дүгнэлт гаргуулаад явъя гэсэн ийм бодолтой байна.

Тэгээд мөн ажлын хэсэг дээр бас тийм байгаа. Дэгийн тухай хуулийн 34.1-д заасны дагуу Байнгын хороо санал гаргаад ингээд эрх зүйн дүгнэлт гаргуулах ёстой.

Тэгэхээр энэ асуудлуудыг хийгээд явах нь хэрэгтэй юм гэж. Тухайлах юм бол одоо Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг бид өнгөрсөн 6 сард баталсан.

2025 оны 6 сараас дагаж мөрдөх ёстой. Гэтэл одоогийн өргөн барьж байгаа энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар үүнийхээ дагаж мөрдөх хугацааг наашлуулах юм шиг ийм хууль ороод ирж байгаа юм. Гэх мэтийн ийм зүйлүүд байгаа учраас бид энэ дагаж өргөн мэдүүлсэн хуулиуд дээр эрх зүйн дүгнэлт гаргуулах шаардлага бол байна гэж ингэж бодож байна.

Ингээд гишүүд орж ирье. Ирцээ бүрдүүлье. Санал хураалтууд явуулна. Сая миний хэлсэн дагасан хуулиудын эрх зүйн дүгнэлт гаргах асуудал дээр бас гишүүдийн саналаар дэмжих эсэхийг шийдэх ёстой. Санал хураалт явуулах ёстой юм байна.

Гишүүд орж ирье. Төсвийн байнгын хорооны гишүүд хуралдаа орж ирье. Одоо 15 санал хураалт явагдана. Хууль бүрээр явагдана. Ирцээ бүрдүүлье.

Тамгын газрынхан ирцээ бүрдүүлье.

Яах вэ, санал хураалт дээр асуулт гарах юм бол бас хариулна шүү дээ. Дуудчих. 4 гишүүнийг дуудчих. Санал хураалтад бэлтгэе.

Гарах болоогүй байна шүү дээ. 11 байгаа болчихоор л юм байна шүү дээ. 17-гоос 11-ээр. Аан.

Л.Гантөмөр гишүүн ээ, үүнийг хураасны дараа Та нар нэг горимын санал гаргахаар байгаа. Тийм үү? Нөгөө Зарлагын хяналтын дэд хороон дарга горимын санал байгаа юу? Дараа нь.

Одоо энэ хэлэлцэж байгаа асуудлынхаа дагуу санал хураалтыг явуулахад бэлтгэе.

11 хүн байна уу? 11 хүн байгаа. Юу ч гэсэн ингэе. Нэг туршилтын санал хураалт явуулаадахъя. Дэмжье гэснээр. Туршилтын санал хураалт. /алх цохив/

Цуцалъя. Техник бэлтгэгдээгүй байна. Цуцалъя. Дахиад. Хөөш. Энэ одоо агаад ингээд байна аа.

Ингэе. Дахиад туршилтын санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүнийхийг тэгвэл протоколоор л явчихъя тэгэх үү. Яагаад гэвэл хурууны хээ нь танигдахгүй байгаа юм байна шүү. Хурууны хээ нь танигдахгүй байгаад байгаа юм байна.

Тэгэхээр Ж.Батжаргал гишүүн бол Та байна шүү дээ, санал хураалтын дараа микрофонд үгээ хэлээд протоколд тэмдэглүүлээд дэмжсэн санал оруулаад юм уу, эсрэг саналд юм уу, тэрийгээ хэлээд явчихъя. Тэгэх үү.

Гишүүд ээ, сая хэд байсан бэ? Сая туршилтынх байсан.

Эхний нэг санал хураалтыг яваад үзье.

Хууль зүйн дүгнэлт гаргах тухай Байнгын хорооны санал. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл, Тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд.

Үүнийг байна шүү, Төсвийн хүрээний мэдэгдлийг ер нь дагаж өргөн мэдүүлсэн хуулиуд гээд явчихъя. За юу.

Тэгээд мөн 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд Монгол Улсын Их

Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 34.1-д заасан үндэслэлээр хууль зүйн дүгнэлт гаргуулах санал гаргаж байна.

Хууль зүйн дүгнэлт гаргуулах саналыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Түрүүний нөгөө хуулийн зөрчлүүдийг Тамгын газрын хуулийн шинжээчийн дүгнэлтийг гаргуулж ингээд янзлаад явъя.

Дэмжье гэдэг. Аан..? Асуулт байна. Асуулт байгаа юм байна. Б.Чойжилсүрэн гишүүний микрофоныг өгье. Б.Чойжилсүрэн гишүүний микрофон.

**Б.Чойжилсүрэн:** Гишүүдийнхээ амрыг эрье.

Энэ чинь нийлээд бараг 17, 20-иод хууль болно. Тийм ээ. Төсвийн хүрээ, төсөв дагасан хоёр нийлээд.

Тэгэхээр яг хууль зүйн дүгнэлт гаргахад ямар хугацаа шаардагдах бол. Яг Тамгын газарт ийм олон хууль дээр зэрэг дүгнэлт гаргаж байсан.../минут дуусав/

**Ц.Даваасүрэн:** Яаралтай горимоор өргөн барьсан учраас Дэгийн тухай хуулийн нөгөө нэг 10-аас 15 өдөр гэдгээ барихгүйгээр шийдэж болно.

Тэгэхдээ манай Хуулийн хэлтсийнхнээс байна уу? Энэ дээр тодорхой хугацаа хэлэх.

Яагаад гэвэл хуулийн зөрчилтэй байгаа учраас дүгнэлт гаргахгүйгээр гишүүд түрүүнийх шиг ярьж байгаад шийдчихэж болохгүй болчихоод байна л даа.

Г.Агар-Эрдэнэ дарга тайлбар өгчихье.

**Г.Агар-Эрдэнэ:** Ц.Даваасүрэн даргын асуултад хариулъя.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34.2 дахь хэсэгт Тамгын газрын хуулийн асуудал хариуцсан нэгж хууль зүйн дүгнэлтийг ажлын 10-аас 15 өдрийн дотор гаргана гэсэн ийм хуулийн заалттай байгаа.

Гэхдээ Улсын Их Хурлын даргын ээлжит бус чуулган товлон зарлах тухай захирамжид зааснаар ээлжит бус чуулган тодорхой хугацаанд хуралдахаар байгаа.

Тийм учраас Төсвийн байнгын хороо одоо шаардлагатай гэж үзэх юм бол Тамгын газар бас энэ хугацаанд нийцүүлэн дүгнэлтээ гаргах боломжтой гэж харж байгаа.

**Ц.Даваасүрэн:** Тэгэхээр яаралтай горимоор.

Ямар ч гэсэн саяын захирамжаар баталсан хугацаанд багтаана гэсэн үг байхгүй юу.

Тэгэхээр нойр хоолгүй зүтгэж байгаад л.

Тэгэхдээ энэ чинь 4, 5 л хууль байх шиг байна лээ. Бүгд биш ээ. Саяын тэр Концессын тухай хууль, Тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль гэсэн ийм нэг.

Мөн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжих хугацаа гэсэн 4 гол хууль дээр л байгаа юм.

Гишүүд ээ, хууль зүйн дүгнэлт гаргах асуудлыг дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү. /алх цохив/

10 гишүүн дэмжсэн байна.

Дээр нь Ж.Батжаргал гишүүн дэмжсэн учраас 11 гишүүн дэмжсэн.

18-аас 11 гишүүн дэмжсэн учир энэ санал дэмжигдлээ.

Одоо ингээд хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлж дууссан учраас үндсэн хууль болон дагаж өргөн мэдүүлсэн хууль нэг бүрээр хэлэлцэх эсэхийг дэмжих саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд анхааралтай байгаарай.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Цуцалъя. Техникийн алдаа гараад байна. Цуцалъя. Дахиад явуулъя.

Төхөөрөмж ажиллахгүй байгаад байна. Энэ цуцалсан шүү. Гар өргөхөөр маргалдаад байгаа юм.

Гишүүд ээ. Саяын санал хураалтыг анхааралтай хэдүүлээ.

Саяын санал хураалтыг. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэдгийг дахин санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүнийг нэмлээ ч тэнцэж байна.

Горимын санал гаргах хүн байна уу? Саяын кнопын эсрэг гарсан улсуудаас горимын санал гаргая. Зааланд байгаагаас эсрэг гарсан хүн байна уу?

Б.Түвшингийн эсрэг гарчихсан байна шүү дээ. Б.Түвшин санал гаргая. Тийм. Б.Түвшин.

**Б.Түвшин:** Тэгвэл горимын санал гаргаад саяын хуулийг саяын дагуу нөгөө санал өгсөн, эсрэг гарчихсан.

**Ц.Даваасүрэн:** Дэмжсэн санал өгсөн байсан байна. Тийм үү?

**Б.Түвшин:** Дэмжсэн санал өгсөн.

**Ц.Даваасүрэн:** Эсрэг гарчихсан.

Б.Түвшин гишүүний саналаар саяын саналыг хүчингүй болгоё гэдэг санал хураалт явуулъя.

Ж.Батжаргал гишүүнтэй 18-аас 11 гишүүн хүчингүй болгохыг дэмжсэн тул санал хураалтыг дахин явуулъя.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэдэг саналын томъёоллоор дахин санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн ороод 18-аас 11 гишүүн дэмжсэн байна.

Энэ хуулийн төсөл хэлэлцэх нь дэмжигдлээ.

Хоёр дахь хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Ж.Батжаргал гишүүн ороод 18-аас 10 гишүүн дэмжсэн тул энэ хууль хэлэлцэх нь дэмжигдлээ.

Тэгэхдээ дэмжигдчихсэн юм чинь Б.Чойжилсүрэн гишүүнийх бас нэмэгдэх ёстой юм байна. Тийм үү? Тэгвэл 18-аас 11 гишүүн дэмжсэн байна.

Гурав дахь санал хураалт. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Б.Чойжилсүрэн гишүүний микрофоныг өгье.

Дараа нь Ж.Батжаргал гишүүн ч гэсэн. Орчихсон байна уу? Тэгвэл хүрэхгүй болчихоод байна шүү дээ. Саяын санал дэмжигдсэнгүй.

Б.Түвшин гишүүн дэмжихгүй байгаа юм уу? Тэгэхээр явахгүй болчихоод байна л даа.

Б.Түвшин гишүүн горимын санал гаргая.

**Б.Түвшин:** Хэлэлцэх эсэх асуудал байгаа учраас ер нь горимын хувьд санал зөрсөн. Хэлэлцэхэд дэмжиж байгаа учраас саяын санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү.

**Ц.Даваасүрэн:** Б.Түвшин гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн орсноор 18-аас 10-д. Мөн Дав.Цогтбаатар гишүүнтэй 11. Тийм үү? 11 гишүүн. 18-аас 11 гишүүн дэмжсэн учраас хүчингүйд тооцё.

Ингээд саяын гурав дахь үндсэн саналыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэдэг саналын томъёоллоор дахин санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн орсноор 18-аас 12 гишүүн дэмжсэн тул энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжлээ.

Дөрөв дэх санал хураалт. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн орсноор 18-аас 11. Олонхын саналаар дэмжигдсэн байна.

Энэ асуудал хэлэлцэх нь дэмжигдлээ.

Тав дахь асуудал. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай

хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн орсноор 18-аас 12 гишүүн дэмжсэн тул энэ хуулийн төсөл хэлэлцэх нь дэмжигдлээ.

Зургаа дахь санал. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн орсноор 18-аас 11 гишүүн хэлэлцэхийг дэмжсэн тул энэ хуулийн төсөл хэлэлцэх нь дэмжигдлээ.

Долоо дахь санал. Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн орсноор 18-аас 11 гишүүн. Олонх дэмжсэн тул энэ хууль. Мөн Б.Чойжилсүрэн гишүүн дэмжсэн байна.

Ингээд 18-аас 12 гишүүн дэмжсэн тул хэлэлцэх нь дэмжигдлээ.

Найм дахь санал. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг

дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн орсноор 18-аас 12 гишүүн дэмжсэн тул хуулийн төслийг хэлэлцэхийг олонх нь дэмжсэн байна.

Ес дэх санал хураалт. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн орсноор 18 тиймээс 12 гишүүн хэлэлцэхийг дэмжсэн тул хуулийн төсөл хэлэлцэх нь дэмжигдлээ.

Арав дахь санал хураалт. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Дэмжсэн. Б.Чойжилсүрэн гишүүний микрофоныг өгье.

**Б.Чойжилсүрэн:** Санал хураалтын төхөөрөмж гацаад байх шиг байна. Би дэмжиж санал өгсөн чинь татгалзсан гэсэн.

**Ц.Даваасүрэн:** Тэгвэл Ж.Батжаргал, Б.Чойжилсүрэн гишүүнээр орсноор 18-аас 11 гишүүн дэмжсэн тул энэ хуулийн төсөл олонхын дэмжлэг авч хэлэлцэх нь дэмжигдлээ.

Арван нэг дэх санал. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Ж.Батжаргал гишүүн орсноор 18-аас 11 гишүүн дэмжсэн тул хуулийн төсөл хэлэлцэх нь дэмжигдлээ.

Арван хоёр дахь хуулийн төслийн санал. Засгийн газар дахь Хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн орсноор 18-аас 12 гишүүн дэмжсэн тул хуулийн төсөл хэлэлцэх нь дэмжигдлээ.

Арван гурав дэх санал. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн орсноороо 18-аас 11 гишүүн дэмжсэн тул хуулийн төсөл хэлэлцэх нь дэмжигдлээ.

Арван дөрөв дэх санал. Төрийн өмчийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Б.Чойжилсүрэн гишүүн, Ж.Батжаргал гишүүн дэмжсэн санал өгсөн байна. 18 гишүүнээс 11 гишүүн дэмжсэн тул хуулийн төсөл хэлэлцэх нь дэмжигдлээ.



Арван тав дахь санал. “Төрийн захиргааны байгууллын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Дав.Цогтбаатар гишүүн дэмжсэн саналыг микрофондоо хэлчих. Дав.Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

**Дав.Цогтбаатар:** Миний энэ төхөөрөмж. Дэмжсэн санал өгч байна.

**Ц.Даваасүрэн:** Дав.Цогтбаатар гишүүн Ж.Батжаргал гишүүн нарын дэмжсэн санал өгснөөр тооцоод 18-аас 12

гишүүн хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжсэн тул хуулийн төсөл дэмжигдлээ.

2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, түүнийг дагаж өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэж холбогдох санал хураалтыг явуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийг хэлэлцэх асуудлын талаар Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Ж.Батжаргал гишүүн танилцуулчих уу? Аан. Ж.Батжаргал гишүүн танилцуулчихъя. /алх цохив/

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуульд хамт өргөн болон эдгээр хуулиудыг дагаж хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, тогтоолуудыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

---

### Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай, үргэлжлэл/

---

Горимын саналтай байна гэсэн. Горимын санал. Дав.Цогтбаатар гишүүн горимын санал гаргая.

Байж байгаарай. Санал хураалт байгаа шүү.

**Дав.Цогтбаатар:** Үүний өмнөх асуудал. Зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох асуудал дээр миний бие Б.Түвшин гишүүнийг дэмжиж санал өгөхөөр байсан.

Тэгээд зайлшгүй ажлын улмаас гарах хооронд санал хураалт явчхаж.

Тэгээд энэ санал хураалтыг дахиж явуулах ийм санал гаргаж байна.

**Ц.Даваасүрэн:** Энэ санал хураалт. Түрүүний санал хураалтыг хүчингүй болгоод уу?

**Дав.Цогтбаатар:** Тийм.

**Ц.Даваасүрэн:** Б.Түвшинг..?

**Дав.Цогтбаатар:** Тийм.

**Ц.Даваасүрэн:** Энэ болох уу?

**Дав.Цогтбаатар:** Горимын санал.

**Ц.Даваасүрэн:** Хүчингүй болгох горимын санал нь уначихсан юм байна.

**Дав.Цогтбаатар:** Хүчингүй болгох санал гаргасан юм уу?

**Ц.Даваасүрэн:** Тийм. Тэр уначихсан юм байна. Дахиж ч одоо болохгүй л болчихоод байна л даа.

Гурав дахь хүнээ дэвшүүлээд явбал яадаг юм.

**Дав.Цогтбаатар:** Эхлээд энэ хоёр дахь асуудлаа шийдчихье л гэж би санал гаргаад байна.

Хүчингүй болгоход горимын санал гаргаад тэр нь дэмжигдээгүй л юм байна л даа.

**Дав.Цогтбаатар:** Гаргаад одоо дахиад хэлэлцээд нэг эцэслэчихвэл яадаг юм.

Ирцдээ орчихсон байсан. Би өглөө. Тийм.

**Ц.Даваасүрэн:** Гарчихсан байхгүй юу. Ж.Батжаргал гишүүн ээ.

Энэ хүний санал эсрэгээр гарчихсан байхгүй юу. Яагаад гэвэл бүртгүүлчихсэн байсан учраас.

**Дав.Цогтбаатар:** Тэгэхээр энэ Б.Түвшин гишүүн дээр би дахиж санал хураалгах.

Тэгээд өглөөнийхийг хүчингүй болгуулаад, одоо дахиж санал хураалгах горимын санал гаргаж байна.

**Ц.Даваасүрэн:** Байнгын хорооны гишүүд байж байгаарай.

Энэ асуудлыг шийдэхгүй бол нөгөө төсвийн чинь хэлэлцүүлэг явахгүй болчих гээд байгаа байхгүй юу. Одоо чуулган хуралдана.

Чуулганы хуралдааны дараа Зарлагын хяналтын дэд хороо ажлын хэсэг хоёр хуралдах ёстой байхгүй юу. Гэтэл байхгүй.

Гишүүд байж байгаарай. Байнгын хорооны гишүүд байж байна шүү. Хэдүүлээ энэ асуудлыг шийдэхгүй бол төсвийн хэлэлцүүлэг явах боломжгүй болчихоод байна.

Саяынх дээр манай хуулийнхан хэлээдэх дээ. Би дахиад хүчингүй болгох санал хураалт явуулж болж байна уу?

**Дав.Цогтбаатар** гишүүний гаргасан саналаар түрүүний нөгөө хүчингүй болсон саналыг дахиад хүчингүй болгох санал хураалт явуулах гэж байна.

Болох юм байна. Тэгвэл **Дав.Цогтбаатар** гишүүний гаргасан горимын саналын дагуу түрүүн өмнө дэмжигдээгүй саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья. Гишүүд анхааралтай байгаарай.

Одоо энэ чинь ёстой анхааралтай байхгүй болбол Зарлагын хяналтын дэд хороон дээр бид үүнээс болоод чуулган хугацаандаа хуралдаж амжихгүй нөхцөл байдал үүсээд байна.

Үдээс хойш Зарлагын хяналтын дэд хороо, ажлын хэсэг хуралдах ёстой. Тийм. Нөгөө нэг дэмжигдээгүй саналыг хүчингүй болгоё гэж байгаа юм.

Ж.Батжаргал гишүүнийг оруулаад 18-аас 10 гишүүн хүчингүй болгохыг дэмжсэн байна. Энэ санал хүчингүй боллоо. /алх цохив/

Тэгвэл санал хураалтыг дахин явуулна. Нөгөө томьёолол хаана байна.

Зарлагын хяналтын дэд хорооны даргаар Банзрагчийн Түвшинг сонгох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн орсноороо 18-аас 8 гишүүн дэмжээд энэ санал дахиад уначихлаа шүү дээ.

Б.Чойжилсүрэн гишүүн дэмжсэн юм байна.

Тэгэхээр 9. Тэгэхдээ 50, 50 хувиар болж байгаа учраас уначаж байгаа байхгүй юу.

Одоо ганцхан л хүн үлдсэн. Тэр хүнээ дэвшүүлээд нэг үзвэл үз.

Батын Батболд билүү? Батбаяр билүү? Аан. Далайн Батбаяр гишүүн ээ, яах юм? Хэрвээ горимын санал гаргаад.

Үгүй ээ үгүй. Дэмжигдвэл дэмжигдэхээр л байгаа байхгүй юу. Тэгээд нэг, хоёр нь яачхаад байх юм байна шүү дээ.

Яах вэ, нөхцөл байдал яагаад байна вэ гэвэл одоо ингээд чуулган эхний хэлэлцүүлэг саяын хуулиудаар хийсний дараа Зарлагын хяналтын дэд хороо,

ажлын хэсэг өнөөдөр хуралдаж дүгнэлтээ гаргах юм билээ л дээ.

Тэгээд нөгөө хугацаагүй болчхоод байгаа байхгүй юу.

Хэрвээ энэ хугацаа ингээд Зарлагын хяналтын дэд хорооны даргаас болоод хойшлогдоод явбал товлосон хугацаандаа энэ хуулийн төслүүдийг хэлэлцэж амжихгүй нөхцөл байдал үүсэхээр байна.

Ирц бол болсон байна. Б.Заяабал гишүүнийг дуудъя. Манайхан Б.Заяабал гишүүнийг дуудчих. Тэгээд санал хураалт явуулаад нэг тийш нь шийдье.

Зарлагын хяналтын дэд хорооны даргын асуудлыг дахиад үргэлжлүүлнэ.

Б.Түвшин гишүүн дээр санал унасан учраас Ардчилсан намын бүлгээс дахиад Төсвийн зарлагын хяналтын хорооны дэд даргаар Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаярыг томилуулах саналыг оруулж байгаа юм байна.

Ингээд Зарлагын хяналтын дэд хорооны даргаар Далайн Батбаярыг дэмжих асуудлыг хэлэлцэнэ.

Төсвийн зарлагын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаярыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн микрофондоо хэлчихье. Энэ удаа хүний томилгоо явж байгаа учраас. Ж.Батжаргал гишүүний микрофоныг өгье.

**Ж.Батжаргал:** Саяын санал хураалтад дэмжиж санал өгсөн. Уншигдсангүй.

Тийм учраас тэгвэл намайг дэмжиж санал өгснөөр бүртгэх.

**Ц.Даваасүрэн:** Тэгвэл Ж.Батжаргал гишүүний дэмжсэн санал өгснөөр тооцоод 18-аас 12 гишүүн дэмжсэн тул Зарлагын хяналтын дэд хороон даргаар Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярыг томилох санал дэмжигдсэн байна.

Д.Батбаяр гишүүнд амжилт хүсье.

Өнөөдрийн Төсвийн байнгын хорооны хуралдаан үүгээр өндөрлөж байна. Баярлалаа гишүүддээ.

Тогтоол уншиж батлуулах юм байна. Тогтоолын төслийг батлах юм байна. Байнгын хорооны тогтоол.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

2024 оны 8 дугаар сарын 19-ний өдөр. “Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Төсвийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаярыг сонгосугай.

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн гэсэн байна.

Тогтоолын төслийг баталъя гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн дэмжсэн санал өгсөн байна. 18-аас 11 гишүүн дэмжсэн тул тогтоолын төсөл батлагдлаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дууслаа. Гишүүддээ баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 3 цаг 39 минут үргэлжилж, 14 цаг 45 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**